



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА 2026 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-25
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	26-107
<hr/>	
1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	27-51
2.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 2 гишүүн 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	51-86
Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.	86-102
Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжлэв.	102
4.“Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	102-104
5..Зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай	104-107

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
4 дүгээр сарын 23-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 65 гишүүн хүрэлцэн ирж, 51.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Алдаржавхлан, Т.Аубакир, Н.Батсүмбэрэл, Х.Баттулга, Б.Батцэцэг, Б.Бейсен, Ж.Галбадрах, Г.Дамдинням, Т.Доржханд, Х.Жангабыл, С.Замира, З.Мэндсайхан, Н.Наранбаатар, У.Отгонбаяр, Ц.Сандаг-Очир, Р.Сэддорж, Д.Үүрийнтуяа, Б.Хэрлэн, Ж.Энхбаяр;

Чөлөөтэй: П.Батчимэг, Ж.Баярмаа, Ж.Баясгалан, Т.Мөнхсайхан, Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Х.Болормаа, А.Ганбаатар, М.Сарнай, Б.Чойжилсүрэн, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: С.Ганбаатар, П.Мөнхтулга;

Хоцорсон: Д.Амарбаясгалан-33 минут, С.Амарсайхан-1 цаг 56 минут, Ц.Баатархүү-12 минут, Э.Батшугар-07 минут, Э.Болормаа-16 минут, Х.Булгантуяа-03 минут, Д.Ганбат-05 минут, Д.Ганмаа-3 цаг 33 минут, Л.Гантөмөр-10 минут, Б.Дэлгэрсайхан-36 минут, Б.Жавхлан-3 цаг 45 минут, Б.Жаргалан-25 минут, Д.Жаргалсайхан-50 минут, Ж.Золжаргал-37 минут, С.Зулпхар-02 минут, Ц.Идэрбат-02 минут, М.Мандхай-07 минут, П.Наранбаяр-03 минут, М.Нарантуяа-Нара-09 минут, Ч.Номин-02 минут, Л.Оюун-Эрдэнэ-3 цаг 51 минут, Ц.Туваан-4 цаг 23 минут, Б.Түвшин-27 минут, А.Ундраа-09 минут, Ч.Ундрам-13 минут, Б.Уянга-01 минут, Г.Уянгахишиг-17 минут, Д.Цогтбаатар-2 цаг 05 минут, Ж.Чинбүрэн-03 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 4 дүгээр сарын 19-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, 4 дүгээр сарын 21-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 18 гишүүнээс 2026.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Хууль зүйн байнгын хороодод;

Монгол Улсын Засгийн газраас 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очироос 2026.04.21-ний өдөр өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав./10:05/

Нэг.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч С.Жаргалсайхан, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга Б.Алтантулга, мөн албаны зөвлөх П.Батчулуун, Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн Ясны чөмөг шилжүүлэн суулгах багийн ахлагч Н.Оюундэлгэр, С.Мядагсүрэн, “Өөжинмед” үр шилжүүлэн суулгах төвийн эмч Г.Гэрэлцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Б.Энхмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Энхтүвшин, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, Н.Алтаншагай, О.Батнайрамдал, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Б.Батбаатар, М.Мандхай, С.Одонтуяа нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга Б.Алтантулга, мөн албаны зөвлөх П.Батчулуун, Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн Ясны чөмөг шилжүүлэн суулгах багийн ахлагч С.Мядагсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор явуулах санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 14.00 цагт явуулахаар хойшлуулав./11:30/

Хоёр.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 2 гишүүн 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар, мөн танхимын

Ерөнхийлөгчийн зөвлөх М.Сарандаваа, Гадаад худалдааны бичиг баримт баталгаажуулах газрын дарга Э.Бадамхорол, танхимын дэргэдэх Хууль зүйн бодлогын зөвлөлийн дарга Ө.Жамбалсүрэн, гишүүн Б.Эрхбаяр, Өмгөөллийн Хэруга Партнерс хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Л.Загдаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, М.Ганхүлэг, Ө.Шижир, О.Саранчулуун, Б.Пунсалмаа, Л.Соронзонболд, Х.Баасанжаргал, Б.Батбаатар, Б.Уянга, М.Мандхай, Б.Жаргалан нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Х.Ганхуяг, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар, мөн танхимын Ерөнхийлөгчийн зөвлөх М.Сарандаваа, Гадаад худалдааны бичиг баримт баталгаажуулах газрын дарга Э.Бадамхорол, Өмгөөллийн Хэруга Партнерс хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Л.Загдаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 13 цаг 02 минутаас хуралдааныг даргалав.

Үдийн завсарлагын цаг болсон тул үдээс өмнөх хуралдаан 3 цаг 32 минут үргэлжилж, 13 цаг 32 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 06 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу түр хойшлуулав./14:08/

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Б.Энхмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 14 цаг 10 минутаас хуралдааныг даргалав.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Л.Энхнасан, Ж.Баясгалан, Х.Болормаа, Д.Рэгдэл, У.Отгонбаяр, М.Сарнай, С.Эрдэнэбат /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээг үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 41
Бүгд: 92
55.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 38
Бүгд: 92
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “эрхтэн, эд, эс” гэсний өмнөх “хүний” гэснийг хасаж, 4.1.2 дахь заалтын “бөгөөд гэрлэгчид, төрлийн хүн, садангийн хүн, хүргэн, бэр гэсэн дарааллаар сонгогдсон хүнийг” гэснийг “, хүргэн, бэрийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 36
Бүгд: 92
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.3.“амьгүй донор” гэж тархины үйл ажиллагаа бүрэн, эргэшгүй алдагдсан, тархины үхэл тодорхойлох мэргэшсэн багаар тархины үхэл нь тогтоогдсоны дараа үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгахаар авч болох донорыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан дэмжиж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 35
Бүгд: 92
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “болон” гэснийг “эсхүл” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтын “эсийг шилжүүлэн суулгах” гэсний өмнө “үүдэл” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.7.“реципиент эмнэлэг” гэж бүтцэд нь төрөлжсөн тасаг, мэргэжлийн багтай Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 36
Бүгд: 93
61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.8.“донор эмнэлэг” гэж амьгүй донорыг илрүүлэх, оношлох, эрхтэн хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 36
Бүгд: 93
61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.11.“био банк” гэж оношилгоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэх, хяналт хийх зорилгоор авсан эд, эсийг хадгалах тусгай зориулалтын санг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 39
Бүгд: 93
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 4.1.17 дахь заалтыг хасах:

“4.1.12.“эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ” гэж эмнэлгийн нөхцөлд донорыг илрүүлэх, эрхтэн, эд, эсийг авах, шинжлэх, хадгалах, тээвэрлэх, хуваарилах, шилжүүлэн суулгах болон мэс заслын дараах эмчилгээ, хяналт хийх эмнэлгийн тусламж, үйлчилгээг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 37
Бүгд: 93
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.17 дахь заалт нэмэх:

“4.1.17.“сорьц” гэж оношилгоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэх, хяналт хийх зорилгоор хүнээс авсан цус, эс, эд, эрхтний хэсгийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 37
Бүгд: 93
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.18 дахь заалт нэмэх:

“4.1.18.“хүйн эд” гэж нярайн хүй таслагдсаны дараа ихэстэй залгаа хэсгээс тайран авсан хүйн судсан багцыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 38
Бүгд: 93
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.19 дэх заалт нэмэх:

“4.1.19.“үндэсний хүлээх жагсаалт” гэж эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгуулах шаардлагатай иргэдийг эрхтэн, эд, эс, цусны бүлгээр ангилан, эмнэл зүйн үнэлгээ, шалгуур үзүүлэлтээр эрэмбэлэн бүртгэсэн жагсаалтыг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 35
Бүгд: 93
62.4 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “сайн дурын,” гэсний дараа “аливаа дарамт шахалт, бусдын нөлөөнд автахгүй” гэж нэмж, мөн зүйлийн 5.1.6 заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 37
Бүгд: 93
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хоёрдугаар бүлгийн гарчгийн “ДОНОРЫГ СОНГОХ” гэснийг “ДОНОРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 36
Бүгд: 93
61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “эрхтэн, эд, эс” гэсний өмнө “энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллагаас” гэж нэмж, мөн заалтын “холбогдох эрх бүхий эрүүл мэндийн байгууллагаас” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 37
Бүгд: 93
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “холбогдох журам, зааврын дагуу” гэснийг хасаж, мөн зүйлийн 6.1.3 дахь заалтын “, хүүхэд” гэснийг “гаргах бөгөөд, хүүхэд, эрх зүйн бүрэн чадамжгүй иргэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 35
Бүгд: 93
62.4 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Эрхтэн, эд” гэсний дараа “, эс” гэж нэмж, 6.2.1 дэх заалтын “тус улсад” гэснийг хасаж, мөн заалтын “гэрлэгчид дундаасаа” гэсний дараа “төрсөн” гэж, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын “гадаад улсын иргэн,” гэсний дараа “харьяалалгүй хүн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “яс үндэс, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, боловсрол харгалзахгүйгээр иргэн амьдралын чанараа сайжруулах, эрүүл мэндээ хамгаалуулах” гэснийг “үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол харгалзахгүйгээр хүн амьдралын чанараа сайжруулах, эрүүл мэндээ хамгаалах” гэж, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтын “хангах” гэснийг “сайжруулах” гэж өөрчилж, мөн заалтын “тусламж, үйлчилгээ” гэсний өмнө “эрүүл мэндийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 35
Бүгд: 93

62.4 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “гэрлэгчид дундаасаа” гэсний дараа “төрсөн” гэж нэмж, мөн зүйлийн 8.1.4 дэх заалтын “сайн дурын үндсэн дээр” гэснийг “сайн дураар” гэж өөрчилж, мөн заалтын “сэтгэцийн эмгэггүй” гэсний өмнө “хөгжлийн бэрхшээлгүй хүн болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 37
Бүгд: 93

60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “хүний эрүүл мэндийг хамгаалах, амьдралын чанарыг дээшлүүлэхэд зориулан эрхтэн, эд, эсээ өгөхдөө” гэснийг, мөн зүйлийн 8.1.6 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 35
Бүгд: 93

62.4 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.2.Эсийн донор нь дараах шаардлагыг хангасан байна:

8.2.1.эсийн донорт насны дээд, доод хязгаар заахгүй, хэрэв бэлгийн эсийн донор бол 18 насанд хүрсэн байна;

8.2.2.хүүхдээс ясны хэм, захын цус авахдаа 14 хүртэлх настай бол хүүхдийн хүсэл зоригийг хүндэтгэн эцэг, эх болон асран хамгаалагчийн, 14-өөс дээш настай бол өөрийнх нь болон эцэг, эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн зөвшөөрлийг бичгээр авна;

8.2.3.эсийн донор нь гэр бүлийн гишүүн эсхүл сайн дурын донор байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 32
Бүгд: 93
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.3 дахь хэсэг нэмэх:

“8.3.Хүүхдээс ясны хэм, хүйн цус, хүйн эд, захын цуснаас бусад эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах зориулалтаар авахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 35
Бүгд: 93
62.4 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын “яс үндэс, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ,” гэснийг “үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол,” гэж, мөн зүйлийн 9.1.2 дахь заалтын “үйлчилгээ, түүнтэй холбоотой бусад мэдээ” гэснийг “үйлчилгээний талаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 32
Бүгд: 93
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “амьдралын чанарыг хангах тасралтгүй тусламж үйлчилгээг” гэснийг “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанар,” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.1.4 дэх заалтын “мөрдөх” гэсний өмнө “дагаж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 34
Бүгд: 93
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын “хонжоо,” гэснийг “олох зорилгоор” гэж өөрчилж, “авах,” гэсний дараа “өгөхийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 32
Бүгд: 93
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.1.6, 9.1.7 дахь заалт тус тус нэмэх:

“9.1.6.эрхтэн, эд, эсээ бусдад шилжүүлэн суулгах явцад өөрийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байх эрхээр хангагдах;

9.1.7.эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний явцад технологийн заавар зөрчигдсөний улмаас донорын эрүүл мэндэд хохирол учруулсан нь тогтоогдсон бол эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгасан буруутай этгээд, байгууллагаар хохирлоо нөхөн төлүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 36

Бүгд: 93

61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн гарчгийн “донорт тавигдах шаардлага” гэснийг “донорыг ирүүлэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 10.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.Тархины үхэл тодорхойлох мэргэшсэн багаар тархины үхэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд амьгүй донороос эрхтэн, эд, эс авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 35

Бүгд: 93

62.4 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “, дүү” гэсний дараа “төрлийн хүн, садангийн хүн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 35

Бүгд: 93

62.4 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийн “Гадны нөлөөтэй” гэснийг “Гэмт хэргийн улмаас тархины үхэлтэй болох нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон” гэж, мөн хэсгийн “эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан” гэсний дараах “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн хэсгийн “хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын” гэсний дараах “гишүүд” гэснийг “гишүүн, Улсын Ерөнхий прокурор” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 36

Бүгд: 93

61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.6 дахь хэсэг нэмэх:

“10.6.Амьгүй донорт насны хязгаар заахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 37

Бүгд: 93

60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн гарчгийн “болохоо” гэснийг “болох хүсэлтээ” гэж өөрчилж, мөн зүйлийн 11.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.21 насанд хүрсэн Монгол Улсын иргэн энэ хуулийн 4.1.3-т заасан донор болох хүсэлтээ төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан гаргаж донорын цахим үнэмлэх, эсхүл Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад өөрийн биеэр хүсэлт гарган баталгаажуулж донорын үнэмлэх авч болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 34

Бүгд: 93

63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн дугаарыг “11.3” болгон өөрчилж, мөн хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.3.Татгалзах хүсэлтээ төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан, эсхүл Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад өөрийн биеэр хүсэлт гарган баталгаажуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 37

Бүгд: 93

60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн дугаарыг “11.2” болгон, мөн хэсгийн “гэрчилгээ” гэснийг “үнэмлэх” гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн “татгалзах эрхтэй.” гэсний өмнө “хугацаа хамаарахгүй” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 38

Бүгд: 93

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “8.1-д заасан шаардлага хангасан амьд донороос эрхтэн, эд, эсийг авна” гэснийг “8.1,

8.2-т заасан шаардлага хангасан байна” гэж, мөн зүйлийн 12.2 дахь хэсгийн “энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан донороос авах бөгөөд зөвшөөрснөөс бусад эрхтэн, эд, эсийг авахыг хориглоно” гэснийг “энэ хуулийн 10.2-т заасан зөвшөөрлийг авна. Зөвшөөрснөөс бусад эрхтэн, эд, эс авахыг хориглоно.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 37

Бүгд: 93

60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “тусламж, үйлчилгээг үзүүлнэ” гэснийг “үйл ажиллагааг зохион байгуулна” гэж өөрчилж, мөн зүйлийн 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрлийн дагуу энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллагын эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах мэргэжлийн баг эрхтэн, эд, эс авах эмнэлгийн тусламж, үйлчилгээг гүйцэтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 40

Бүгд: 93

57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн “донороос” гэснийг “донорыг бүртгэх,” гэж, мөн хэсгийн “эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан” гэсний дараах “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн “хадгалах,” гэсний дараа “хамгаалах,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 36

Бүгд: 93

61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн дугаарыг “12.3” болгож, мөн хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.3.Энэ хуулийн 11.1-д заасан амьгүй донороос эрхтэн, эд, эс авахдаа гэр бүлийн 3 хүртэл гишүүнд урьдчилан танилцуулах бөгөөд энэ хуулийн 10.2-т заасан зөвшөөрлийг авахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 36

Бүгд: 93

61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн гарчгийн “Эрхтэн, эд, эс шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах” гэснийг “Био банк

байгуулах, ашиглах үйл ажиллагаа” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь үндэсний хэмжээнд оношилгоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэх, хяналт хийх зориулалттай нэгдсэн био банктай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 35
Бүгд: 93
62.4 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 13.1-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэх” гэснийг “Био банк байгуулах, ашиглах” гэж, мөн хэсгийн “байгууллагын саналыг үндэслэн” гэсний өмнөх “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 41
Бүгд: 93
55.9 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.3, 13.4 дэх хэсэг нэмэх:

“13.3.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож байгаа эрүүл мэндийн байгууллага нь эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэх био банктай байж болно.

“13.4.Био банкиг эд, эсийг цуглуулах, шинжлэх, өсгөвөрлөх, боловсруулах, хадгалах, бүртгэх, тээвэрлэх, устгах, шаардлагатай үед эмчилгээ, судалгааны зорилгоор тохирох эд, эсээр реципиент эмнэлэг болон судалгаа, шинжилгээний байгууллагыг хангах зориулалтаар ашиглана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 36
Бүгд: 93
61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “шаардлага хангасан” гэснийг хасаж, мөн хэсгийн “импортолж болно” гэсний өмнө “энэ хуулийн 14.3-т заасан журамд заасны дагуу” гэж нэмж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “хариуцсан” гэснийг “эрхэлсэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 38
Бүгд: 93

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 15.2 дахь хэсгийг хасах:

“15.1.энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллага нь донор, реципиентийн эрхтэн, эд, эсийн тохироог үзэх, донороос авсан эрхтэн, эд, эсийг шинжлэх, боловсруулах, шилжүүлэн суулгах мэс засал, эмчилгээг гүйцэтгэх мэргэжлийн багтай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 37

Бүгд: 93

60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.5, 15.6 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 41

Бүгд: 93

55.9 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн “13.3-д” гэснийг “12.5-д” гэж, мөн зүйлийн 15.8 дахь хэсгийн “Донор бэлгийн эсийг” гэснийг “Бэлгийн эсийг” гэж, мөн хэсгийн “болох бөгөөд холбогдох журмыг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.” гэснийг “болно.” гэж, мөн зүйлийн 15.9 дэх хэсгийн “энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллага эрхэлнэ.” гэснийг “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.4-т заасан эрүүл мэндийн байгууллага гүйцэтгэж болно.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 39

Бүгд: 93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.10, 15.11 дэх хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“15.10.холбогдох эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр өөрөө жирэмслэх, ураг тээх, хүүхэд төрүүлэх чадваргүй нь тогтоогдсон эмэгтэйд тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болохыг зөвшөөрөх бөгөөд бусад тохиолдолд тээгч эх ашиглахыг хориглоно.

15.11.Бэлгийн эс ашиглах, үр хөврөлийг шилжүүлэн суулгах, тээгч эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ энэ хуулийн 12.5-д заасан журмыг баримтлах бөгөөд талуудын хооронд байгуулах гэрээний загварыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.13, 15.14 дэх хэсэг нэмэх:

“15.13.Нэг донорын бэлгийн эсийг зөвхөн нэг удаагийн амьд төрөлтөд ашиглахыг зөвшөөрнө.

15.14.Үр хөврөлийг эцэг, эхээс нь бусад хүмүүст ашиглахыг хориглоно.” гэсэн саналыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “байх бөгөөд мэдээллийн аюулгүй байдал технологийн нууцлал, найдвартай байдлыг хангасан” гэснийг хасаж, мөн хэсгийн “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн зүйлийн 16.2 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн” гэснийг “эрүүл мэндийн байгууллага” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 42
Бүгд: 93
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “шилжүүлэн суулгах” гэсний дараа “тусламж, үйлчилгээний” гэж, мөн заалтын “баримтлах бодлого,” гэсний дараа “төлөвлөлт, арга хэмжээ,” гэж тус тус нэмж, мөн заалтын “төрөөс” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 43
Бүгд: 93
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалтын “ажиллагааг зохион байгуулах,” гэснийг “ажиллагаа,” гэж өөрчилж, мөн зүйлийн 18.1.3, 18.1.6 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 39
Бүгд: 94
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг 19 дүгээр зүйлийн 19.3.4 дэх заалт болгон шилжүүлж, мөн заалтын “4.1.8-д заасан” гэсний өмнө “4.1.7,” гэж нэмж, мөн заалтын “механизм” гэснийг “систем” гэж өөрчилж, мөн заалтын “эмнэлгийн мэргэжилтнийг” гэсний өмнөх “эмч,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 40
Бүгд: 94
57.4 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.9 дэх заалтыг 19 дүгээр зүйлийн 19.3.5 дахь заалт болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.3.5.энэ хуулийн 4.1.7, 4.1.8-д заасан эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээг батлах, хэрэгжилтийг хянах, цуцлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 43
Бүгд: 94
54.3 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.10 дахь заалтыг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмэх:

“18.2.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын бүтэц, дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 39
Бүгд: 94
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.1 дэх хэсэг нэмэх:

“19.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан тусгай мэргэжлийн төв байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 32

Бүгд: 94
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн нэрийн “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн зүйлийн 19.1.2 дахь заалтын “12.5-д заасан журмыг дагаж мөрдөнө.” гэснийг “12.5, 13.2-т заасан журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавих.” гэж, мөн зүйлийн 19.1.3 дахь заалтын, мөн зүйлийн 19.4.4 дэх заалтын “эмчилгээ,” гэснийг “тусламж,” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 19.1.4, 19.2.3, 19.3.4, 19.3.5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 38
Бүгд: 94
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2.2 дахь заалтын “эмч эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, багийн чадавхийг дээшлүүлэх,” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 19.2.3 дахь хэсэг нэмэх:

“19.2.3.эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, багийн чадавхыг дээшлүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 37
Бүгд: 94
60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

57.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.3.1 дэх заалтын “Эрүүл мэндийн тухай хуулийн” гэсний дараах “15.1.4, 15.1.5,” гэснийг, мөн заалтын “15.1.13-т заасан” гэсний өмнөх “15.1.12,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 43
Бүгд: 94
54.3 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.4.1 дэх заалтын “донор эмнэлгийн,” гэснийг хасаж, мөн заалтын “ёс зүйн хороодтой” гэсний өмнө “мэргэжил,” гэж нэмж, мөн зүйлийн 19.4.2 дахь заалтын “Эрүүл мэндийн тухай хуулийн 26.5-д заасан ёс зүйн хороонд хүргүүлэх” гэснийг “шийдвэрлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 35
Бүгд: 94
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

59.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн

байгууллага нь эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн,” гэснийг, мөн хэсгийн “байгууллагын бүтцэд” гэсний өмнөх “байгууллага байх ба тус” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 35

Бүгд: 94

62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “4.1.6” гэснийг “4.1.7” гэж, мөн хэсгийн “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн хэсгийн “мэдээлнэ.” гэснийг “мэдээлж, улирал тутам тайлагнана.” гэж тус тус өөрчилж, “донорын талаарх мэдээллийг” гэсний өмнөх “амьд, амьгүй” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 35

Бүгд: 94

62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

61.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтын “хүндрэл, сөрөг нөлөөллөөс” гэснийг “эрсдэл, хүндрэлээс” гэж, мөн зүйлийн 20.2.2 дахь заалтын “энэ хуулийн 20-д” гэснийг “энэ хуулийн 19-д” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 20.3.6 дахь заалтын “эрчимт эмчилгээг” гэсний өмнө “амин чухал эрхтний үйл ажиллагааг дэмжин,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 20.3.8 дахь заалт тус тус нэмэх:

“20.3.8.хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 37

Бүгд: 94

60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

62.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэнд дараах үйл ажиллагааг хориглоно:

21.1.1.донор болон реципиент, тэдний гэр бүлийн гишүүн, тэдгээрийн хамаарал бүхий этгээдээс аливаа хэлбэрээр урамшуулал, шан харамж авах;

21.1.2.албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж, бусдад давуу байдал олгох;

21.1.3.Шинжлэх ухааны бус зорилгоор судалгаа, шинжилгээ, туршилт хийх;

21.1.4.хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 37

Бүгд: 94

60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

63.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22, 23 дугаар зүйлийг нэгтгэн 22 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22 дугаар зүйл. Амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмж болон амьд донорт үзүүлэх дэмжлэг

22.1.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг холбогдох сангаас олгоно.

22.2.Амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, рашаан сувилалд сувилуулах журмыг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

22.3.Хуульд заасан бусад.” гэсэн саналыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

64.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийг 23 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23 дугаар зүйл.Санхүүжилтийн тогтолцоо

23.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээтэй холбоотой санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, реципиентийн төлөх төлбөр, хандив, тусламж, дэмжлэг, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

23.2.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлж болно.

23.3.Энэ хуулийн 23.2-т заасан тусламж, үйлчилгээний жагсаалт, төлбөрийн жишиг хэмжээг Эрүүл мэндийн тухай хуулийн 24.3-т заасны дагуу тогтооно.

23.4.Дархлаа дарангуйлах эмийн эмчилгээний санхүүжилтийг улсын төсвөөс хариуцах бөгөөд худалдан авалт, тасралтгүй бэлэн байдал, хуваарилалт, хяналтын асуудлыг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар зохицуулна.

23.5.Хүүхдэд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний төлбөрийг Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.11-т заасны дагуу шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 39

Бүгд: 94
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

65.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 38
Бүгд: 94
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

66.Ажлын хэсгийн гаргасан, зарчмын зөрүүтэй 63 дугаар санал буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг холбогдох сангаас олгох санал дэмжигдсэнтэй холбогдуулан хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулах гэсэн саналыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Найруулгын санал:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.16 заалтын “аав, ээжийг” гэснийг “эцэг, эхийг” гэж, төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын “суулгах” гэснийг “суулгуулах” гэж, төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “доор дурдсан” гэснийг “дараах” гэж, төслийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “шаардлагад нийцсэн” гэснийг “шаардлага хангасан” гэж тус тус өөрчлөх;

2.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь заалтын “эрүүл мэндийн байгууллага” гэсний өмнөх “заасан” гэснийг, төслийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалтын “талаарх” гэснийг, мөн зүйлийн 19.4.4 дэх заалтын “ухуулан” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 34
Бүгд: 94
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн нэрийн “ЭРХТЭН, ЭД, ЭС” гэсний өмнө “ХҮНИЙ” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 34
Бүгд: 94
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дугаарыг “2” болгож, мөн заалтын 6.19 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 34
Бүгд: 94
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын дугаарыг “1” болгож, мөн заалтын 6.1.4 дэх заалтын “, холбогдох баримт бичиг” гэснийг “болон хоорондын байгуулсан гэрээ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 32
Бүгд: 94
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 31
Бүгд: 94
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж, төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл тус тус нэмж, төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгох:

“2 дугаар зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.18 дахь заалтын “Донорын тухай хуулийн 3.1.2-3.1.4-т” гэснийг “Хүний эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн 4.1.2, 4.1.3, 4.1.5-д” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 31
Бүгд: 94
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ажлын 5 өдөр буюу 2026.04.30-ны өдрийн өглөөний 10:00 цаг хүртэл завсарлага өгөв./15:17/

Гурав.“Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Бямбацогт: “Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 42
Бүгд: 94
55.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Ж.Батсуурь, Д.Цогтбаатар нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 59.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:22/

Уг асуудлыг 15 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн нар байлцав.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр нар танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Бямбацогт: 1.Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхланг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 36
Бүгд: 94
61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзоригийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 33
Бүгд: 94
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хороодын даргаар Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, П.Ганзориг нарыг сонгохыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:33/

Уг асуудлыг 15 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн урилгаар Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн бакалаврын эчнээ хөтөлбөрийн оюутнууд, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 117 дугаар сургуулийн 11Б, 11В ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагайн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн 12Б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын урилгаар “Yes Монгол” Төрийн бус байгууллагын нийслэлийн Сүхбаатар дүүргийн салбар зөвлөлийн гишүүд, нийслэлийн ерөнхий боловсролын 130 дугаар сургуулийн 11Г ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 10А, 11А, 12А ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн урилгаар нийслэлийн Баянзүрх дүүргийн “Социал демократ Монголын залуучуудын холбоо”-ны гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын урилгаар “Монгол 92-эвсэг барс холбоо”-ны төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны урилгаар Төв аймгийн Аргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 8А ангийн багш, сурагчид, нийслэлийн ерөнхий боловсролын 111 дүгээр сургуулийн 9Б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 133 дугаар сургуулийн 9Д ангийн багш, сурагчид, нийслэлийн ерөнхий боловсролын Монгени сургуулийн 11Е ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын референт Б.Мөнгөншагай, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 59 минут үргэлжилж, 126 гишүүнээс 94 гишүүн хүрэлцэн ирж, 74.6 хувийн ирцтэйгээр 15 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2026 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. 2026 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн чуулганы хуралдааны ирц хүрсэн байна. 126 гишүүнээс 65 гишүүн буюу 51,6 хувийн ирцтэй байгаа учраас чуулганы хуралдааныг нээснийг мэдэгдье.

Чуулганы хуралдааны өмнө энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож буй гишүүдийнхээ мэдээллийг та бүхэнд бас хүргэе. Төрсөн өдөр нь тохиож буй Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат 4 сарын 21-ний өдөр, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн 4 сарын 19-нд төрсөн байна. Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Сүхбаатарын Эрдэнэбат нарт төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол Улсын төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Өнөөдрийн чуулганы хуралдаанд хамгийн түрүүлж ирцдээ орсон гишүүдийг та бүхэнд мэдээлэл хүргэе. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Бөхчулууны Пүрэвдорж, Сүхбаатарын Эрдэнэболд, Ганбатын Очирбат, Баярмагнайн Баярбаатар гишүүд өглөө 9 цагт түрүүлж ирсэндээ орсон байна.

Энэ долоо хоногт, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн чуулганы хуралдаанаар дараах 4 асуудлыг хэлэлцэнэ. Энэ долоо хоногийн чуулганы хуралдааны товд орсон зарим асуудлууд тодорхой шалтгааны улмаас Байнгын хороод хуралдаж амжаагүй учраас хасагдсан байгаа. Хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. 1 дүгээрт нь Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна, Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Алдаржавхлан, Ариунзаяа нарын, мөн Батсүмбэрэл нарын одоо 4 гишүүн санаачилсан байгаа. Худалдаа, аж үйлдвэрийн танхим /ХАҮТ/-ын тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин, Хассуурийн Ганхуяг нарын гишүүд санаачилсан энэ хуулийн төсөл байгаа. 3 дугаарт нь Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ. 4 дүгээрт нь бусад асуудлын хүрээнд Зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хурал /УИХ/-д өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөлд хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд

мэдээлнэ гэж заасан. УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар та бүхэнд танилцуулъя.

1 дүгээрт, Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын 18 гишүүн 2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороонд.

2. Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан төслүүдийг Засгийн газар /ЗГ/ 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд.

3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир 2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороо /ТББХ/-нд тус тус хуваарилсан. Энэ асуудлуудаа холбогдох Байнгын хороод хэлэлцэх эсэхийг нь шийдэж, чуулганы хуралдаанд оруулж ирэхийг чиглэл болгож байна. Хэлэлцэх асуудалдаа орёё.

Нэг. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж. Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнай Баярбаатар танилцуулна. Энэ нэлээн чухал хууль байгаа. Өнөөдөр яах аргагүй ард иргэдийн амьдрал, эрүүл мэнд, амь насанд өвчин зовлон тохиолдсон үед эд, эрхтэн шилжүүлэх шаардлагатай. Энэ эд, эрхтэн шилжүүлэх асуудлыг мөнгөтэй боломжтой улсууд нь л гадаад руу явж эд, эрхтнээ солиулдаг, боломжгүй улсууд нь Монголдоо солиулах гээд хуулийн тодорхой зохицуулалт байхгүй байгааг манай Улсын Их Хурлын гишүүн, хууль санаачлагч Чинбүрэн, Ариунзаяа, Алдаржавхлан, Батсүмбэрэл нарын гишүүдээс олж харж санаачилсан. Өнгөрсөн 2025 оны 5 сард Их Хуралд өргөн мэдүүлэгдсэн. Одоо үндсэндээ жил гаруй хугацаанд хэлэлцүүлэг, ажлын хэсэг ажиллаад, Баярмагнайн Баярбаатар гишүүн ахалж ажиллаад, одоо анхны хэлэлцүүлэг хийх гэж байна. Тэгээд Баярбаатар гишүүн танилцуулгаа хийнэ үү.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Алдаржавхлан, Ариунзаяа, Батсүмбэрэл нараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал /УИХ/ 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын даргын 2025 оны 252 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Үүнд, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах хууль тогтоомжийн нэр томъёоны тодорхойлолтыг үг хэллэгийг иргэн, олон нийтэд ойлгоход хялбар, энгийн салаа утгагүй байдлаар илүү нарийвчлан томъёолж, хуульд хэрэглэгдэж буй сорьц, хүн, эд, үндэсний хүлээх жагсаалт зэрэг зарим нэр томъёоны тайлбарыг нэмж тусгалаа.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээг үзүүлэх зохицуулалтыг нэмж тусгасан.

3.Эд, эсийг шилжүүлэн суулгах эмчилгээг илүү эрчимтэй хөгжүүлэх зорилгоор эсийн ангиллыг тусад нь зүйл болгож, олон улсад хэрэглэж буй эмчилгээний шинэ технологи болох эд, эсийг хадгалах тусгай зориулалтын сан буюу био банкны зохицуулалтыг шинээр тусгалаа.

4.Амьд донорт тавигдах шаардлага, амьгүй донорыг илрүүлэх, бүртгэх асуудлыг олон улсын жишиг зарчимд нийцүүлэн томъёолсон.

5.Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/ болон Станбулын тунхаглалын зарчмуудыг хуулийн төсөлд мөрдлөг болгон тусгасан.

6.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах удирдлагын тогтолцоо үйл ажиллагааг илүү оновчтой болгох хүрээнд шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож байгаа эрүүл мэндийн байгууллагуудын чиг үүрэг, уялдаа холбоог нарийвчлан тодорхойллоо.

Байнгын хорооны хуралдаанд хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн хуулийн төслийн нэр, амьгүй донорын гэр бүлийн 3 гишүүнээс зөвшөөрөл авах талаар, Улсын Их Хурлын гишүүн Алтаншагай энэхүү харилцааг зохицуулж буй хүчин төгөлдөр эрх зүйн зохицуулалтын талаар болон донор хүлээж буй иргэдийн хувьд нөөцийн хуваарилалтыг хэрхэн шударга, хүртээмжтэй хийх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар гэнэтийн тохиолдолд авах зөвшөөрлийг хэрхэн зохицуулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир амьгүй донор гэсэн тодорхойлолт нь уламжлалт ёс заншилтай хэрхэн нийцэж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Наранбаяр донор хүүхдийн насыг тогтоосон зохицуулалтыг хүүхдийн хүсэл зоригийг хүндэтгэн оновчтой тодорхойлох талаар, Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун эд, эс хадгалах био банкны өнөөгийн нөхцөл байдлын талаар сургалт, судалгаа зохицуулалт би эсэх, реципиент эмнэлгийн тоо, төлбөрийн урьдчилсан зохицуулалтын талаар, эсийн донорт тавигдах тавих шаардлагад хүүхдийн насыг тогтоохдоо баримталсан эрх зүйн зохицуулалт нь хүүхдийн эрхийн зөрчил үүсгэсэн эсэх, зөвшөөрөл олгох гэр бүлийн гишүүдийн тоог ямар шалгуураар тогтоосон эсэх, амьгүй донорыг гэр бүлд

нь хүлээлгэн өгөхдөө хүндэтгэлтэй хандах ёс зүйн хэм хэмжээ болон амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмжийн хэмжээний талаар, түүнчлэн тархины үхэлд тодорхойлох мэргэшсэн баг болон эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төвийн талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёолол та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Донорын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Баярбаатар даргад баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Баярбаатараар ахлуулсан Энхнасан, Баясгалан, Болормаа, Рэгдэл, Отгонбаяр, Сарнай, Эрдэнэбат нарын гишүүдийн ажлын хэсэг энэ хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр 2025 оны 6 сарын 12-ны өдрийн Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийн дэд ажлын хэсгийн гишүүд Намжилын Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яам /ЭМЯ/-ны Төрийн нарийн бичгийн дарга /ТНБД/, Мэндсайханы Наранпүрэв ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Сэмбэдоржийн Жаргалсайхан ЭМЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Пандааны Батчулуун Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх, Баяраагийн Алтантулга Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга, Норовын Оюундэлгэр Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн Ясны чөмөг шилжүүлэн суулгах багийн ахлагч, Сүхбаатарын Мядагсүрэн Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн Ясны чөмөг шилжүүлэн суулгах багийн ахлагч, Ганбатын Гэрэлцэцэг Өөжинмед үр шилжүүлэн суулгах эмнэлгийн эмч. Ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн гишүүдэд хуулийн төслийг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ЗГ-ын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан болон бусад этгээд үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлэл өгөх үүрэгтэй. 21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, УИХ-д худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. 21.31.Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүй хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасныг та бүхэндээ сануулъя. Тийм болохоор үнэн зөв,

бодитой мэдээлэл өгч, Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд УИХ-д хүндэтгэлтэй хандахыг та бүхнээс хүсье.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. 12 гишүүн асуулт асууна. Энэ 74 санал хураалттай байгаа. Тийм учраас гишүүдийг өнөөдөртөө багтаагаад энэ асуудлыг хэлэлцэж дуусах бодолтой байна. 14 цагаас санал хураалтыг явуулна. 14 цагаас санал хураалт явагдана. Одоо гишүүд асуулт асууж, хариултаа авъя. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Энэ хуулийг би дэмжиж байгаа. Тэгэхээр ер нь далан хэдэн санал хураалттай байна гэдэг анхнаасаа яг энэ мэргэжлийн хүмүүсийн зөвлөгөөг бүрэн дүүрэн аваагүй учраас олон, олон саналууд, мэргэжилтнүүдийн саналаар орж байгаа байх. Хэлэлцүүлгийн явцад дэмжээд явна.

Нэг асуудал байнга над руу манай малчдаас маш их санал тавьж байгаа. Өөрөөр хэлбэл 2021 онд малчдын нийгмийн даатгалын шимтгэл /НДШ/-ийг нэг удаа нөхөн төлөх энэ хуулийн төслийг санаачилж, энд 16 мянга гаруй малчин, дээрээс нь 6 мянга гаруй хувиараа хөдөлмөр эрхэлсэн хүмүүс хамрагдсан. Тэгээд энэ хуулийг дахин явуулж өгөөч, баталж өгөөч гэдэг ийм хүсэлтийг тавьдаг. Энэ хүсэлтийн дагуу Тэмүүлэн, Батжаргал нарын гишүүд Малчны тухай хуулийг 2024 оны 5 сард батлуулсан. Энэ 5 сард батлуулсан, жоохон чимээгүй байж байгаарай, 5 сард батлуулсан. 5 сард батлуулсны үр дүнд малчны НДШ-ийг нөхөн төлөх энэ асуудал 25 оны 1 сарын 1-нээс нэг жилийн хугацаатай хэрэгжих ёстой байсан.

Гэвч харамсалтай нь ЗГ дагасан журмаа гаргахгүй байсаар байгаад өнгөрсөн Оюун-Эрдэнийн ЗГ энэ асуудлыг тоогоогүй. Дээрээс нь Занданшатарын ЗГ энэ асуудлыг тоогоогүй. Одоо энэ Учрал сайдын хувьд энэ асуудлыг яримаар байдаг. Гэвч Малчны тухай хуулийн тэр хэрэгжилт нь хугацаа нь дуусчихсан байгаа. Тэгэхээр энэ юуг илэрхийлж байна вэ гэвэл МАН 2024 оны сонгуулиар малчдын энэ гол асуудлыг шийдвэрлэнэ гэж саналыг нь авчхаад, тэгээд хулхидсан гэсэн үг. Тийм учраас би энэ хуулийн Малчны тухай хуулийн энэ заалтыг нэг жилийн хугацаагаар сунгах ийм хуулийн төслийг өнөөдрөөс эхлээд гишүүдээр гарын үсэг зуруулна. МАН-ынхан энэ бүлгийн дарга Батжаргал дарга бүлгийн дарга болсон байна. Энэ хуулиа амилуулах талаар нэлээн ажиллах байх. Манай Их Хурлын гишүүд ч гэсэн хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүдийн хувьд маш их энэ асуудлыг малчид тавьдаг. Дээрээс нь малын үнэ ч гэсэн жоохон ахиухан болж байна. Нийгмийн асуудлаа шийдвэрлэх ийм шаардлага малчдын хувьд хамгийн том асуудал болсон. Тийм учраас нөхөн төлбөрөө төлөх энэ боломж малчдын хувьд энэ жил гайгүй болж эхэлж байна. Малын үнэ цаашдаа өсөх нь, ер нь уламжлалт Орос руу махаа экспортлох ийм боломж нэмэгдэх юм байна. Үүний үр дүнд малын үнэ ч гэсэн нэлээн гайгүй өсөх ийм боломж гарч ирж байна.

Дээрээс нь хүйтэн улиралтай учраас малын түүхий эд, арьс шир, ноос ноолуур энэ уламжлалт зах зээл рүү гарах ийм боломж нь нэмэгдэж байна. Ингэсний үр дүнд малчид маань орлоготой болох нь. Орлоготой болохоор яах вэ малчид маань нийгмийн асуудлаа шийдвэрлэх ийм зайлшгүй шаардлага гарчаж байгаа юм. Тийм учраас энэ хуулийн нэг жилээр сунгах энэ хуулийн төслийг өргөн барина. Гишүүд маань дэмжиж, маш хурдан энэ асуудлыг 7 сарын 1-нээс, ирэх оны 7 сарын 1 хүртэл хэрэгжих ийм заалттай байна. Энэнийг дэмжиж өгөөсэй гэж хүсэж

байна. Малчид нөхдүүд энэ Их Хурлын гишүүдийг хөдөө орон нутагт ажиллахад нь чихнээс нь сайн хонх уяад, энэ асуудлыг дэмжихгүй бол дараагийн удаа сонголт байхгүй болно шүү, МАН-ынханд ялангуяа та нар хулхидаж ханалаа шүү гэж сайн захиж хэлээрэй гэж малчдадаа захих байна.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж гишүүд асуулт асууна. Тийм болохоор хэлэлцэх асуудалтай холбогдож асуултаа асууна шүү гишүүдээ. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. Тэгээд ажлын хэсгийн гишүүн Батчулуун эмчээс нэг асуулт байна. Батчулуун эмчийн хувьд бол Монголд яг энэ эд, эрхтэн шилжүүлэн суулгах чиглэлээр олон жил ажилласан, олон хүнд амь амьдрал, олон гэр бүлд амь амьдрал бэлэглэсэн ийм ачтай хүн байгаа. Би бас тэр ачийг нь хүртсэн хүмүүсийн нэг байгаа. Тэгээд энэ хууль, эрх зүйн орчноо сайжруулахаар ингээд үргэлжлүүлж идэвхтэй ажиллаж энэ хуулийн төсөл дээр нэлээн идэвхтэй ажиллаж байгаад талархаж байгаа. Тэгээд энэнтэй холбоотой яах вэ таны туршлагатай холбоотойгоор нэг асуулт байна. Энэ хууль дээр эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байгуулахаар заасан байгаа. Тэгэхээр яах вэ энэ нь өөрөө төсвийн асуудал байгаа учраас энэ оноос шууд энэ төвийн асуудал бол яригдах бололцоогүй. Тэгэхээр энэ зохицуулалт дээр ямаршуу байдлаар хэзээнээс, ямар байдлаар хийхээр төлөвлөгдөж байгаа вэ?

Дээр нь 2 дахь асуулт нь болохоор олон улсад яг энэ эд, эрхтэн шилжүүлэн суулгах төвтэй холбоотой асуудлууд энэ донорын олдоц, өвчлөл, тэгээд эдийн засгийн хүчин чадал зэргээсээ хамаараад тодорхой тооны жишээлбэл ийм тоонууд байдаг. Жишээлбэл тэдэн сая хүнд ийм хэмжээний, ийм чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг төв байхад болно гэсэн. Тэгэхээр энэ чиглэлээр ер нь энэ төвийн, энэ агентлаг ч юм уу дээр ямаршуу бодлого баривал зөв бэ, энэ талаар та юу гэж бодож байгаа юм бэ? Энэ талаар хариулж өгөхийг хүссэн ийм 2 асуулт байна.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? 4 номер дээр ажлын хэсэг Батчулуун эмч хариулъя.

П.Батчулуун: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь анх манай энэ хуулийг санаачилсан Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн тухайн үед энэ хуулийг санаачлахдаа ер нь бол төрийн захиргааны байгууллага байна, тэр дотроо агентлаг байна гэсэн асуудлыг оруулж ирсэн. Тухайн үед манай ажлын хэсгийг ахалж байсан өнөөдөр Ерөнхий сайдаар ажиллаж байгаа Учрал гишүүн энэ асуудлыг дэмжиж байсан. Гэхдээ бид явцын дунд манай үйл ажиллагааг бол илүү тохируулах ажил нь бол энэ үндэсний төв байх нь зүйтэй юм гэдэг асуудлыг ЭМЯ-н дээрээ удирдлагуудтайгаа ярьж шийдсэн байгаа.

2 дахь асуулт нь тэр дэлхийд, ДЭМБ, Дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах нийгэмлэгээс ер нь улс орнуудад рекумляц заавар өгдөг. Тэр нь 3,5-аас 5,5 сая хүн амтай улс оронд бол 1-ээс 2 эрхтэн шилжүүлэн суулгах төв байх нь зүйтэй гэдэг. Харин энэ манайх шиг энэ саяын яригдсан энэ агентлаг биш, энэ үндэсний төв шиг асуудал бол улс орон болгонд байдаг. Дэлхийд 93 орон эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийж байгаа болно. Баярлалаа.

С.Бямбацогт: Гомбын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Бүгдэд нь өглөөний мэнд. Энэ эрүүл мэндийн салбарт маш чухал хэрэгтэй. Гэхдээ хэл ам ихтэй, нарийн төвөгтэй энэ нүсэр үйл ажиллагааг зохицуулах ийм эрх зүйн бичиг баримттай болох гээд зориглон энэхүү хуулийг санаачилж байгаа гишүүд болон баг хамт олонд юуны өмнө талархлаа илэрхийлье. Эрхтэн, би эрүүл мэндийн салбарын хүн биш, тэс өөр салбарын хүн. Хэрвээ миний асуулт дотор танин мэдэхүйн чанартай юм гарвал уучлаарай. Гэхдээ яах вэ нэлээн энэ хуультай холбоотой нэлээн юм уншлаа. Энэ эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль боловсруулахад 1 дүгээрт нь хүний эрх, ёс зүй, 2 дугаарт нь донорын зохицуулалт, шилжүүлэн суулгах үйл ажиллагааны явц, хувь хүний эрүүл мэндийн аюулгүй байдал, хяналт, хариуцлага, хяналт, зохицуулалтын байгууллага, хариуцлага, шийтгэл, нууцлал ба мэдээлэл, олон улсын стандарт, олон нийтийн ойлголт, хандлага, боловсрол, дээрээс нь санхүүжилт, даатгал гээд маш олон өргөн хүрээтэй асуудал байдаг юм байна энэ салбар дээр яах вэ энэ хуулийг уншиж байхад.

Тэгээд энэ явцад 3 асуулт гарч байгаа юм л даа. 1 дүгээрт нь энэ хуультай холбоотой олон улсаас анхааруулдаг зүйл юу вэ гэхлээр энэ хариуцлагын тогтолцоо их сул байвал хууль бус эрхтний наймаа их цэцэглэдэг гэж ийм дүгнэлт, зөвлөмж өгдөг юм байна. Тэгэхлээр энэ хуулийн заалтын 26.1-д хууль зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж 26.2-т нь энэхүү хуулийг зөрчсөн хуулийн этгээдэд Эрүүгийн болон Зөрчлийн хуулийн хариуцлага хүлээнэ гэж. Энэ дээр яагаад эмч болон байгууллагын хариуцлагын заалтын хуулийн санкцыг тодорхой оруулж ирээгүй вэ гэдэг 1 дүгээр асуулт байна?

2 дахь асуулт нь энэ донорын сайн дурын зөвшөөрөл хүний эд, эрхтнийг арилжаалах хууль бус наймаанаас сэргийлэх, ялангуяа энэ эмзэг бүлгийн хүмүүсийг эрхтнээ албадан арилжаалахаас сэргийлэх тухай маш их анхаарах ёстой гэж заадаг юм байна. Энэ чиглэлээр ямар зохицуулалт орж ирсэн юм бэ? Энэ эрхтний наймаа чинь ялангуяа орлого багатай эмзэг эрхтнүүдийг хүмүүс албадан наймаа хийлгээд, эрхтнийг нь заруулдаг дэлхий даяар тийм гашуун, хар туршлага байдаг юм байна л даа. Энэ чиглэлийн заалтыг би ерөөсөө энэ хууль дотроос олж харсангүй. Энэ зохицуулалтуудыг хэлж өгнө үү гэж?

3 дахид нь донорын зохицуулалттай холбоотойгоор амьд донорын эрүүл мэндийн шалгуур, тэр сэтгэл зүйн үнэлгээ, нас барсан донорыг үнэлэх, донорын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан. Ялангуяа энэ нэгдсэн санг олон улсад найдвартай байх үүднээс нь Үндэсний зөвлөл, бүүр тусгай агентлаг байгуулж хянадаг юм байна. Гэтэл манай хуульд энэ оруулж ирж байгаа хуулийн 16 дугаар зүйлд төрийн захиргааны байгууллага нь нэгдсэн бүртгэл мэдээллийн сантай байх бөгөөд технологийн нууцлал, найдвартай байдлыг хангасан байна гэж заасан байгаа юм. Тэгээд энэ 3 асуулт дээр. Энэ аюулгүй байдал, тэр технологийн нууцлал эд нартай холбоотой энэ 3 асуултыг би хуулийг танилцах, унших явцдаа хувь хүнийхээ хувьд тодруулж байгаа юм. Та бүхэнд мэргэжлийн улсуудад танин мэдэхүйн чанартай ч юм уу, мэргэжлийн бус байвал уучлаарай гэж хүсэж байна. Хариултаа авъя.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Баярмагнайн Баярбаатар гишүүн хариулъя. Дараа нь ажлын хэсэг бэлдэж байгаарай.

Б.Баярбаатар: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Дараа нь ажлын хэсэг нэмээд хариулаарай. Монгол Улс 1996 онд анхны эрхтэн шилжүүлэх мэс заслыг хийснээс өдгөө 30 жил болж байгаа юм. 2018 онд Донорын тухай хуульд зарим зүйл, заалтыг эрхтэн шилжүүлэхтэй холбоотой зүйл, заалтыг оруулж мөрдөж хэрэгжүүлж явсан. Энэ зүйл, заалт дутмагийн улмаас өнөөдөр эмч, эмнэлгийн ажилтнууд маань энэ эрхтэн шилжүүлэх үйл ажиллагаа тасалдах, цаашлаад анагаах ухааны дутмаг мэдлэгийн дутмагаас болж зарим нэг улсууд буруу хариуцлагын систем рүү шилжсэн ийм зүйлүүд өнгөрсөн хугацаанд өрнөсөн. Тэгээд энэ үед энийг засаж залруулахаар энэ анхны бие даасан буюу анхдагч хуулийн төслийг өнөөдөр нэгдсэн чуулганд хэлэлцүүлж байгаа.

Эхний асуултад хариуцлагын тогтолцоо сул биш. Эрүүгийн хуульд, Зөрчлийн хуульд тусгай заачихсан, дэлгэрэнгүй хүний эд, эрхтний наймаа гээд бүүр Эрүүгийн хуулийн зүйл, заалтууд нь байж байгаа. Энийг заавал энэ хуульд зүйл, заалтаар нь биш, тэртээ тэргүй Эрүүгийн хууль дээр тусчихсан, Зөрчлийн хууль дээр туссан байгаа учраас тэр агуулгаар нь Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулийн холбогдох заалтаар хариуцлага хүлээлгэнэ гэсэн ийм заалт нь хамгийн төгсгөлд нь 26 дугаар зүйл дээр та байгааг уншлаа.

Дараагийн асуудал нь эрхтний наймаатай холбоотой асуудал. Өнөөдөр энэ манай хууль дээр яг заачихсан юм. Гэр бүлийн гишүүн, амьд донороос эрхтэн шилжүүлэн суулгах бол гэр бүлийн гишүүнээс нь, дээр нь энэ дээр бид нар хүргэн, бэр гэдэг заалтыг оруулж өгөөд ингээд тодотгосон. Энэ нь өөрөө Гэр бүлийн тухай хуулиараа гэр бүлийн гишүүн гэдэгт хэн, хэн хамаарах вэ гэдгийг тодорхойлоод заагаад өгчихсөн байж байгаа. Тэгэхээр ямар нэгэн байдлаар гэр бүлийн гишүүн биш хүнээс амьд донороос эрхтэн шилжүүлж суулгах нь манай хуулиар хориотой гэдэг агуулгын заалт нь энэ дээр орж байгаа. 3 дахь асуултад манай Алтантулга дарга саяын хариулт дээр нэмээд хариулт өгчих.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Б.Алтантулга: Сайн байцаана уу? Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга Алтантулга. Ганбаатар гишүүний асуултад нэмж хариулъя. 2 дахь асуулт дээр бол яг энэ хууль бус эрхтний наймаатай холбоотой олон улсад нэг мөрдөгддөг Станбулын тунхаглал гэж байдаг. Энэ бол хүний наймаа, хүний эрхтний наймаанаас ангид байна гэсэн ийм тунхаглал байдаг. Энэ тунхаглалд Монгол Улс 2018 онд нэгдэж орсон байгаа. Тэгэхээр энэ талын зарчмууд, заалтуудыг бид хуулийн төсөлдөө тусгаж, мөрдөж ингэж явдаг байгаа.

Дараа нь бол амьгүй донорын энэ асуудал дээр нэмж тайлбарлахад энэ амьгүй донорын бид гэр бүлийн гишүүдээс нь 3 хүртэлх гишүүнээс нь заавал ч үгүй зөвшөөрөл авч, баталгаажуулсны үндсэн дээр эрхтэн, эд, эс авах мэс заслыг ингэж зохион байгуулахаар зохицуулсан байгаа. Нэгдсэн бүртгэл мэдээний сангийн хувьд гэвэл яг манай алба 2018 онд байгуулагдсанаас өнөөдрийг хүртэл бид нэгдсэн бүртгэл мэдээний сангаа байгуулсан. Энэ хуулийн төслийн үндсэн дээрээ бид энэ үйл ажиллагааг хэрхэн зохицуулах, ямархуу зохион байгуулалттай байх юм, журам энэ асуудлыг ярьж байгаа. Мөн энэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя.

Б.Алтантулга: Нууцлал, аюулгүй байдлын хувьд гэвэл энэ цахимын дагаж гарсан 4 хууль дээрээ маш тодорхой заалтууд заасан байгаа учраас энэ хууль дээр нэмж тусгах шаардлагагүй юм байна гэж үзсэн байгаа. Тэгэхээр энэ бусад хуулиараа зохицуулчхаж байгаа учраас энэ бол нууцлалыг, тэр дундаа хүний эмзэг мэдээллийг найдвартай, аюулгүй байдлыг хангана гэж орсон байгаа.

С.Бямбацогт: Хариулт хангалттай юу, тодруулчихъя. Гомбын Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Тодруулга ч юу байх вэ дээ ер нь би асуултынхаа эхэнд хэлсэн. Энэ эрүүл мэндийн салбарт төвөгтэй, ярвигтай, хэл ам ихтэй хууль шүү гэж. Тэгэхээр яах вэ энэ манай улсад энэ олон нийтийн хандлага энэ эрүүл мэндийн эрхтэн шилжүүлэх, эд, эс шилжүүлэх энэ ойлголт арай дутмаг байдаг иргэдийн дунд. Тийм учраас энэ чиглэлээр их сайн ажиллаж, энэ хуулийн ач холбогдол болоод ер нь иргэдийнхээ энэ хандлагыг өөрчлөх чиглэлээр нэлээн их зүйл хийх шаардлагатай байгаа шүү гэдгийг эцэст нь хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Үг хэллээ. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Өглөөний мэндийг хүргэе. Эд, эс, эрхтэн шилжүүлэхтэй холбогдолтой асуудлыг зохицуулсан хуулийн төсөл орж ирж байна. Хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлье. Ажлын хэсэг нэлээн идэвхтэй ажиллаж, Байнгын хороон дээр зүйл бүрээр нь бид бүхэн ярилцсан. Энэ хуулийн төсөлтэй холбогдуулаад хэд хэдэн асуултуудыг тодруулъя.

Үндсэндээ дэлхийн, үзэл баримтлал дээр дурдсанаар дэлхийн 93 улс эд, эс, эрхтэн шилжүүлэх энэ эмчилгээг явуулж байгаа юм байна лээ. Үүний 90 улс нь тусгай зохицуулалт бүхий хуультай гэдэг ийм мэдээллийг дурдсан байна. Монгол Улсын хувьд бол энэ төрлийн эмчилгээ, үйлчилгээг явуулж байгаа хэр нь тусгай зохицуулсан хуульгүй, яг энэ Донорын тухай хуулиараа бусад хуулиараа зохицуулаад явж ирсэн байна. Энэний үндсэндээ үр дүнд олон эмч, эмнэлгийн ажилчид, мөн дээрээс нь олон хүний амь настай холбогдолтой асуудал шийдэж чадахгүй зохицуулалтгүйгээр явж ирсэн ийм асуудал байгаа учраас нэлээн хэрэгцээ шаардлагын хувьд зайлшгүй шаардлагатай ийм хууль гэж үзэж байна.

Энэ хуулийн тодорхой төсөлтэй танилцаад явахад энэ үндэсний энэ хүлээлгийн жагсаалттай холбогдолтой асуудлыг нэлээн хөндөж байна. Мэдээжийн хэрэг хэрэгцээ шаардлага нэлээн их байгаа. Энэ хүлээлэгт орсон энэ жагсаалтыг ил тод байх, хуваарилалтыг шударга явуулах, үүнтэй холбогдолтой тодорхой асуудлууд гарахаас урьдчилан сэргийлсэн, мөн илүү цахим хүний оролцоогүйгээр шийдвэрлэх боломжийг олгосон ямар зохицуулалт байгаа вэ гэдгийг би тодруулж асууя. Аль нэгэн хүнээс хамааралтайгаар шийдэгдэхгүй байхаар ийм шийдлүүд юу байна вэ гэдэг дээр энэ их чухал? Хүлээлгийн жагсаалтаа хүлээгээд хэдэн жил болж байгаа ийм тохиолдлууд үндсэндээ гарна. Тэгэхээр хэнийг нь түрүүлж оруулах вэ гэдэг дээр яг юуг баримталж, яаж ажиллах вэ гэдэг их чухал гэж.

2-т нь иргэдийн мэдээлэлжүүлэхтэй холбогдолтой гишүүдийн хэлж байгаа саналыг дэмжиж байна. Энэ чиглэлийн доноруудыг дэмжих, ойлгуулах чиглэлийн тусгай зохицуулалтууд ямар байгаа вэ? Нөгөө талдаа энэ хууль батлагдсанаараа янз бүрийн хууль бус байдлууд бий болох вий гэдэг ийм эмзэглэлүүд нийгэмд гарч ирж байгаа. Тэгэхээр үүнтэй холбогдолтой тайлбар мэдээллийг нэмж тодруулъя.

Ялангуяа Монгол Улсад бөөрөө байдаг юм уу, эсхүл энэ донор болоод тодорхой хэмжээний арилжаа наймаа ийм мөнгө төгрөг олох ийм зар сошиал медиа энэ хуудаснууд дээр тавигдаад ингээд явдаг. Гэхдээ үүний цаана иргэдийн хувьд буруу мэдээллүүд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хуулиас өмнө ч тэр, энэ хууль батлагдсанаараа ч тэр ямар нэгэн эд, эс, эрхтнээ худалдан борлуулахтай холбогдолтой үүнийг дэмжсэн агуулга Монгол Улсад байхгүй гэдгийг мэргэжилтнүүд маань албан ёсоор хэлж ойлгуулах нь зөв байх гэж бодож байна.

3 дахь нь орон нутгийн иргэд, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд, бүсийн оношилгооны төвүүд энэ хуулиар ямар чиг үүрэгтэй болж, ямар байдлаар үндсэндээ ажиллах зохицуулалтууд тусгагдсан байгаа вэ? Орон нутгийн иргэдийг энэ зохицуулсан зохицуулалтыг илүү нарийвчилж асууя?

Жил болгон бид 20 гаруй өвчнийг зарлаад, Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй гэдэг ийм жагсаалтыг гаргаад явж байгаа. Хэчнээн тэрбумаар нь үндсэндээ гадаад улсад очиж, энэ төрлийн үйлчилгээнүүдийг бид бүхэн авч байгаа. Тэгэхээр энэ хууль батлагдсанаараа Монгол Улсад эмчлэгдэхгүй байгаа тодорхой ямар төрлийн энэ өвчлөлтүүдийг, ямар төрлийн энэ хагалгаануудыг хийх боломж бололцоонууд бүрдэх вэ, яаж нэмэгдэх вэ гэсэн ийм 4 асуултыг асууя.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Баярмагнайн Баярбаатар гишүүн асуултад хариулья.

Б.Баярбаатар: Би Ганхүлэг гишүүний зарим асуултад хариулаад, заримд нь манай Алтантулга дарга хариулаарай. 93 улс өнөөдөр эрхтэн шилжүүлэх мэс заслыг хийж байгаа дэлхийн 220 гаруй улсаас. Энэ 93 улсын нэг нь Монгол. Мөн энэ 93 улс дотроо Монгол Улс эрэмбээрээ нэлээн дээгүүр эрэмбэлэгдэж, чадвараараа үнэлэгдэж явж байгаа. 25 онд жишээлбэл амьгүй донор нэг ч амьгүй донороос эрхтэн шилжүүлээгүй. 26 онд ганцхан амьгүй донороос эрхтэн шилжүүлсэн, нэг амьгүй донороос үндсэндээ 8 хүний амь насыг аврах ийм боломжтой. Яагаад энэ амьгүй донорыг бид эрхтэн шилжүүлэх мэс засал зогссон бэ гэвэл ерөөсөө бид өнөөдөр энэ хууль, эрх зүйн орчин дутмаг байгаагаас болж үндсэндээ энэ ажил явахгүй байгаа.

Дээр нь энэ хууль батлагдсанаар бид хэрэгжилтийг хангах, иргэдийг соён гэгээрүүлэх чиглэл рүү нэлээн өндөр ач холбогдол өгч зайлшгүй ажиллах шаардлага байгаа. Учир юу вэ гэвэл зан заншил, шашин гээд олон зүйлүүд дээр өнөөдөр энэ талийгаач буюу бурхан болоочийнхоо энэ цогцост хөндүүлэхгүй гэсэн ийм нөхцөл байдалтай иргэд нь дийлэнх байдаг учраас эргээд бид үүгээрээ буяны үйлс, алтан хүний амь насыг аврах гэдэг тал дээр соён гэгээрүүлэх чиглэлээр ажиллах нь зүйтэй.

Жагсаалт бол ил тод. Өнөөдөр 1044 хүн жагсаалтын хүлээлгийн горимд байгаа. Эндээс эрхтэн шилжүүлж суулгаад эдгэрч байгаа хүн нь ховор. Жагсаалтад хүлээж байгаад бурхны оронд одож байгаа хүмүүсийн тоо нь олон байгаа. Тэгэхээр энэ дотор ингээд нарийвчлаад ангилаад үзвэл элэг шилжүүлэн суулгах, бөөр шилжүүлэн суулгах гээд ангиллууд нь өөрсдөө тусдаа байж байдаг. Жишээлбэл нэг амьгүй донор гарлаа гэж үзэхэд тэр хүний ингээд цусны бүлгээс нөгөө эрхтэнд таарах эсэх гээд нийтдээ хамгийн багадаа 20-оод хүнийг дуудаж жагсаалтын дарааллын дагуу шинжилгээнд оруулахаар ингэж зорьж ажилладаг. Гэтэл нөгөө дуудаж байгаа хориод хүнээс маань хүлээлгэндээ байх үедээ 50 хувь нь үндсэндээ

бурхны оронд очсон ийм харамсалтай тоо баримт бол өнгөрсөн хугацаанд гараад явж байгаа гэдгийг хэлэх нь зөв.

Орон нутгийн эмнэлгүүд өнөөдөр бүгд донор эмнэлгүүд болж байгаа. Өнөөдөр бид нөгөө амьгүй донорыг олноор илрүүлэх нь манай хуулийн концепц байж байгаа. Амьд донороо хамгаалах өөрөө эрх зүйн орчин байх ёстой. Тэгэхээр энэ амьгүй донор илрүүлэлт нь өөрөө таны хэлээд байгаа нөгөө бүсийн хөгжлийн төв, аймгийн эрүүл мэндийн нэгдсэн эмнэлгүүд өөрөө энэ илрүүлэх ийм эмнэлгийн тоонд ороод ингээд явж байгаа. Энэнээс үүдээд нөгөө холбогдох манай хууль батлагдсанаар 7 журам батлагдана. Энэ дээр нөгөө эрхтэн нь зөөвөрлөх, хадгалах, шилжүүлэн суулгах эд нар гэсэн ийм зохицуулалтын нарийвчилсан зүйлүүд нь ингээд ороод явж байгаа гэдгийг танд хэлье. Алтантулга дарга нэмээд хариулчих.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон, ажлын хэсгийн гишүүн Алтантулга хариулъя.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Ганхүлэг гишүүний асуултад нэмж хариулъя. Бид нэгдсэн бүртгэл мэдээний сантай болсноор энэ хүлээх жагсаалтад хүлээж байгаа хүмүүс маань өөрийнхөө ИМонголиа системээр дамжуулж ороод яг зөвхөн өөрийнхөө хүлээх жагсаалтын хэддүгээрт байх энэ байрыг мэдэх боломжийг энэ шинэ хуулийн төслөөрөө холбогдох энэ журмаараа бол зохицуулж өгөхөөр төлөвлөсөн байгаа.

Монгол Улсад энэ эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаатай холбоотой хүний наймаа, эрхтний наймаатай холбоотой асуудлыг манай алба байгуулагдсанаас хойш Эрүүгийн цагдаагийн газар, Цахим гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй байнгын хамтарч ажилладаг. Энэ үүднээсээ энэ сошиал ертөнцөд энэ хүний наймаа, эрхтний наймаатай холбоотой, тэр дундаа элэг, бөөрөө зарна гэсэн энэ холбоотой пост, зарим энэ юун дээр бол бид хамтарч устгуулах, тухайн иргэнийг IP хаягаар нь дамжуулж асуух байдлаар ингэж зохицуулж явдаг байгаа.

Монгол Улсад эмчлэгдэх, оношлох боломжгүй энэ өвчний жагсаалтыг бол яг манай эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой ясны чөмөг, элэг, бөөр шилжүүлэн суулгах энэ асуудлууд байдаг. Энэ дээр бол ялангуяа.../үг тасрав/

С.Бямбацогт: Түр байж байгаарай, тэгээд зочин танилцуулна шүү. Байж байгаарай. Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэгийн урилгаар Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн сургуулийн эчнээ ангийн 2, 3 дугаар түвшний оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Оюутан, залуучууд та бүхэн маань оюутны ширээний ард суух цаг хугацаа эргэж олдохгүй гэдгээ үргэлж санаж, өдрөөс өдөрт өөрийгөө олж, өөрийгөө ирээдүйд бэлтгэж, сайн суралцаарай гэдгийг Улсын Их Хурлын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс өргөн дэвшүүлье. Манай Ганхүлэг гишүүний ангийн оюутнууд байна тийм ээ? Ганхүлэг гишүүн маань асуултаа асууж байгаа. Тодруулаад асуучихъя. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Хүлээлгийн жагсаалттай болоод ИМонголиа систем рүү оруулаад ингээд жагсаалт нь ил болчих юм байна. Миний асуугаад байгаа нь хэн шалгаруулах вэ, энийг яаж хэн нэгэн хүнээс ангид байдлаар шийдэх боломжууд юу байна вэ? Үүнтэй холбогдолтой жагсаалтын урдуур, хойгуур орууллаа, аль нэг нь дарга шийдлээ ингэлээ гэдэг ийм асуудлыг бид яаж шийдэх вэ гэдэг өөрөө явж, явж

хамгийн чухал асуудал болно. Тэгэхээр энэ дээр тэр журам тодорхой асуудлаар шийдэх юм шиг байна. Тэгэхдээ ер нь ямар шийдэл байдаг юм бэ гэдгийг асууя?

2 дахь нь энэ орон нутагт тодорхой чиг үүргүүд очих нь байна. Тэгэхээр хүний нөөцийн асуудал дээр яах юм бэ, зардал, санхүү дээр яах юм бэ энийг яаж шийдье гэж тооцсон байгаа вэ? Тэр 25 нэр төрлийн гадаадад эмчлүүлж байгаа энэ өвчлөл дээр ямар өөрчлөлт гарах вэ гэсэн ийм асуулт байгаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гишүүн 4 номерын микрофон Алтантулга хариулъя.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Бид энэ амьгүй донороос энэ хэрвээ зөвшөөрсөн тохиолдолд эд, эрхтнийг хуваарилах тогтолцоо бол бүрэн цахимжиж байгаа. Ялангуяа энэ хүлээлгийн жагсаалтад байгаа хүмүүсийг тухайн амьгүй донор гарсан тохиолдолд эд нийцлийн тохироо, холбогдох цусны бүлэг, эрхтнийх нь онцлогоос нь хамаараад оноо өгөх зарчмаараа ялангуяа яг олон улстай жишигт нийцүүлэн хүлээх жагсаалтад хүлээсэн хугацаа, тухайн хүний эрүүл мэндийн байдал, мөн эд нийцлийн тохироо зэргээс нь хамаараад мэдээний сангаар дамжуулаад хамгийн тохироо бүрдсэн энэ хүмүүсийг бид лист гаргаж авна. Эдгээр листээсээ бид эрхтэн шилжүүлэн суулгах баг, манай зохицуулах албатай хамтраад тухайн эмчлүүлэгчийг энэ сонгох асуудал байгаа. Энэ дээр заавал ч үгүй нэг гишүүнийг нэг candidate-г гаргадаггүй нь асуудал нь тухайн хүн хэрвээ зөвшөөрөхгүй эсвэл ямар нэгэн байдлаар хасагдах тохиолдолд дараагийн гишүүдийг мөн дууддаг байгаа.

2 дахь асуултын хувьд хүний нөөцийн асуудал ямар нэгэн нэмж бол зардал учруулахгүй. Ялангуяа тухайн эрүүл мэндийн байгууллага.../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа гүйцээгээд хариулчихъя.

Б.Алтантулга: Бүсийн оношилгоо, эмчилгээний төв /БООТ/, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг дээр энэ амьгүй донорыг илрүүлэх, тархины үхэлд тодорхойлох баг нь тухайн эмчилгээний эмнэл зүйн эрхэлсэн дэд захирлаар ахлуулсан тухайн мэргэжил бүрийн, чиглэл бүрийн эмч нарын энэ оролцоотой энэ тархины үхэл тодорхойлох байдаг учраас нэмэлт ийм зардал бол ямар нэгэн байдлаар шаардлагагүй. Харин илүү цаг, урамшууллын асуудлыг тухайн эрүүл мэндийн байгууллага зохицуулахаар байгаа.

Монгол Улсад эмчлэгдэх, оношлох боломжгүй өвчний жагсаалтад бол энэ эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой ясны чөмөг, үүдэл эс, элэг шилжүүлэн суулгахын асуудлууд орсон байдаг. Эдгээр нь яагаад орсон бэ гэхээр жишээ нь элэг шилжүүлэн суулгахын хувьд тухайн реципиент юм уу, донорын хувьд ямар нэгэн хэвийн бус бүтэцтэй, цусны замын салаатай, судасны салаатай байсан тохиолдолд бид бол одоогоор гадагшаага энэ төрлийн эмчилгээг явуулж байгаа. Бид цаашдаа эх орондоо энэ төрлийн эмчилгээ тусламж, үйлчилгээг авах зорилготой зочин профессор урих, эргүүлээд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаадад урих сургах энэ асуудлыг зохицуулж байгаа.

С.Бямбацогт: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: 2 дахь асуудал дээр яг нэг та хэд маань мэргэжлийн хүний зүгээс нэг тайлбар өгчхөөрэй. Яагаад гэвэл иргэд маань мэдээллийн дутуугаас болоод бөөрөө зарж болох юм байна, элгээ зарж болох юм байна гэдэг юм уу нэг ийм мэдээлэл яваад байгаа дээр яг нэг албан ёсны хариу өгөөч. Монгол Улсад ийм үндсэндээ зохицуулалт огт байхгүй. Энэ хууль батлагдсанаараа ч тийм нөхцөл бүрдэхгүй гэдгийг бүүр яг албан ёсоор хэлээд, дээр нь энэ төрлийн мэдээллийг цацсан тохиолдолд байдаг юм уу, энэ төрлийн асуудал дээр ямар хариуцлага үүрдэг юм бэ гэдгийг албан ёсоор өгчих нь зөв байна тийм.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Монгол Улсад өнөөдрийн байдлаар энэ ялангуяа цахим орчинд, энэ сошиал орчинд эрхтний зарах, тэр дундаа элгээ зарна, бөөрөө зарна гэсэн энэ асуудал бол ямар ч байж болохгүй. Энэ бол холбогдох хуулиараа бүрэн зохицуулсан байгаа. Тэгэхээрээ хэрэв та эдгээр төрлийн зар энэ тэр тавивал холбогдох хууль, ялангуяа эрүүгийн хуулиар бол шийдэх ийм зохицуулалттай байгаа шүү.

Дараагийнх нь болохоороо бид амьд донорын энэ асуудал дээр нарийн зохицуулалтыг оруулж өгсөн. Өмнө нь энэ гэр бүлийн гишүүн гэдэг энэ асуудалтай байсан бол бид гэр бүлийн гишүүн, үүнээс гадна хүргэн, бэрийн асуудлыг оруулсан. Тэр дундаа энэ зөвшөөрөл авах процесс дээр бид амьгүй донор тухайн гэр бүлд зөвшөөрсөн тохиолдолд тухайн амьгүй донорын хамгийн ойрынх нь гэр бүлийн гишүүнээс нь давхар зөвшөөрөл авах энэ зохицуулалтуудыг илүү нарийн оруулж өгсөн байгаа.

С.Бямбацогт: Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуултаа асууя, алга байна. Отгоншарын Батнайрамдал гишүүн. Уучлаарай би зочин танилцуулаадахъя. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 117 дугаар сургуулийн 11Б, 11В ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Сурагч нас гэдэг хүний амьдралын хамгийн нандин, хамгийн гэгээн, хамгийн сайхан мөрөөдөлтэй энэ цаг үе. Энэ хүүхэд насандаа эрдэм номдоо шамдан, спортоор хичээллэж, мөн тун удахгүй хүссэн мэргэжлээрээ, хүссэн их, дээд сургуульдаа орохын төлөө шамдаарай, хичээгээрэй гэдгийг Улсын Их Хурлынхаа гишүүдийн нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуултаа асууя.

О.Батнайрамдал: Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай энэ чухал хуулийн төслийг санаачилсан, мөн ажлын хэсгийнхэндээ талархал илэрхийлье. Энэ хүний амь нас аврах маш буянтай хууль. Надад маш тодорхой нэг асуулт хууль санаачлагч болон ажлын хэсгээс асууя. 11 дүгээр зүйл донор болохоо илэрхийлэх талаар. Энэ донор болохоо илэрхийлэх талаар энэ өөрөө эдийн засгийн шинжлэх ухаан, тэр дундаа зан төлөвийн эдийн засаг дээр аягүй тод гарч ирдэг жишээ л дээ. Маш олон оронд нийт иргэдийн дийлэнх нь донор болох хүсэлтэй боловч буцаад яг шаардлагатай болохоор донор хангалттай байдаггүй маш олон жишээ дэлхий даяар байдаг. Тэгэхээр энэ дээр 2 төрлийн шийдлүүд байдаг шүү дээ opt in, opt out. Ялангуяа opt out буюу анхны сонголт нь бүгдээрээ донор байж байгаад донор биш болбол өөрийн биеэр ИМонголиа дээр ч юм уу бүртгүүлээд донороос гарах хүсэлтээ гаргадаг. Энэний сонгодог жишээ жишээлбэл Испани байна, Австри байна, Герман байна. Энэ эдийн засгийн хамгийн сүүлд гарч ирсэн зан төлөвийн эдийн засаг дээр

маш амархан ёвроо аргаар, ёврох гэдэг юм даа, ... буюу ёврох гэдэг аргаар дефолт буюу хамгийн анхны тэр тохиолдлыг нь анхны тэр сонголтыг нь бүгдээрээ донор болгох гэж өгөөд, донороос гаргах сонголтоо өөрөө ИМонголиагаар дамжуулаад хийх энэ шийдлийг хэрэгжүүлсэн орон донороор бол донорын хүртээмж хамаагүй илүү байдаг ийм тохиолдлууд байгаа юм л даа.

Тэгэхээр энэ талаар тухайн хуулийг бичиж байхдаа хууль санаачлагч Монгол Улсын хэмжээнд энийг хэрэгжүүлэх нь үр дүнтэй болох байсан юм биш үү гэдэг би асуултыг л асуумаар байгаа юм л даа. Одоо байгаа орж ирсэн хувилбараар нөгөө opt in буюу эсвэл бүгд донороор больё гэвэл өөрөө хүсэлтээ гаргаад ИМонголиа дээр орж ингээд, тэгэхээрээ ер нь хүмүүс бүгдээрээ донор болоход татгалздаггүй мөртөө гэхдээ тэр ИМонголиа руу ороод тэгээд бүртгүүлдэг хүмүүс нь ер нь явж, явж олон улсын жишгийг харахаар маш ховор болж таардаг. Эсвэл бүүр том компанит ажил л хийхгүй бол энэ систем өөрөө хангалттай ажиллаж өгдөггүй. Тэгэхээр энэ тал дээр бодлого энэ хууль боловсруулж байхдаа бусад орны жишээг хэрхэн авч үзэж, энэ шийдлийг гаргасан юм бол гэдгийг асууя? Даргаа хууль санаачлагчаас болон ажлын хэсгээс асууж байна.

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулахгүй л дээ, одоо ажлын хэсэг хариулах ёстой анхны хэлэлцүүлэг явж байгаа учраас. Ажлын хэсгийн ахлагч Баярмагнайн Баярбаатар хариулъя. Дэг нь тийм дэгтэй. Тийм дэг байхгүй.

Б.Баярбаатар: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя, чухал асуудал хөндлөө. Өнөөдөр энэ opt in, opt out гээд 2 үндсэн арга хэрэгсэл дэлхийн жишигт хэрэгжээд явж байгаа. Тэгээд тухайн улсын зан заншил, соёл, хүний эрх, ёс зүй гээд олон зүйлүүдийг харгалзаж, хууль санаачлагч хуулийн төсөл боловсруулах үедээ болдог бол нээрээ үнэхээр энэ opt out-аар нь явах юм сан гэсэн ийм хүсэл эрмэлзэл байсан. Тэгэхдээ өнөөдөр Монгол Улс хүний эрхийг дээдэлдэг улс. Иргэдийн зан заншил, шашин шүтлэгийн асуудлыг бид өндөр түвшинд авч үзэж, бид opt in гэдэг зарчмыг нь хуульдаа тусгаж өгсөн. Өнөөдөр амьд сэрүүндээ хэн ч байсан гэсэн өнөөдөр донор болох хүсэлтээ ИМонголиагаар орж илэрхийлж, үнэмлэх авах ёстой, авах боломжтой. Одоогоор 6500 орчим иргэн донор болох хүсэлтээ илэрхийлсэн үнэмлэхээ авсан гэсэн үг. Энийг хуулиар бид нээлттэй зохицуулаад өгсөн. Соён гэгээрүүлэх ажил буюу тэр компанит ажил маш чухал байгаа.

Бид өнөөдөр хууль батлахдаа гол, батлаад дуусгахдаа гол нь биш. Энэ хууль батлагдсанаар хэдэн хүний амь нас аврагдах вэ гэдэг асуудал дээр онцгой анхаарал хандуулж, энэ хуулийн төслийг болсон. Хэрвээ амьд сэрүүндээ хүн өөрөө донор болох зөвшөөрлөө ИМонголиагаар дамжаад цахим системд бүртгүүлээд үнэмлэх авчихсан тохиолдолд дараа нь бид гэр бүлийн гишүүдээс нь зөвшөөрөл авах шаардлага байхгүй. Өөрөө ямар нэгэн тийм зөвшөөрөл олгоогүй тохиолдолд тухайн шаардлага хангаж байгаа амьгүй донорын 3 хүртэл гэр бүлийн гишүүнээс нь бичгээр зөвшөөрөл авч байж. Тэгэхдээ өнөөдөр жишээлбэл бидний хамгийн түгээмэл мэддэг тархины цус харвалтаар өнөөдөр жилд 3 мянга орчим хүн нас барж байдаг. Гэтэл энэ 3 мянга орчим хүнээс яг амьгүй донорын шаардлагыг хангаж байгаа хүн маш цөөхөн гарч ирнэ. Тэгэхээр бид энэ соён гэгээрүүлэх ажил энэ компанит ажлын гол асуудал өөрөө их чухал байдаг гэдэг дээр тантай санал нэг байна. Дараа дараадаа бид нар энэ анхдагч хуулийн төсөл хууль, эрх зүйн орчноо бий болгосны дараа бид сайжруулах, магадгүй энэ саяын тэр opt out гэдэг зарчим руу нэг өдөр шилжих ийм боломж бололцоо байгаа гэдгийг танд хэлье.

С.Бямбацогт: Ажлын хэсэг нэмээд хариулчихъя.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Батнайрамдал гишүүний асуултад нэмж хариулъя. Өнөөдрийн байдлаар Монгол Улс opt in гэдэг системээр явдаг байгаа. Тэгэхээр ер нь бол энэ ДЭМБ, Дэлхийн эрхтэн шилжин суулгах холбооноос өгч байгаа зөвлөмжийн дагуу тухайн улс орны ялангуяа нийгмийн боловсролын түвшний байдлаас нь харгалзаж үзэж энэ opt out аар явах уу, in-ээр явах уу гэдэг энэ асуудал бол зөвлөдөг. Сүүлийн үед эдгээр байгууллага Монгол Улс маань түр зуурдаа in гэдэг системээр явах ёстой юм байна. Цаашдаа out гэдэг систем рүү шилжих шаардлагатай гэдэг зөвлөмжийг ирүүлдэг. Тэр ч үүднээсээ манай энэ хуулийн төсөл дээр хамгийн гол өөрчлөлт бид opt out, opt in гэдэг холимог тогтолцоог оруулж өгч байгаа. Ялангуяа энэ донорын карттай байсан тохиолдолд тухайн гэр бүлд нь танилцуулаад, зөвшөөрөл авах шаардлагагүйгээр эрхтэн, эд, эс авах мэс засал хийх энэ зохицуулалтууд оруулж өгсөн байгаа. Эдгээр асуудал бол дэлхийн улс орнуудад нийт эрхтэн шилжүүлэн суулгалтын 90 гаруй хувь нь амьгүй донороос, 10 гаруй хувь нь амьд донороос хийгддэг бол энэ Монголд эсрэгээрээ байгаа. Энэ асуудлыг шийдсэнээр.../минут дуусав/

С.Бямбацогт: Отгоншарын Батнайрамдал гишүүн нэмж асууя.

О.Батнайрамдал: Олон улсын байгууллагуудаас зөвлөмжид нь тусгасан гэж хэлж байх шиг байна. Тэгэхээр энэ асуудлын ард нь дандаа хүний амь яригддаг учраас бидний цаг хугацаа хойшлох тусам л аварч болох байсан амь тэр чинээгээрээ багасна гэсэн үг л дээ. Тэгэхээр яах вэ энэ эдийн засгийн шинжлэх ухаан дээр ялангуяа энэ сүүлийн шинжлэх ухаан л даа 2024 оны Нобелийн шагналт Richard H.Thaler гээд зан төлөвийн эдийн засагч байдаг. Тэгээд энэ хүний гаргасан тэр концептынхоо хамгийн сонгодог жишээ дээр яг энэ гарч ирдэг байхгүй юу. Тэгэхээр хүмүүсийн хийдэг сонголтыг илүү ёвроод маш амархнаар үр дүн гаргах боломжтой жишээнүүд яг энэ дээр гардаг. Тэгэхээр ер нь нэг хугацаа алдалгүйгээр цаашдаа opt out систем рүү орох нь зөв л гэж бодож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Үг хэллээ. Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Хууль санаачлагчийн хувьд ажлын хэсгээс ганц, хоёр зүйл тодруулах гэсэн юм. Би Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар 2020-оос 22 онд ажиллах ийм завшаан тохиож байсан. Тэгээд 2020 онд Чинбүрэн гавьяат эмч тухайн үедээ анх удаа Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдоод, яг энэ эрүүл мэндийн салбарт маш их өөрчлөлтүүдийг хийж, хуулийг санаачилж ажиллаж ирсэн. Тухайн үед бид яаман дээр уулзалтыг зохион байгуулаад тухайн үед чинь ямар сэдвээр уулзаж байлаа даа, үгүй ээ нийгмийн даатгал биш байсан. Тухайн үед бид чинь нөгөө групп тогтоолтыг илүү сайжруулах, хяналт шалгалт явуулах ийм сэдвээр уулзаж байсан. Тэгээд яг энэ үеэрээ бид яг энэ Эд, эс, эрхтэн шилжүүлэх хууль өөрөө донорын, цусны донортой Цусны хуультайгаа нэг байсан. Тухайн үедээ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ийм төслийг өргөн барьсан байсан. Насны хязгаарыг 25 байсныг 21 болгох, мөн түүнчлэн яг энэ урамшууллын асуудлыг буюу амьгүй донорын ар гэр нь тухайн амьгүй тархины үхжилттэй байгаа тэр хүнийг донороор нь шилжүүлэхэд илүү тийм хөшүүрэг гэдэг юм уу, эсвэл талархал гэдэг юм уу яг энэ олон улсын энэ юу гэдэг юм аргачлалыг гэдэг юм уу энэ хэлбэрийг Монголдоо нэвтрүүлэх ийм анхны оролдлого хийгдэж байсан.

Харамсалтай нь 21 онд УИХ-аар бол ердөөсөө энэ талархлын урамшуулал, энэ санхүүжилтийг бол шийдээгүй. Тухайн үед ердөөсөө ойлгоогүй, ингээд буцаасан байдаг. Гэхдээ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бол яг Чинбүрэн гишүүнтэй ярилцаж байсныхаа дагуу энэ бол маш чухал асуудал юм, олон улсад байдаг асуудал юм. Бид ядаж өөрийнхөө байгаа эрх мэдлийнхээ хүрээнд шийдвэрлэх боломжтой энэ оршуулгын тэтгэмж дээр нь тодорхой хэмжээнд ердийн оршуулгын тэтгэмжээс илүү авч үзэх ийм арга хэлбэрийг хайя гэж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдааны шийдвэрээр нийгмийн даатгалын санд төлж байгаа шимтгэл төлөгчийн харилцаанд орсон аливаа хүн амьгүй донор болсон энэ тохиолдолд оршуулгын тэтгэмжийг нь нэмэгдүүлье. Ердийн оршуулгын тэтгэмж тухайн үед 2 сая төгрөг, амьгүй донор бол 3,5 сая төгрөг байна гэж бид тухайн үедээ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөрөө шийдвэрлэж байсан.

Үүний улмаар тодорхой хэмжээнд бага зэрэг идэвхжих гэдэг юм уу, бага зэрэг таниулах гэдэг юм уу ийм ажиллагаа явсан. Харамсалтай нь Батчулуун эмч маань ямар асуудал тухайн үедээ үүсэж байсан бэ гэхлээр Нийгмийн даатгалын сангаас бол нийгмийн даатгалын харилцаанд орсон хүний л энэ оршуулгын тэтгэмжийг олгодог. Тэрнээс биш нийгмийн даатгалын харилцаанд ороогүй хүнд бол нийгмийн даатгалын сангаас аливаа тэтгэвэр, тэтгэмж ямар ч ийм юу гэдэг юм олговор ердөөсөө олгогддоггүй. Энэ бол угаасаа хуулиараа ч тэр. Тэгэхээр энэ агуулгаараа одоо бол Нийгмийн даатгалын сангийн харилцаанд орсон хүмүүс оршуулгын тэтгэмжээ нийгмийн даатгалын сангаасаа авдаг. Нөгөө талдаа зохицуулагдаагүй байсан харилцааг ЭМЯ, Эрүүл мэндийн сайд өөрөө энэ тушаалаа гаргаж Дэмжих сангаасаа олгоод явж байгаа. Энэ хууль дээр бол одоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх оршуулгын тэтгэмжийг холбогдох сангаас олгоно гэж заасан байгаа.

Гэтэл энэ маань өөрөө яг ямар санг хэлж байгаа вэ? Дагалдаж өргөн барьсан байгаа хууль дээр бол зөвхөн нийгмийн даатгалын санг л хөндчихсөн байгаад байгаа. Тэгэхээр энийг эрүүл мэндийн даатгал /ЭМД/-ын сан гэж нэгмөсөн харж байна уу, эсхүл нийгмийн даатгалын сан гэж харж байна уу? Зөвхөн нийгмийн даатгалын сан гэж харж байгаа бол энэ хуулийн зөрчил үүсэх буюу нийгмийн даатгалын сангийн энэ харилцаанд ороогүй хүнд хуулиараа бид нар уг нь ямар ч тэтгэмж олгох боломжгүй хэвээрээ байгаа. Тэгэхээр энэ сангийн асуудлыг нэг тодруулж өгөөч гэсэн.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн хариулъя.

С.Эрдэнэбат: Энэ эд, эрхтэн шилжүүлэх энэ асуудалтай холбоотойгоор даатгал төлж байсан уу, төлөөгүй байсан уу гэдэг асуудал жич асуудал гэж бид авч үзсэн. Хуулийн ерөнхийдөө анхны төсөлд даатгал төлж байсан бол даатгалаас, даатгал төлөөгүй байсан бол даатгалыг нь бараг нөхөн төлөх юм шиг ийм зохицуулалт байсан. Тэгэхээр бид авч үзээд энэ хүн амьд бус донор эд, эрхтнээ бусдад өгснийх нь төлөө оршуулгынх нь зардлыг Эрүүл мэндийн дэмжих сан, өөр бусад тэр хуулиуд өөрчлөгдөхөөр юу ч болж болно. Эрүүл мэндийг нь дэмжих сан, бусад сангуудын холбогдох сангуудтай холбоотой асуудлыг нь тухайн хуульд нь зохицуулаад өгчих боломжтой юм. Яг одоо тэр сан, энэ сан гээд тавьчихаар сүүлд нь тэр сан нь байх байхгүй асуудал болчихоор энэ дахиад асуудал үүсэх вий гэдэг үүднээс нь ярьж байгаа юм.

Тийм учраас энэ удаагийн тэр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин гэж оруулсан нь одоо бол 4 сая 500 орчим мянган төгрөгийг өгөхөөр байгаа юм байна лээ. Тэгэхээр дундаж оршуулгын зардлыг аваад үзэхээр ер нь дундаж оршуулгын зардлын 10 сая хавьцаа байдаг ийм судалгааг гаргасан. Энийг нь ерөөсөө тэр хүн жилдээ маш цөөхөн хүн байдаг учраас Эрүүл мэндийг дэмжих сан гэж нэрлэх нь үү, Эрүүл мэндийн тухай хууль болон Сангийн хуулиуд дээр явж байгаатай холбоотойгоор хамгийн зохистой сан нь болохоор ерөөсөө Эрүүл мэндийг дэмжих сан юм байна. Эрүүл мэндийг, даатгалын сан гэвэл энэ өөрөө нэг талаар яг тийм тохиромжтой биш юм болов уу гэдэг үүднээс нь холбогдох гэдэг үгээр оруулсан юм. Тийм учраас ЗГ аль сангаас энийг олгох гэдэг асуудлаа бол дараа нь тэр дүрэм журмаар оруулчих болох байх гэдэг үүднээс нь оруулсан юм гэдгээ хэлмээр байна.

С.Бямбацогт: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Харин уг нь бол яг энэ хууль дээрээ л тодорхой зааж өгч байж үл ойлголцлыг байхгүй болгоно шүү дээ. Тэгээд хууль санаачлагчийн хувьд ажлын хэсэгт орж юм уу, саналаа хэлэх эрх нь байхгүй учраас тухайн үедээ ажлын хэсгийнхээ хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар /НДЕГ/-аас ч гэсэн яг саналуудаа бол өгч байсан, тэгээд, өгч байсан байна лээ. Тэгээд яг энэ дагалдаад өргөн барьсан байгаа хуулийг ердөөсөө огт хөндөөгүй хэвээр нь үлдээчихлээр Эрдэнэбатын саяын хэлсэн асуудал чинь биш болоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь өөрөө эргээд зөрчилтэй байгаад байна. Тэгэхээр агуулгаар нь магадгүй редакцын засвар ч юм уу, эсхүл ийм гарц боломж гарах болов уу, үгүй болов уу гэдгийг ажлын хэсгийн даргад уламжилмаар байна. Тэгээд энийгээ нэг анхаарч өгөөрэй. Тэгэхгүй бол нэг тийм хуулийн зөрчилтэй нэг асуудал үүсэх гээд байна нэг.

2 дахь нь болохлоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах нь ер нь буруу юм байгаа юм шүү дээ. Хэдүүлээ уг нь нэг тодорхой яг нэг дүн байвал илүү зохилтой. Тэгэхгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг олон асуудалтай уялдуулснаар.../минут дуусав/

С.Бямбацогт: Хууль санаачлагчийн хэлж байгаа саналуудыг анхаарах ёстой байх, манай ажлын хэсэг анхааралдаа аваарай. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Би асуулт асууя. Энэ эд, эрхтэн, эс шилжүүлэн суулгах ажиллагаа нь орчин үеийн анагаахын хамгийн үр дүнтэй эмчилгээний нэг арга боловч үүний зэрэгцээ хүний эрхийн хувьд хамгийн эмзэг зохицуулалт шаарддаг. Бүтэн ийм хүний эрхийн тогтолцоо шаарддаг ийм байдгаараа онцлог байдаг. Тэгэхээр яах вэ би нөгөө ажлын хэсгийн сая бүрэлдэхүүн гээд танилцуулж байхад яг хүний эрхийн чиглэлийн хүмүүс танай ажлын хэсэгт ажиллав уу? Үүнтэй холбоотой яг энэ хуулийн төсөл дээр далан хэдэн нэмэлт зарчмын зөрүүтэй санал орж ирж байна. Бүхэлд нь бүтнээр нь хүний эрхийн дүн шинжилгээ хийлгэв үү гэсэн нэг ийм асуулт байна?

2 дугаарт энэ шийдвэрийг гаргах нь өөрөө зөвхөн тухайн хувь хүн шийдвэр гаргахаас гадна, гол нь маш сайн мэдлэгтэй, мэдээлэлтэй байж энэ шийдвэрийг гаргах ёстой байдаг. Өөрөөр хэлбэл бидний хэллэгээр нөгөө зөвшөөрөлтэй, мэдээлэлтэй шийдвэр гаргалт гээд байгаа. Тэгэхээр яг тухайн хүнийг энэ бүрэн мэдээлэлтэй шийдвэр гаргалт хийхэд нь энэ хууль дээр ямар, ямар механизм

тусгасан бэ, ямар, ямар үе шаттайгаар хэрхэн, яаж танилцуулах юм бэ, ямар мэдээлэл өгч байж тэр хүн шийдвэрээ гаргахаар энэ хуульд туссан байгаа вэ гэдэг дээр маш тодорхой үе шаттай нь, алхамтай нь ингээд хариулаад өгөөч гэж байгаа юм?

3 дугаар асуулт яг үүнтэй холбоотой. Шийдвэр гаргасны дараа эд, эрхтэнтэй холбоотой мэс засал, ажилбар, янз бүрийн ажиллагаанууд хийгдлээ. Хожим нь энэ нь өөрөө эдийн засгийн шахалт, гэр бүлийн дарамт, өөр ямарваа нэгэн гуравдагч этгээдийн нөлөө байсан эсэхийг шалгадаг хяналтын ийм механизм энэ хуулийн төсөл дээр туссан байгаа юу, үүнийг яг хэрхэн ер нь шалгаж илрүүлнэ гэж харж байгаа вэ гэсэн ийм 3 асуулт байна?

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Индрийн 4 дүгээр микрофон.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг бол яг эмнэл зүйн чиглэлийн ажлын хэсэг, ажлын дэд хэсэг дэмжих ажлын хэсэгт орж ажилласан байгаа. Бид хууль өргөн барьсны дараа Хүний эрхийн Үндэсний Комисс /ХЭҮК/-оос санал авч, холбогдох хэлэлцүүлгийг хийж, заалтуудыг тусгаж ажилласан байгаа.

2 дахь асуулт бүрэн мэдээлэлтэй байдалд нь тусгасан асуудлыг бол яг өнөөдрийн байдлаар энийг илүү журмын зохицуулалтыг хийх шаардлагатай юм байна гэж үзээд журмаар зохицуулах боломжтой юм байна гэж харсан. Одоогийн процесс нь бид амьгүй донорын гэр бүлтэй тархины үхэл батлагдсан тохиолдолд гэр бүлтэй нь уулзаад, холбогдох мэдээллийг өгөөд, яг тархины үхлийг бүрэн ойлгуулсны дараа бид донор болох хүсэлтээ тавьдаг. Ингээд яг хэрвээ зөвшөөрвөл холбогдох маягтад гарын үсэг зуруулж, баталгаажуулж авдаг байгаа. Миний өмнө хэлсэнчлэн тархины үхэл тодорхойлох баг нь өөрийнхөө тархины үхлээ оношилсны дараа гэр бүлийн гишүүдтэй уулзаад, яг энэ хүн маань эмнэлгийн тусламж, үйлчилгээгээрээ иймэрхүү байдал дээр авлаа, одоо яг энэ тархины үхэл нь ийм, ийм оношоор ингээд баталгаажууллаа гээд тархины үхлээ бүрэн гэр бүлд ойлгуулсны дараа манай алба орж уулздаг байгаа.

Гуравдагч нөлөөний асуудлын хувьд гэвэл яг мөн адил журмаар зохицуулах бүрэн боломжтой гэж харсан. Ялангуяа амьд донорын энэ асуудал дээр хуулийн төслийн нэр томъёоны тайлбараар амьд донорын энэ асуудлыг тодорхой тусгасан байгаа. Сайн дураараа, бие даасан өөрөө шийдвэр гаргасан энэ тохиолдолд гэсэн заалтууд байгаа. Тэгээд энийг бид ялангуяа манай зохицуулах алба амьд донортой нь уулзаад, холбогдох өргөдөл энэ маягтуудыг яг та өөрөө сайн дураар гаргасан уу, ямар нэгэн ах, дүү, хамаатан садан, аав, ээжийнхээ дарамт шахалтын үндсэн дээр бусдад амьд донор болох гээд байна уу гэдэг энэ асуудлыг манай албаны зүгээс уулзаад, тухайн амьд донороор нь хүсэлтийг нь бичүүлж ингэж авдаг байгаа.

С.Бямбацогт: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн тодруулж асууя.

Х.Баасанжаргал: Журмаар зохицуулна гэж ийм чухал асуудлыг нээлттэй үлдээх нь хэр оновчтой юм доо гэдэг дээр ажлын хэсэг хариулаарай. Тэгээд ялангуяа зарчмын шинжтэй асуудлуудаа тусгахгүй бол энэ өөрөө маш эмзэг асуудал. Тэгэхээр бидэнд өмнө нь гарч байсан зөндөө олон кейсүүд ч байгаа, өөр бусад улс орны туршлагауд ч байгаа. Тэгэхээр энийг журмаар зохицуулах гэдэг дээр би яг хувьдаа бол жаахан эргэлзэж байна. Тэр дундаа, ялангуяа тархины, жишээ

авъя л даа сая та өөрөө нөгөө тархины үхжилттэй донорын тухайд ярьсан учраас. Тархины үхжилттэй гэдгийг ойлгуулна ар гэрийнхэнд нь ойлгуулна гэдэг нь өөрөө ямар процесс юм бэ, хэр удаан үргэлжлэх юм бэ, ямар, ямар мэдээлэл өгснөөрөө тэр хүн зөвшөөрснийг нь энэ хүн үнэхээр бүрэн мэдээлэлтэй байлаа гэдгийг нь яг ямар процессыг хэлээд байгаа юм гээд байгаа байхгүй юу? Яг үүнтэй холбоотой дахиад нөгөө хожим нь гээд байгаа юм. Тухайн үедээ тэр хүн зөвшөөрөөд ямарваа нэгэн байдлаар илрэхгүйгээр эдийн засгийн.../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа гүйцээгээд асуучихъя Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Хожим нь ямарваа нэгэн эдийн засаг, гэр бүлийн дарамт, шахалт, эдийн засгийн дарамттай холбоотой ийм шийдвэр гаргачихсан гэдгийг нь илрүүлэх ямар механизм ажиллах вэ? Тэрнээс та бүхэнтэй уулзаад, өөрөө өргөдлөө гараар бичих чинь өөрөө механизм биш байхгүй юу. ISO стандарт өөр янз бүрийн хяналтын механизмууд байгаа шүү дээ. Тэгэхээр тэр хяналтын механизм яаж ажиллах вэ гэдгийг нь тодруулаад байгаа. Тэрнээс яг ийм хүн хоорондын харилцаагаар, итгэлцлээр явах ажил энэ ерөөсөө биш байхгүй юу. Тэгэхээр тэр талаас нь яг механизмаа юу гэж харж байгаа вэ гэж асуугаад байгаа юм.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Баасанжаргал гишүүний асуултад нэмж хариулъя. Бид яг гэр бүлтэй уулзаж байх явцад ер нь энэ амьгүй донорын бүрэн ойлголттой байгаа талаараа нэмж ойлгуулдаг байгаа. Ер нь энэ амьгүй донорын шалтгаан нь осол гэмтлийн шалтгаан буюу мөн тархины цус харвалтын шалтгаанаас тухайн эмчлүүлэгч маань амь нас аврах тусламж, үйлчилгээг бүрэн гүйцэтгэсний дараа тархины үхэл нь бүрэн батлагдсан энэ үеийг хэлдэг. Тархины үхэл нь бол ямар ч эргэж сэргэхгүй ийм өөрчлөлт байдаг гэдгийг холбогдох шинжилгээ болон багажийн шинжилгээнүүдээр нарийн тодруулдаг байгаа. Энийг тодруулдаг баг нь тархины үхэлд тодорхойлох баг. Ингээд одоо бол энэ эмчлүүлэгч маань амьсгал зүрх судасны системийг нэг ёсондоо хиймлээр ажиллуулж байгаа энэ үеийг бид тархины үхэл гэж нэрлэдэг. Энийг олон улсдаа бол мөн үхэл гэж зарладаг байгаа гэдгийг гэр бүлд нь ойлгуулдаг байгаа. Тэгэхдээ энэ амьгүй донорын гэр бүлтэй нь уулзах энэ процесс маань бол цаг хугацаанаас үл хамаараад, өдөр, шөнө ч гэдэг юм уу эдгээр хугацаанаас үл хамаараад ямар нэгэн байдлаар цаг хугацааг богино хугацаанд үргэлжлүүлэх ийм шаардлагууд.../минут дуусав/

С.Бямбацогт: Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Бидний Улсын Их Хурлын үе үеийн Улсын Их Хурлын баталсан хуулиуд нэг зүйлээ л их орхигдуулаад байдаг. Нөгөө процессынхоо хуулийг нь, процессыг нь хуульжуулах асуудал дээрээ их дутмаг байгаагаас болоод журам, дүрэм, стандарт гэдэг зүйлүүд нь алдагдаад, тэгээд нөгөө эрх олгогдсон төрийн захиргааны юм уу, төрийн байгууллагууд нь гүйцэж давахын аргагүй ийм зүйлүүд болгоод хувиргачихдаг. Энэ нь өөрөө эргээд янз бүрийн ашиг сонирхол ордог, янз бүрийн зүйл ордог ийм зүйлүүд болоод байгаа юм. Тэгэхээр энэ хуулиа процессынхоо асуудал дээр нь яаж анхаарах вэ гэдэг зүйл байна нэг?

2-т нь энэ хуулийн төсөл дээр өмнөх хуулийнхаа аль зохицуулалтыг илүү сайжруулаад, яг алийг нь хасчхаад байгаа вэ гэдэг дээр ер нь нэлээн өргөн болгож байгаа гэж ойлгож байгаа. Түүнээсээ хассан зүйл байгаа юу, үгүй юү гэж байна?

3-д нь донорын зохицуулалтыг өөрчилснөөрөө иргэний нөгөө бие махбодын халдашгүй байдлын эрх хэрхэн хамгаалагдах вэ? Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд арилжааны шинж орох эрсдэлээс хэрхэн сэргийлж байгаа вэ хууль маань? Монгол Улсад эрхтэн шилжүүлэн суулгах үйлчилгээний эмнэлгийн бэлэн байдал буюу нөгөө хүний нөөц, тоног төхөөрөмж хангалттай байгаа юу, үгүй юү гэдэг асуудал байна. Хүүхдэд эрхтэн шилжүүлэн суулгах үйлчилгээ нэвтрүүлэхэд эрсдэл, стандарт, санхүүжилтийн эх үүсвэр энэ нэг хүүхдийн асуудлууд дээр ер нь бэлэн байж чадаж байгаа юу? Аймаг, орон нутагт, хөдөө, орон нутагт энэ үйлчилгээг хүргэх боломж нь хуулиараа ямар байх юм бэ, үгүй бол энэ төвлөрсөн хэвээрээ байгаад байх юм уу гэдэг ийм зүйлүүдийг асуумаар байна?

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Индрийн 4 дүгээр микрофон.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Батбаатар гишүүний асуултад хариулъя. Бид энэ өмнө мөрдөгдөж байгаа Донорын тухай хууль дээр одоо Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай бие даасан анхдагч хуулийн төсөл дээр нэлээн том, том зохицуулалтыг оруулж өгсөн байгаа. Ялангуяа бид өмнө нь зөвхөн донорын насыг 21 насаар хязгаарлаж байсан бол бид энэ шинэ зохицуулалтаараа жишээ нь амьгүй донор дээр бол ямар нэгэн насны хязгаар тавихгүй. Амьд донор нь уул нь насны 21 нас хүрсэн байна. Эсийн донор дээр 18 нас хүрсэн байна гэдэг эдгээр зохицуулалтуудыг мөн тусгасан.

2 дахь нь би түрүүн хэлсэнчлэн opt out, opt in гэдэг холимог тогтолцоо, донорын карттай байсан тохиолдолд гэр бүлд нь зөвшөөрөл авах шаардлагагүйгээр танилцуулаад эрхтэн, эд, эс авах энэ зохицуулалт оруулж өгсөн. Хамгийн гол зохицуулалт нь одоогийн байгаа хууль дээр манай Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаа зохицуулах албаны энэ статусын асуудал маань тусдаа тусгай мэргэжлийн төв болох энэ асуудал байгаа. Ингээд тусгай мэргэжлийн төв болсноороо бид эдгээр бүх энэ хяналт бүрэн энэ тогтолцоог хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм байна гэж мөн харсан байгаа.

Донорын халдашгүй байдал энэ арилжааны асуудал бол миний өмнө хэлсэнчлэн бид Станбулын тунхаглалд нэгдэж орсон учраас эдгээр холбогдох заалтуудыг бид хуулийн төсөлдөө мөн тусгаж ингэж ажиллаж байгаа. Ингээд эдгээр зарчмуудыг зөрчсөн тохиолдолд холбогдох Эрүүгийн хууль ч гэдэг юм уу эдгээр хуулиар бол мөн шийдэгдэх ийм байдалтай байгаа.

Хүүхдэд эрхтэн шилжүүлэн суулгах асуудал маань бид энэ төсөлд оруулаад, хүүхдэд эрхтэн шилжүүлэн суулгасан тохиолдолд энэ ЭМД-ын сангаасаа холбогдох хууль тогтоомжоосоо бол зохицуулна гэсэн зохицуулалт байгаа.

Аймгийн эрхтэн, аймаг, бүсийн оношилгооны эмчилгээний төв дээр эрхтэн шилжүүлэн суулгах боломжийн асуудал дээр бол ДЭМБ, Дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах холбооноос өгч байгаа зөвлөмжийн дагуу 2 сая хүн амд нэг эрхтэн шилжүүлэн суулгах төв байна гэж заасан байдаг. Эдгээр хүрээндээ бо бид эрхтэн шилжүүлэн суулгах төв одоогийн байгаа 6 эрүүл мэндийн байгууллагаар хязгаарлагдана. Харин энэ 6 эрүүл мэндийн байгууллагын эрхтэн шилжүүлэн

суулгах эмчилгээний үр дүнгийн асуудлаас нь хамаараад тухайн эрүүл мэндийн байгууллагад эрхтэн шилжүүлэн суулгахыг цаашид үргэлжлүүлэх үү, эсвэл зогсоох уу, эсвэл нээх үү гэдэг асуудлыг энэ тусгай мэргэжлийн төв маань зохицуулахаар оруулсан байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагайн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн 12В ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хэдхэн хоногийн дараа та бүхэн амьдралынхаа нэгэн гэгээн хуудсыг хааж, аав, ээжийнхээ гэрээс гарч, хүссэн мэргэжлээрээ, хүссэн сургуульдаа орж, амьдралын их далайд хөл тавина. Монгол Улсдаа хэрэгтэй, Монгол Улсынхаа хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулсан дэлхийн иргэн болоорой гэж та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Батын Батбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Батбаатар: Тэр 6 эмнэлэг бэлэн байгаа гэж ойлгож байгаа юм байна. Энэ хуулийн чинь 23-аас 26 дугаар зүйлүүд нь нөгөө Эрхтэн шилжүүлэн суулгах тогтолцооныхоо хамгийн эмзэг, хамгийн чухал хэсэг болох тэр санхүүжилт, хяналт, ёс зүйн асуудлууд гээд ингээд яригдаад байдаг энэнтэйгээ холбоотой байна. Тэгээд үүн дээр чинь нөгөө амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмжийг дэмжиж байгаа чинь жаахан зөв бодлоготой явахгүй бол нөгөө далд урамшууллын хэлбэр лүү орчих тийм эрсдэл дагуулах боломжтой байгааг нэг анхаармаар юм байна гэж санагдсан. Тэгээд дээрээс нь энэ хяналтын тогтолцоо одоо байгаа энэ төсөл дээр харьцангуй сул байна л гэж харагдаад байгаа юм. Зөвхөн яамандаа хяналтаа төвлөрүүлэх биш, бие даасан, ил тод тийм хариуцлагатай хяналтын ямар нэг механизм хийх боломж цаашид гарна гэж үзэх үү?

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон хариулъя.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Батбаатар гишүүний асуултад хариулъя. Амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмжийн энэ асуудал бол яг олон улсдаа ч гэсэн байдаг ийм асуудал. Ялангуяа Бүгд Найрамдах Солонгос хэрвээ амьгүй донор болсон тохиолдолд холбогдох энэ оршуулгын зардлыг тухайн гэр бүлд болон эсвэл оршуулга зохион байгуулагч энэ байгууллагад олгох энэ асуудал байдаг. Бид 18 онд байгуулагдсанаас хойш өнөөдрийг хүртэл гэр бүлтэй нь уулзах явцад тухайн гэр бүлд нь үнэхээр энэ оршуулгын зардлыг зохицуулах энэ асуудлыг бол бид олж хараад, энийг олон улсад ямархуу байдалтай байдаг юм гэдгийг судалж үзсэний үндсэн дээр энэ хуулийн төсөлдөө бол тусгасан байгаа. Тэгэхээрээ яг өнөөдрийн байдлаар энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан 22 оны 04 дүгээр тогтоол, 23 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлснээс хойш яг бол халамжийн энэ сангаас нийт 6 хүнд оршуулгын тэтгэмжийг өгсөн байна. Даатгал төлөөгүй байсан тохиолдолд энэ Эрүүл мэндийн дэмжих сан.../минут дуусав/

С.Бямбацогт: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуултаа асууя, алга байна. Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя.

М.Мандхай: Эд, эрхтэн шилжүүлэх тухай хууль Монгол Улсад маш чухал хууль гэж бодож байгаа. Ялангуяа хүн ам ийм цөөн, хүн амынхаа эрүүл байдлыг хангаж, хүн амынхаа өсөж хөгжих энэ нөхцөл байдалд бид Монгол Улс үндэсний аюулгүй байдлын түвшинд анхаарч ажилладаг учраас бидэнд яг энэ хууль өөрийн

гэсэн олон улсын стандартад нийцсэн, илүү энийг хөгжүүлэхийн төлөө ажиллах шаардлагатай байгаа учраас энэ хуулийг санаачлаад явж байгаа хуульч санаачлагч болон энийг ажлын хэсэг нэлээн нарийн сууж, зарчмын зөрүүтэй санал гаргаж, энэ хуулийн илүү сайжруулж ажиллахад ажилласан энэ ажлын хэсэгтээ талархал илэрхийлье.

Ер нь яах вэ эд, эс, эрхтэн шилжүүлэхэд донор олоод, ингээд эд, эрхтэн шилжүүлээ гэж бодлоо, хамгийн чухал юм бол энэний дараа гарах үр дагавар. Энэний дараа авах нөгөө уртын эмчилгээ, үүнд холбогдох зардал, энэ нөөц бололцоо ер нь яг ямар байгаа вэ? Донор жишээлбэл шилжүүлчхээд, гадаадад очиж байнгын сар болгон явж үзүүлдэг, шинжилгээ хийлгэдэг, эмчилгээ хийлгэдэг, хяналтад байдаг энэ маш их өндөр зардалтай. Нэг удаа донор оллоо, донороо олоод шилжүүлээд суулгачихлаа, цаана нь нөгөөгөө ингээд амьд урт хугацаанд байлгах тэр процесс чинь өөрөө хамгийн өндөр зардалтай, хүндрэлтэй байдаг. Энэ дээр энэ хууль хэрхэн зохицуулж байгаа вэ? Үүнтэй холбоотойгоор зардал, санхүүгийн энэ нөхөн олговор, төлбөрүүдийг яаж шийдэж байгаа вэ гэдэг нэг асуултад хариулж өгөөч?

2 дугаарт энэ эрхтэн шилжүүлэн суулгах үйлчилгээний үнийн зохицуулалтыг инфляц, валютын ханштай уялдах нь хэр оновчтой гэж үзэж байгаа вэ? Энэ дээр асуулт асууя.

Мөн хувийн хэвшлийн оролцоог энэ нэмэгдүүлэх бас энэ эдийн засгийн хөшүүргийг магадгүй нөгөө төр, хувийн хэвшлийн түншлэлийн зүгээс ч юм уу, татварын хөнгөлөлт гэх мэт энэ асуудлууд тусгагдсан байгаа юу гэдэг асуултыг эхлээд асуучхаад, тэгээд дараа нь тодруулъя.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Баярмагнайн Баярбаатар гишүүн хариулъя.

Б.Баярбаатар: Мандхай гишүүний асуултад хариулъя. Тийм бидний хийсэн судалгаагаар ийм байгаа юм Мандхай гишүүнээ. Эрхтэн шилжүүлэх шаардлагатай реципиент өвчтөн, эрхтэн шилжүүлэх мэс засалд орох хүртлээ харин зардал нь өсөж байдаг нөгөө эмчилгээний зардал нь. Ингээд эрхтэн шилжүүлээд суулгаснаас хойш буурч байгаа ийм үзүүлэлтүүд гарч байгаа. Дархлаа дарангуйлах эмийг насан туршдаа хэрэглэнэ. Энийг төр тааж байгаа манай хуулийн зохицуулалтаар, өнөөдөр ч хэрэгжээд явж байгаа. Өнөөдөр энэ бидний төсөл дээр ч гэсэн энэ ингээд суучихсан явж байгаа.

Тэгэхээр цаашлаад эрхтэн шилжүүлээд суулгасны дараах эмчилгээний зардал нь төр хариуцаж байгаа. Дээр нь тухайн өвчтөн ямар нэгэн тийм санхүүгийн дарамт нь эрхтэн шилжүүлж суулгахаас өмнөх үеийн зардал сүүлийн үеийн зардлыг харьцуулсан судалгаагаар үзэхэд ингээд яг уул руу ингээд авираад буцаад бууж байгаа юм шиг ингэж бууж байгаа ийм судалгааг ажлын хэсгийн түвшинд бид хийгээд, ажлын хэсгийн түвшиндээ энийгээ яриад, энэ хуулийн зүйл, заалтдаа тусгаад оруулсан байж байгаа. 2 асуултад нь Алтантулга дарга хариулчих уу.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Мандхай гишүүний асуултад хариулъя. Ялангуяа энэ асуудлыг хөндсөнд баярлалаа. Энэ эрхтэн

шилжүүлэн суулгах эмчилгээний энэ дараах хяналт, тэр дундаа дархлаа дарангуйлах эмийн энэ асуудал бол маш чухал байдаг. Өмнө болон одоо мөрдөгдөж байгаа энэ хууль дээрээ ч гэсэн бид энэ дархлаа дарангуйлах эмийн энэ асуудлыг улсын төсвөөс зохицуулна гэж энэ заалтуудыг оруулж өгсөн. Тэр дундаа яг өнөөдрийн байдлаар 2025 оны хувьд гэвэл 6,2 тэрбум төгрөгийг нийт 1366 эрхтэн шилжүүлэн суулгах эмчлүүлэгдээд олгож байгаа энэ асуудлууд байгаа. Тэгэхээр энийг бол улсын төсөвт оруулснаараа эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний үр дүнг бол яг маш дээшлүүлж өгч байгаа.

Олон улсад бол зарим асуудлыг хамтын төлбөрийн асуудлаар зохицуулж өгч байсан боловч одоо бол яг энэ улсын төсөв рүү зохицуулах нь энэ эмчилгээний үр дүнд бол маш эерэг үр дүнтэй юм байна гээд энэ эдгээр улс орнууд шилжиж орж байгаа байна. Хувийн хэвшлийн энэ тогтолцооны асуудал.../минут дуусав/

С.Бямбацогт: Үргэлжлээд хариулчихъя, хариултаа дуусгачихъя.

Б.Алтантулга: Хувийн хэвшлийн тогтолцоо нь ялангуяа эс шилжүүлэн суулгах эмчилгээний энэ тогтолцоо дээр бүрэн нээлттэй. Тэр дундаа өнөөдөр үр шилжүүлэн суулгах эрүүл мэндийн байгууллагын хувьд 5 байгууллага байна. Эдгээрийн 4 нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, 1 эрүүл мэндийн байгууллага нь улсын эрүүл мэндийн байгууллага ажиллаж байна. Тэр дундаа бид шинэ хуулийн төсөлдөө бид үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээний технологийн асуудлыг оруулж ирсэн. Тэр дундаа энэ био банк, үүдэл эсээс хэрхэн эмчилгээний энэ харилцааг хэрхэн зохицуулах энэ асуудлыг тусгаж өгсөн байгаа.

С.Бямбацогт: Мэндбаярын Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Тэгэхлээр нөгөө дархлаа дарангуйлах эмийн санхүүжилт улсын төсвөөс хамааралтай юм байна. Тэгэхлээр яах вэ түрүүн би дахиад л нөгөө нэг түрүүн хэлсэн л дээ. Ерөнхийдөө энэ үнийн зохицуулалт инфляц нэмэгдэнэ, тэр хэмжээгээр энэ дархлаа дарангуйлах эмийн санхүүжилт улсын төсвөөс хамааралтай учраас өсөн нэмэгдэх ийм эрсдэлтэй тийм ээ жил болгон. 1 дүгээрт энэ асуудлыг яаж ерөнхийдөө харж байгаа вэ? Цаашдаа ингээд улсын төсвөөс хамааралтай байх тусам энэ зардал нэмэгдээд явна. Энэ улсын төсөвт дарамт учрахгүй юу гэдэг 1 дүгээрт асуулт байна?

2 дугаарт хэрэв дархлаа дарангуйлах эмийн санхүүжилт улсын төсвөөс хамааралтай бол нөгөө талдаа эрсдэлтэй байгаад байгаа юм. Яагаад гэхлээр тогтвортой өсөж нэмэгдэх үр дүн гараад байгаа бол энэний санхүүжилтийг нэмэх шаардлага хэрэгцээ үүсээд байна. Тэгэхлээр энэ өөрөө хэр тогтвортой явах вэ гэдэг асуулт гарч ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр би улсын төсвөөс хамааралтай болохоор энэнээс өөр шийдлийг тооцож үзсэн үү? Хэрэв ингээд.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариулъя, ажлын хэсэг хариулчихъя, 4 дүгээр микрофон.

М.Наранпүрэв: ЭМЯ Наранпүрэв. Мандхай гишүүний асуултад хариулъя. Эрхтэн шилжүүлэн суулгах хагалгааны дараах эмчилгээний асуудал байгаа хүндрэл болон бусад эмийн зохицуулалт байгаа. Эмийн зохицуулалтыг түрүүн хэлсэнчлэн төрөөс даахаар зохицуулалттай байгаа. Нөгөө талаас инфляцтай уялдуулаад ЭМД-ын тогтолцоогоороо тухайн эмчилгээ дээр бол ЭМД-ын сангаасаа эмчилгээнийх нь зардлыг зохицуулдаг DRG-ээрээ зохицуулдаг байгаа.

С.Бямбацогт: Салдангийн Одонтуяа гишүүн асуултаа асууя.

С.Одонтуяа: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Энэ 68 саналын томъёололтой юм байна. Их Хурлын дарга анхаараад, энэ 68 саналын томъёолол дээр гишүүд идэвхтэй оролцохгүй бол ганц нэг санал унавал энэ өөрөө хуулийн юу алдагдах эрсдэлтэй байгаа. Өмнөх парламент дээр Чинбүрэн гишүүн бид 2 энэ хуулийн төслийг өргөн барьсан. Цаг хугацааны хувьд батлуулж амжаагүй. Тэгээд дахиад орж ирж байгаад баяртай байна. Ер нь энэ хууль батлагдсанаар олон хүний амь аврах, энэ эрсдэл бол буурах юм сайжрах юм.

Монгол Улсад амьд донороос эрхтэн, эд, эс шилжүүлэх, суулгах ажлыг амжилттай хэрэгжүүлээд багагүй хугацаа өнгөрч байгаа. Гэхдээ сүүлийн жилүүдэд энэ дэлхийн улс орнууд аль болохоор амьгүй донороос эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгахад анхаарлаа хандуулж байгаа. Тэгэхээр манайд өмнө нь энэ амьгүй донороос эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах ажил хууль, эрх зүйн зохицуулалт тодорхой бус явж ирснээс олон бэрхшээл тулгарч ирсэн. Энэ зовлонг биеэр амссан манай төрийн соёрхолт гавьяат эмч Батчулуун доктор ажлын хэсэгт ороод, ингээд ажиллаж байгаад их баяртай байна. Мөн туршлагатай доктор манай Оюундэлгэр эмч байна.

Би нэг зүйлийг асуух гэсэн юм. 4.1.18 дээр энэ хүйн эд гэж нярайн хүү таслагдсаны дараа ихэстэй залгаа хэсгээс тайран авсан хүйн судсыг хэлнэ гээд. Тэгээд энэ 4.1.18 дээр зүгээр нэр томъёоны юу байхаас энэ асуудлыг хэрхэн шийдэхээр оруулж ирсэн бэ? Би хуулиас хайгаад олсонгүй. Бүгд Найрамдах Хятад Ард улс /БНХАУ/ сүүлийн жилүүдэд яг энэ аргаар маш олон өвчнийг эмчлээд явж байгаа. Жишээлэхэд чихрийн шижинг яг бүрэн эмчилж байна үүдэл эсээр. Сүүлийн үед энэ аутизмтай хүүхдүүдийг энэ чиглэлээр эмнээд явж байгаа. Тэгэхээр энэ яаж энэ асуудлыг хэрхэн энэ хуульд оруулж өгсөн юм бэ гэдгийг асуух гэсэн юм? Ер нь бид энэ бол хамгийн үр дүнтэй аргуудын нэг гэж өөрсдөө бол Хятадууд үзэж байгаа юм байна лээ. Энэ дээрээ бүүр банк байгуулчихсан ингээд ажиллаж байгаа.

2 дугаарт энэ хэрэгжих хугацаа нь хэзээ юм бэ? Би хайгаад олсонгүй. Хэрэгжих хугацаа жоохон тавиу байхгүй бол маш олон журам хэлэлцэх юм байна шүү дээ, бичих юм байна шүү дээ. Ялангуяа энэ бүртгэл мэдээлэл нь ямар байх юм, үүдэл эсийг эмчилгээнд ашиглахдаа хадгалах, тээвэрлэх нь ямар байх юм, амьд болон амьгүй донороос эрхтэн, эд, эс авахдаа энэ тээвэрлэх, шилжүүлэн суулгахыг хэрхэн хянах юм гээд ингээд маш олон журам хэлэлцэх юм байна л даа. Тэгэхээр энэ журмууд бол энэ хуулийнхаа агуулгатай яв цав тохирч байх ёстой.

Дээрээс нь түрүүн гишүүд хэлж байна. Энэ хууль батлагдахаар ард иргэдэд энэ мэдээллийг нэлээн сайн зөв ойлгуулах талаар ажиллах ёстой. Олон нийт, хэвлэл мэдээлэл, энэ төрийн бус байгууллагууд гээд ингээд их олон талаас энэ дээр хамтарч ажиллах шаардлагатай байгаа юм. Тэгээд энэ талаар хариултуудаа авъя.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Баярмагнай Баярбаатар гишүүн хариулъя. Дараад нь ажлын хэсэг бэлдэж байгаарай.

Б.Баярбаатар: Би эхлээд хариулчихъя. Манай хууль бие даасан анхдагч хуулийн хувьд нэлээн дэвшилтэт бодлогуудыг оруулж ирсэн. Та өмнө нь, өмнөх парламент дээр энэ хуулийн төслийг Чинбүрэн гишүүнтэй хамт өргөн барьж байсны

хувьд агуулга, ач холбогдлын хувьд өндөр ач холбогдол өгч байна гэж харагдаж байгаа.

Хүйн эд, эс нярайн хүйн таслагдсаны дараа ихэстэй залгаа хэсгээс тайран авсан хүйн судсын багцыг гээд. Манай хууль дээр био банк гээд нэг шинэ нэр томьёо орж ирж байгаа. Өнөөдөр ингээд манай урд хөрш энэ талаар бүүр батлаад, хэрэгжүүлээд явж байгаа. Өнөөдөр хүйн эсээсээ нөгөө эсийг хадгалдаг ийм нөхцөл рүү ороод, дараа нь тэр эсээрээ буцаагаад эмчилгээндээ ашигладаг ийм нөхцөл байдал руу орж байгаа учраас манай хуулийн дэвшилтэт тал нь энэ явж байгаа гэдгийг хэлье. Манай Мядагсүрэн эмч энэ дээр нэмээд хариулаарай.

Дараагийн асуудал нь юу гэхээр энэ соён гэгээрүүлэх асуудал өөрөө их чухал байгаа юм. Бид энэ төрийн бус байгууллагуудтай олон хэлэлцүүлгүүдийг энэ хуулийн ажлын хэсгийн түвшиндээ ажиллаад явсан. Ер нь хамтарч ажиллах зайлшгүй шаардлагууд байгаа. Ялангуяа манай хуулийн гол концепц өөрөө энэ амьгүй донорыг илрүүлэх, амьд донороо хамгаалах гэсэн. Тэгэхээр нөгөө амьгүй донорыг илрүүлэхийн тулд тухайн амьгүй донороор бүртгүүлэх, өнөөдөр амьд сэрүүн байгаа донорт бүртгүүлэх, гэр бүлийн гишүүд нь хүлээн зөвшөөрөх гэсэн ийм зүйлүүдийг нэлээн соён гэрлэх түвшиндээ явахгүй бол манай хууль маань амь орох боломж бололцоо өөрөө хумигдаад явчихна.

Анх хуулийн төсөл орж ирэхэд 14 журам батлагдахаар орж ирснийг 7 болгож бууруулж, бусад 7 журмыг нь бол хуульдаа тусгаж өгөөд, процессыг нь оруулаад ингээд явсан. Хууль ердийн хууль батлагдаад ингээд мөрдөгддөг хугацаагаараа мөрдөгдөнө. Агентлаг байсныг нь үндэсний төв болгож өөрчилсөн. Хэрэв агентлаг байсан бол манай хуулийн хэрэгжилт маань ирэх оны 01 сарын 01 рүү татагдах гээд байсан учраас эрүүл мэндийн төрийн захиргааны байгууллагуудтайгаа би зөвлөлдөж байгаад, мэргэжлийн үндэсний төв болгож өөрчилж хуулийн төсөлдөө оруулж ирсэн байгаа. Мядагсүрэн эмч үүдэл эстэй холбоотой асуултад та нэмээд хариулчих.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

С.Мядагсүрэн: Сайн байцгаана уу. Үүдэл эс шилжүүлэн суулгах багийн гишүүн Мядагсүрэн. Үүдэл эс, цусны үүдэл эсийг бид бүхэн цусны өвчний үед эмчилгээний үед хэрэглээд, хэрэглэх зорилгоор энэ хуульдаа тусгасан байгаа. Хүйн цуснаас хүйн мезенхимийн эсийг, мөн түүнээс гадна хүйн эдээс ялгаварлаад өсгөвөрлөөд мезенхимийн үүдэл эсийг эмчилгээнд ашиглах зорилгоор мезенхимийн эсийн эмчилгээг оруулсан байгаа. Био банканд ихэвчлэн цусны үүдэл эсийг, мөн түүнээс гадна мезенхимийн эсийг аль алиныг нь хадгалж болох учраас Био банк гэдэг ухагдахууныг оруулсан. Одоогийн байдлаар мэргэжилтнүүд нь бэлэн, байгуулахаар төлөвлөгдөж байгаа. Үүдэл эсийг цусны үүдэл эсийг болон мезенхимийн үүдэл эсийг боловсруулах өсгөвөрлөх арга аргачлалыг баталсан журам гарсан байгаа.../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа дуусгачихъя 4 дүгээр микрофон.

С.Мядагсүрэн: 2019 оны журмууд батлагдсан байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Хэрэгжих хугацаа асуусан гэнэ, хариулчихъя, 4 дүгээр микрофон. Ажлын хэсгийн ахлагч хариулъя Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Хууль түрүүн би хариултдаа хэлсэн, батлагдаад нөгөө хэрэгжих ердийн хугацаа байгаа шүү дээ, нөгөө хоригийн хугацаа, Төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдэх гээд энэ хугацаанууддаа хамаараад, тэгээд л хэрэгжилт нь хэрэгжээд явна. Энэ бол яаралтай хэрэгжих ёстой хууль. Өнөөдөр би түрүүн хэлсэн 1044 хүн хүлээлгийн жагсаалтад ингээд амь тэмцээд хүлээж байгаа гэдгийг хэлэх нь зөв байх.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалтыг 14 цагаас гэж зарласан байгаа. Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Ариунзаяа, Батсүмбэрэл, Алдаржавхлан нарын гишүүд маш чухал хуулийн төсөл санаачилсан. Ажлын хэсэг Баярбаатар гишүүн ахлагчтай ажлын хэсэг маш сайн ажилласан. 72 зарчмын зөрүүтэй санал гарсан байгаа. Өнөөдөр ингээд Монгол Улсад донор олдохгүйгээсээ болоод өвдөөд зовоод, эд, эрхтнээ зайлшгүй солиулах шаардлагатай болчихсон сая хэлж байна 1044 иргэн донор олдохгүй, хагалгаанд орох гээд хүлээгдэж байна. Амь нас нь өдрөөс өдөрт эрсдэлд учирч байгаа. Боломжтой улсууд нь гадаад, дотоодын улс орнууд руу яваад, мөнгө төгрөгтэй улсууд нь эд, эрхтнээ солиулж ч амждаг. Мөнгө төгрөг, санхүү боломжгүй улсууд маань яах аргагүй энэ эрх зүйн орчныг хүлээж, дотооддоо донор олдох энэ эрх зүйн боломж бий болоосой гэж хүсэж, мөрөөдөж хүлээж байгаа. Тэгээд ийм чухал хуулийг санаачилсан гишүүддээ баярлалаа. Их Хурлын гишүүд маань 14 цагаас санал хураалт 72 санал хураалтад хариуцлагатай оролцож, саналаа өгөхийг хүсье.

Ингээд 3 гишүүн үг хэлэхээр байгаа. Санал хураалтын өмнө дэмжсэн, дэмжээгүй 3 гишүүн үгээ хэлнэ шүү. Их Хурлын гишүүдийг бэлтгэлтэй байгаарай гэдгийг сануулж хэлье.

11.30 цаг

Хоёр.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 2 гишүүн 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. ХАҮТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин, Хассуурийн Ганхуяг нарын гишүүд санаачилсан байгаа. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн нэгж /ААН/, байгууллагуудын худалдаа, үйлдвэрлэлийг дэмжиж, тэдгээрийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилготой ХАҮТ-ын тухай хууль 1995 онд батлагдаж, өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Өнгөрсөн хугацаанд ХАҮТ-ын тухай хуульд бусад хуулийг дагалдуулах байдлаар зарим заалтын нэр томъёог өөрчлөх, найруулгын шинжтэй 4 удаа нэмэлт, өөрчлөлт орсныг эс тооцвол уг хуультай холбоотой тухайлсан өөрчлөлт ороогүй байна. Зах зээлийн шилжилтийн эхэн үед батлагдсан ХАҮТ-ын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт 2021 онд анх удаа үнэлгээ хийсэн бөгөөд үнэлгээний үр

дүн, олон улсын жишиг, бусад орны сайн туршлагыг харьцуулан судалж, ХАҮТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ХАҮТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг дараах байдалтайгаар үнэлсэн байна. 1 дүгээрт, танхим нь ААН, байгууллагуудын хууль ёсны нийтлэг ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах асуудлаар төрийн байгууллагатай харилцах эрх зүйн орчин сул, төрөөс эдийн засгийн бодлого боловсруулахад танхимын оролцох оролцоо тодорхойгүй, нөлөө бага, танхимын тогтолцоог орон нутгийн зарчимд тулгуурлан байгуулах нь практикт хэрэгждэггүй, 21 аймгийн салбар танхимууд бие даан үйл ажиллагаа явуулах чадамжгүй зэргээр үнэлсэн байна.

Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогын 5.2 дахь хэсэгт бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах, эрх ашгийг хамгаалах, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно гэж, 5.5-д иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлнэ гэж тус тус заасан. Эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх, хамгаалах харилцааг зохицуулахаар хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсрууллаа.

Хуулийн төслийг боловсруулахдаа бусад улсуудын ХАҮТ-ын эрх зүйн байдлыг зохицуулсан хууль тогтоомжийг харьцуулан судалж, олон улсын жишиг, Монгол Улсын эдийн засаг, эдийн засгийн төвлөрөл, аж ахуй эрхлэгчдийн саналыг харгалзсан болно. Хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зарчмын өөрчлөлт орохоор тусгалаа.

1.Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар ХАҮТ-ыг орон нутгийн зарчмаар хөгжүүлэхээр зорьсон боловч өнгөрсөн хугацаанд зөвхөн Улаанбаатар хотын худалдааны танхим л байгуулагдсан байна. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний дийлэнх нь Улаанбаатар хотод төвлөрсөн байдлыг харгалзан цаашид танхимыг орон нутгийн зарчмаас гадна эдийн засгийн салбараар нэмж зохион байгуулахаар тусгалаа. ААН-үүд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр салбар танхимдаа нэгдсэнээр тухайн салбарын төлөөлөх чадвар сайжирч, бодлогын судалгаа, тооцоо бодитой болж, бодлогын өмгөөллийн нөлөө сайжирна.

2.Танхим нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчныг сайжруулах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төрийн байгууллагад төлөөлөн илэрхийлэх хамгаалах үндсэн зорилготой. Хуульд заасан энэ зорилгыг, зорилгын хэрэгжилт хангалтгүй байгаа тул эрх зүйн орчныг тодорхой болгож, Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад танхимын төлөөллийг оролцуулах зохицуулалтыг нэмж, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн оролцоог сайжруулахаар хуулийн төсөлд тусгалаа.

3.Улсын бүртгэлийн ерөнхий газар /УБЕГ/-ын мэдээллээс харахад зөвхөн барилгын салбарт 24, аялал жуулчлалын салбарт 80, уул уурхайн салбарт 92, хүнсний салбарт 102 төрийн бус байгууллага /ТББ/, мэргэжлийн холбоод бүртгэлтэй байгаа хэдий ч салбарын нийтлэг эрх ашгийг төлөөлөх чадвартай идэвхтэй үйл

ажиллагаа явуулж байгаа нь тун цөөхөн байна. ХАҮТ-ын тухай хуулийн төсөл нь энэ асуудлыг шийдэхэд бодитой хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Аймаг, нийслэлийн болон эдийн засгийн салбарын танхимууд нь сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдаж, бие даан үйл ажиллагаа явуулах бөгөөд эдгээр салбар танхимууд нь нэгдэж Үндэсний танхимаа бүрдүүлэхээр хуулийн төсөлд тусгасан. Ингэснээр үндэсний ХАҮТ-ыг ААН-үүд биш, салбар танхимууд үүсгэн байгуулж, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг төлөөлөх чадвар сайжирч, эдийн засгийн салбар хоорондын бодлогын уялдаа сайжирна. Мөн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудад салбар танхимын чиг үүргийг шилжүүлж, тухайн салбарт давхар салбарын танхим байгуулахгүй байхаар хуулийн төсөлд тусгасан.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна гэж үзэж байна. 1.ХАҮТ-ын бүтэц, зохион байгуулалт, түүний бүрэн эрх тодорхой болсноор аж ахуй эрхлэгчид ялангуяа жижиг, дунд бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах боломж нэмэгдэнэ. 2.Аймаг, нийслэлийн болон салбарын танхим нь үйл ажиллагаагаа хараат бус, бие даасан байдлаар явуулах санхүүгийн боломж бий болно. Үйл ажиллагааны бие даасан байдал хангагдсанаар аж ахуй эрхлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах явцад ахиц гарах болно. 3.Төрөөс нийгэм, эдийн засгийн бодлого боловсруулахад хувийн хэвшлийн идэвхтэй оролцоо нэмэгдэнэ. ХАҮТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хуулиудад нийцүүлэн боловсруулсан бөгөөд хуулийн төслийг дагалдуулж 1995 оны 10 сарын 24-ний өдөр баталсан ХАҮТ-ын хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ХАҮТ-ын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг боловсруулсан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэж, шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүнд баярлалаа. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралын урилгаар Yes Монгол ТББ-ын СБД-ийн салбар зөвлөлийн гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Залуучууд та бүхэн Монгол Улсынхаа шийдвэр гаргах түвшинд дуу хоолойгоо хүргэх гэж ажиллах, мөн нийгмийн амьдралд ажиглагч, идэвхтэй оролцогч байхыг хүсье. Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

М.Энхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин, Ганхуяг нараас 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн ХАҮТ-ын тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

ХАҮТ-ын тухай хууль 1995 онд батлагдсан, 30 гаруй жил хэрэгжих хугацаанд манай улсын эдийн засаг, хууль эрх зүй, бизнесийн орчин, аж ахуй нэгжийн үйл ажиллагааны чиглэл, засаглал, хэлбэрт томоохон өөрчлөлтүүд гарсан боловч энэ хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд танхим нь ААН, байгууллагуудын хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах эрх зүйн орчин сул, танхимаас төрийн байгууллагад гаргасан саналыг нь хүлээн авах байдал хангалтгүй, аймгийн салбар танхимууд бие даан үйл ажиллагаа явуулах чадамж сул, танхимын тогтолцоог бүс нутгийн зарчимд тулгуурлан байгуулах нь оновчгүй зэрэг дүгнэлтүүд гарсан тул танхимын одоогийн бүтэц, тогтолцоо, гишүүнчлэл, санхүүжилт, зорилт, чиг үүргийг өнөөгийн эдийн засаг, бизнесийн нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөх эрэлт хэрэгцээ шаардлагатай гэж үзэж, хууль санаачлагчдын зүгээс хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан байна. Хуулийн төслийг d.parliament.mn сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар Үндэсний топ ААН-үүдийн бизнесийн үйл ажиллагааг үнэлж, эрэмбэ тогтоодог одоогийн шалгаруулалт, шалгуур үзүүлэлтүүд хэр оновчтой талаар, Үндэсний танхим буюу толгой танхимтай байх ач холбогдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг хуулийн төслийн 26 дугаар зүйлд заасан үндэсний танхим нь гэрээний үндсэн дээр үзүүлдэг үйлчилгээнүүдээ шилжүүлэх зохицуулалт нь одоо үйл ажиллагаа явуулж байгаа танхимууд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжтой эсэх талаар, эсвэл гэрээ хийсний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулах шаардлага байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат хуулийн төсөлд санал авахдаа хуулийн үйлчлэлд эрх ашиг нь хөндөгдөх үйлдвэрчний эвлэлүүдийн саналыг авсан эсэх, танхимын удирдлага, удирдах зөвлөл зэрэг зохион байгуулалттай холбоотой дүрмээр зохицуулах харилцааг хуулиар зохицуулах нь оновчтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Заяабал хуулийн төсөлд ЗГ-аас өгсөн барааны гарал үүслийн гэрчилгээг гаалийн байгууллагад хариуцуулж, гүйцэтгүүлэхийг зөвлөсөн Дэлхийн гаалийн байгууллагын саналын талаар, Монголд үйлдвэрлэв зураасан код шошгыг ашиглан үндэсний бараа, бүтээгдэхүүнүүдийг дуурайлган гадаад улсад үйлдвэрлэж, үндэсний үйлдвэрлэгч дотоодын ААН-үүдийн эрх ашгийг хохироож байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуультай хэрхэн уялдах, жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдийг төлөөлөх эрхийг хэрхэн баталгаажуулсан, улс төрөөс ангид байлгах хуулийн хязгаарлалтыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар, төрийн өмчит компани /ТӨК/-иудыг танхимд хамааруулахгүй байгаа нь хэр оновчтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл олон салбар танхимуудад элсэхэд хураамж төлөлт давхардах эсэх, хариуцлагын тогтолцоо, үндэсний ААН-үүдийг эрэмбэлж байгаа Топ 100 өргөжүүлж, шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, жижиг, дунд, бичил бизнесүүдээ олон нийтэд таниулж, сурталчлах талаар, Улсын Их Хурлын гишүүн Очирбат хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.3, 18 дугаар зүйлийн 18.4-д зааснаар танхим

нь төрийн байгууллагын зарим чиг үүргийг хариуцан хэрэгжүүлэх, төрийн байгууллагын албан тушаалтнаас дэмжлэг, туслалцаа авах зэрэг асуудлыг тусгасан нь зохистой эсэх талаар, танхимын удирдлага улс төрийн намын харьяалалтай, харьяалалгүй байх зохицуулалтыг сайжруулах, гадаад улсад хуурамчаар үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүнд Монголд үйлдвэрлэв зураасан код шошгыг ашиглаж байгаад хэрхэн хяналт тавьж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан танхимд татвар хураамж төлдөг ААН-үүдийн тоо, гишүүнчлэл, жилийн төсөв, түүний хэдэн хувь нь татвар хураамжийн орлого, хэдэн хувь нь бусад орлогын талаарх мэдээлэл, хараат бус, бие даасан институт болох чиглэлд ямар арга хэмжээ авч байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай том групп компаниудын нөлөөллөөс хэрхэн хамгаалах, танхимын Ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн хариуцлагын механизмын талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц үндэсний ААН-үүдийг том байх тусмаа топ шилдэг ААН гэж эрэмбэлэхээсээ илүүтэй салбар танхимууд олон улсын сайн жишгийг нэвтрүүлсэн байдлаар эрэмбэлдэг болох талаар, Улсын Их Хурлын гишүүн Очирбат Монгол Улсын ЗГ-ын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д заасан төрийн гүйцэтгэх чиг үүргийг ТББ-д хариуцуулан гүйцэтгүүлэх, санхүүжүүлэх нь зохисгүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан хууль батлагдаж салбар танхимууд бий болсон тохиолдолд өөрсдийн эрх ашиг, олон янз байдал, үнэт зүйлээрээ эвлэлдэн нэгдсэн байгууллагуудыг хүчээр нэгтгэх нь ардчиллын зарчимд нийцэж байгаа эсэх талаар, одоо үйл ажиллагаа явуулж байгаа эрх ашиг нь хөндөгдөж байгаа талуудын санал, дүгнэлтийг авах талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай хуулийн төслийн үзэл баримтлал, зорилтын талаар, хууль батлагдсанаар ААН, бизнес эрхлэгчид ямар давуу талыг бий болгох, жижиг, дунд бизнес, бичил бизнесүүдийг хэрхэн хамгаалах, том групп компаниудыг охин компаниудын хамт танхимд гишүүнээр элсдэг явдлыг хязгаарлах зохицуулалтуудыг хуульд нэмэлт тусгах, хуулийн төслийг сайжруулах шаардлагатай талаар тус тус санал хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11-д заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад ХАҮТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн 47,6 хувь буюу төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бөгөөд мөн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

ХАҮТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ХАҮТ-ын тухай хуулийг хүчингүйд болсонд тооцох тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийг дагаж мөрдөх тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны хуралдааныг даргалагч Л.Соронзонболд.

С.Бямбацогт: Энхцэцэг гишүүнд баярлалаа. Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 130 дугаар сургуулийн 11Г ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хэдхэн хоногийн дараа та бүхэн маань амьдралынхаа гэгээн дурсамжтай нэгэн хуудсыг хааж, аав, ээжийнхээ гэрээс гарч, амьдралын их далайд хөл тавина. Тэгээд хүссэн мэргэжлээрээ хүссэн сургуульдаа суралцахыг нийт Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс хүсэн ерөөе.

Байнгын хорооны, ажлын хэсгийг та бүхэндээ танилцуулъя. Хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцохоор хүрэлцэн ирсэн ажлын хэсэг. Цэндсүрэнгийн Магнайбаатар МҮХАҮТ-ын гүйцэтгэх захирал, Мянганбуугийн Сарандаваа МҮХАҮТ-ын Ерөнхийлөгчийн зөвлөх, Мөнхцэцэгийн Шинэбаяр Монголын олон улсын арбитрын ерөнхий нарийн бичгийн дарга, алга байна. Өлзийдэлгэрийн Жамбалсүрэн МҮХАҮТ-ын дэргэдэх Хууль зүйн бодлогын зөвлөлийн дарга, Эрдэнэчулууны Бадамхорол МҮХАҮТ-ын Гадаад худалдаа баримт бичиг баталгаажилтын газрын дарга, Лхагвасүрэнгийн Загдаа Өмгөөллийн Хэруга партнерс компанийн гүйцэтгэх захирал, Баавгайн Эрхбаяр Улсын Их Хурлын гишүүний зөвлөх. Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн гишүүд та бүхэнд хууль сануулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ЗГ-ын гишүүн, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан болон бусад этгээд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй. 21.25.Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх Албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, УИХ-д худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. 21.31.Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байдгийг та бүхэнд сануулж танилцуулъя. Тэгээд Их Хуралд хүндэтгэлтэй хандаж, асуултад үнэн зөв, бодитой хариулт өгөхийг хүсье.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. 20 гишүүн асуулт асуухаар ирүүлсэн байгаа. Гомбын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Өглөөний мэнд. Энэ хуулийн төсөлтэй холбоотой хуулийн 6 дугаар зүйлд бүхэлдээ ХАҮТ-ын эрхийг нэмэгдүүлсэн тухай байна. Хуулийн төслийн 6.3-д ХАҮТ нь Монгол Улсын ЗГ-ын тухай хуулийн 19.1-д заасан холбогдох шийдвэрийн дагуу төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг хэрэгжүүлж болно гэж. Өөрөөр хэлбэл 19.1 нь ЗГ-ын тухай хууль, ЗГ нь төрийн гүйцэтгэх

байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэн ЗГ-ын шийдвэр, гэрээний үндсэн дээр ЗГ-ын бус байгууллагуудад хариуцуулан гүйцэтгүүлэх тухай заалт байгаа юм л даа. Энэ чинь нийт танай танхимын үйл ажиллагааны хэдэн хувь нь энэ үндсэндээ төрөөс санхүүжих байгууллага болчхов 1 дүгээр асуулт?

2-т нь салбарын танхимыг эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 50-аас доошгүй ААН, үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд сайн дурын үндсэн дээр нэгдэн энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу байгуулах бөгөөд үйл ажиллагаагаа бие дааж хэрэгжүүлнэ гэж. Тэгэхлээр энэ нөгөө нэг бусад мэргэжлийн холбоод байгаа шүү дээ. Мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг энэ хууль, энэ заалт зөрчилдөж хязгаарлах юм биш биз дээ гэсэн нэг болгоомжлол байна 2 дахь нь?

3 дахь асуулт маань уг хуулийн 13 дугаар зүйлд аймаг, нийслэл болон салбарын удирдах зөвлөл гэж. 13.3-д нь аймаг, нийслэлийн болон салбарын танхимын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд нэг эцсийн өмчлөгчтэй 5-аас дээш тооны хуулийн этгээд байхыг хориглоно гэж заасан байна. Тэгэхлээр бүх гишүүдийн хурлаас 11 Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоно гэж заасан. Түүнээс 5-аас доошгүй нь нэг эцсийн өмчлөгчтэй байна гэдэг нь нэг компанид давуу эрх олгочих юм биш биз дээ гэсэн нэг болгоомжлол байна. Тэгээд үүн дээр хариулж өгөөрэй.

4 дэх нь хуулийн 19 дүгээр зүйл. 19.1 дээр Монголын ХАҮТ нь Монгол Улсаас гаралтай экспортын барааны гарал үүслийг тодорхойлох гэрчилгээ олгох үйлчилгээ үзүүлнэ гэж. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ хамаарч байгаа юу гэсэн ийм 4 асуулт байна.

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулъя. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: 3 дугаар асуултаас эхэлье. Аймаг, нийслэлийн салбар танхимын нэг эцсийн өмчлөгчтэй бол энэ тоог нь хязгаарлаж байгаа. Өөрөөр хэлбэл энэ бизнесийн салбарын төлөөлөл нь улс төрөөс гадна энэ том компаниудын төлөөллүүд энэ эдийн засгийн салбарын ч юм уу, аймаг, нийслэлийн салбар танхимууд дээр энэ нөлөөлөл өндөр байхаас хамгаалах ийм зайлшгүй шаардлага байгаад байгаа. Тэгэхээр энэ заалт дээр 11 удирдах зөвлөлийн гишүүнтэй байна гэж заасан байгаа. Тэгэхдээ энэ тооны талд нь хүрэхгүй буюу ийм 5 гэсэн хязгаарлалт тавьсан байгаа. Эцсийн, нэг эцсийн өмчлөгчтэй. Тэгэхээр энэ байдлаар бол том компаниуд тухайн салбарыг ч юм уу, аймаг, нийслэлийг төлөөлөх энэ бололцоо боломжуудыг нь хязгаарлаж байгаа.

Дээр нь энэ танхимаас, танхимын одоо энэ удирдлагуудаас энэ дээр Монгол Улсын Их сургууль /МУИС/ дээр судалгаа хийлгүүлээд, хуулийн төсөл давхар энэ дээр ажиллуулсан байгаа. Энэ саналаар бол энийг 2 болгох ийм саналтай байгаа. Тэгээд энийг бол хууль санаачлагчийн хувьд хууль үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх нь дэмжигдвэл энийг хүлээж авах бололцоотой гэж бодож байгаа.

Гарал үүслийн хувьд ажлын хэсгээс нэмэлт мэдээлэл өгнө гэж, өгчхөөрэй. Салбарын танхимуудын хувьд 50-аас дээш энэ одоогийн хуулиар болохоор 50-аас дээш ААН-үүд нэгдэж, энэ бие даасан байдлаар сайн дурын үндсэн дээр энэ салбар танхимуудаа байгуулахаар зохицуулалт байгаа. Одоогийн зохицуулалтаар

болохоор орон нутгийн зарчмаар буюу аймаг, нийслэлийн танхимууд байхаар өөрөөр хэлбэл эдийн засгийн салбарын ийм танхим байхгүй байсан. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд ганцхан Улаанбаатар хотын л танхим байгуулагдсан байгаа. Бусад жишээлбэл танхимууд байгуулагдаад үйл ажиллагаа явуулах эдийн засгийн бололцоо боломжууд байхгүй байсан. Тэгэхээр одоо энэ салбар танхимууд маань аймгуудын төлөөлөл маань танхимын нэг хэсэг байдалтай ингээд явж байгаа, бие даасан үйл ажиллагаа явуулахгүй байгаа. Тэгэхээр цаашдаа энэ хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор ААН-үүд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдээд, энэ өөрсдийнхөө аймаг, нийслэл юм уу, салбарын танхимыг байгуулах ийм бололцоотой байгаа.

Дээр нь энэ салбарын танхимуудтай холбогдуулаад тухайн салбартаа олонхынхоо олон жилийн түүхтэй болчихсон, хүлээн зөвшөөрөгдсөн ийм мэргэжлийн холбоод байгаа. Тэгээд энэ холбоод, дээр нь мэргэжлийн холбоодын нэгдсэн энэ холбоодын хуулиар зохион байгуулагдаад тухайн салбарынхаа олонхыг төлөөлж авсан байгууллагууддаа бол шууд энэ салбар танхимын чиг үүргийг нь гүйцэтгэхээр гэрээ байгуулж болохоор, тухайн салбарт нь зэрэгцүүлж давхар тухайн эдийн засгийн салбар танхим байгуулахгүй байхаар ингэж заасан байгаа. Тэгэхээр энэ нь өөрөөр хэлбэл бий болчихсон, тогтчихсон энэ харилцааг бужигнуулахгүй, давхар ийм үл ойлголцол бий болгохгүй байх гэсэн ийм үүднээс ийм заалтуудыг оруулсан байгаа юм. Төрийн ер нь бол одоо эдийн засаг дээр бол бүх шийдвэрүүд, оролцоонууд төрийн оролцоо нэлээн өндөр байгаа. Тэгэхээр энэ чиг үүргүүдийг.../минут дуусав/

С.Бямбацогт: Хассуурийн Ганхуяг гишүүн нэмж хариулъя хууль санаачлагч.

Х.Ганхуяг: Энэ 6.3-тай холбоотой асуудал дээр тэнхимээс нэмээд хариултыг нь өгөөрэй. Яагаад гэхээр яг хэдэн төгрөг ЗГ-аас авдаг эд нарын надад мэдээлэл алга байна. Гэхдээ энэ заалт өөрөө болно гэдэг л заалт юм. Тэгээд салбар хуулиуд дээр бас болно гэдэг заалт оруулдаг. Жишээлбэл тухайлбал Зөвшөөрлийн хууль дээр зарим нэг зөвшөөрлийг мэргэжлийн холбоод буюу ТББ-аар олгуулж болно гэдэг жишиг юм байдаг ч юм уу, эсвэл Боловсролын хуулиар мэргэжлийн боловсролтой холбоотой асуудлыг ТББ-аар гүйцэтгүүлж болно ч гэдэг юм уу. Жишээлбэл Боловсролын хууль дээр тэр ТББ-тай холбоотой асуудал нь ажил олгогчийг нөгөө мэргэжлийн боловсролын сурагчтай холбож өгөх үүргийг жишээлбэл төрийн бус энэ ТББ гүйцэтгэхээр орсон байдаг юм. Тэрийг л гүйцэтгэж болно гэсэн заалт юм. Нөгөө талдаа салбар хууль дээрээ ч гэсэн тэр заалт орох ёстой. Тэгээд эрх бүхий байгууллага буюу тухайн бодлогын юм уу, эсвэл салбарын яам нь гэрээний үндсэн дээр аль нэг төр бус.../минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг нэмж хариулъя. Хэн хариулах вэ? Гарал үүсэлтэй холбоотой гэсэн. 4 дүгээр микрофон. Ажлын хэсгийн гишүүд асуултад хариулахдаа бэлтгэлтэй байгаарай, бэлдэж байгаарай.

Э.Бадамхорол: Эрхэм Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Миний бие МҮХАҮТ-ын Гадаад худалдааны бичиг баримт баталгаажуулах газрын дарга Бадамхорол байна. Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Гарал үүслийн гэрчилгээг уул уурхайн бүтээгдэхүүний экспортын бүтээгдэхүүн хамаарах уу гэж асуусан. МҮХАҮТ нь ХАҮТ-ын тухай хуулийн 6.2.3 дахь заалт, хэсэгт заасны дагуу экспортын барааны гарал үүслийг гэрчлэх зохицуулалттай. Гарал үүслийн гэрчилгээ олгох үйл

ажиллагаа нь бол Монгол Улсын болон олон улсын гэрээ хэлэлцээр, Монгол Улсаас гарал үүсэлтэй экспортын барааны гарал үүслийг тодорхойлох, гарал үүслийн гэрчилгээ олгох журмаар бол зохицуулагддаг. Тус журмын 1.2.1 дүгээр заалтад Монгол Улсаас гарал үүсэлтэй бараа, Монгол Улсын бүрэн гарал үүсэлтэй бараа болон Монгол Улсад үлэмж хэмжээний боловсруулалт хийгдсэн барааг бол ойлгоно. Энэхүү журам.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя, 4 дүгээр микрофон.

Э.Бадамхорол: Үүнтэй холбогдуулан Монгол Улсын нутаг дэвсгэрээс олборлосон ашигт малтмал, түүхий эд, үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн бол хамаарна. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Хэд хэдэн удаа орж ирж байгаа, дээр нь мэргэжлийн Байнгын хороо дэмжээгүй байдаг. Тэгээд энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг нь сайн эргэлзэж байна. Шалтгаан нь ер нь яах вэ цаашдаа Өмгөөлөгчдийн холбоо ч байдаг юм уу, Ажил олгогчдын холбоо ч байдаг юм уу, Хүний эрхийн Комисс ч байдаг юм уу ингээд ер нь Их Хурлаас тодорхой бодлогоор тодорхой асуудлуудыг нь дэмжиж ингэж явдаг энэ байгууллагуудаа Ерөнхийлөгч нь нам бус байна, ТУЗ нь тэдэн гишүүнтэй байна, дотроо ийм бүтэцтэй байна энэ тэр гээд ингээд бүүр ингээд дотоод асуудал руу нь бид ингээд ороод явах нь зөв юм уу? Хараат бус байдлаа жоохон хадгалаад энэ асуудлаа харин ч та хэд Их Хурлаар шийдүүлэхгүйгээр дотооддоо шийдээд явах нь зөв юм биш үү? Тэгээд эсрэгээрээ тэгээд нөгөө Ерөнхийлөгч нар нь Их Хуралд сонгогдох шат болгодог, дахиад яг нэг ийм бизнес эрхлэгчдийн нам юм шиг ийм байдал руу одоо орчихсон байгаа нөхцөл байдлаа улам л лавшруулах ийм байдал юм шүү гээд. Тэгээд энэ талаас нь харахаар дэмжмээргүй санагдаад байгаа юм.

Харин яг бизнес эрхлэгчдийнхээ эрх ашгийг хамгаалах, нэгдсэн зохион байгуулалтад орох, тэр дундаа экспортын чиг баримжаатай салбараар нь яг экспортын төрлийн бүтээгдэхүүнээр нь ангилж, ямар асуудал байна вэ гэдгийг олж харж байгаа энийг нь бодохоор дэмжмээр санагдаж байгаа юм. Тэгээд сая гарал үүсэлтэй холбогдолтой асуудлыг ярилаа. Би хөдөө аж ахуй /ХАА/-н салбарт ажиллаж байсан хүний хувьд махны хэдэн компани байгаа. Мах бол Монгол Улсын хувьд стратегийн гол бүтээгдэхүүндээ зүй ёсоор орно. ХАА-н гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох тухай асуудлыг бид олон жил ярьж байгаа. Ингээд ирэнгүүт махны компаниудын эв нэгдэл, компани болгон өөрсдийн брэндийг хөгжүүлж, экспортлогч болно энэ тэр гэдэг энэ асуудлуудыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах зайлшгүй шаардлага байж байгаа. Энэ дээр ямар ч зохицуулалт байхгүй. Булангийн орнууд руу гарцыг нээсэн, идэвхтэй ажиллаж байгаа 20 гаруй компани, тэр дундаас 12 компани нийлээд ажиллаад явахаар хоорондоо маргалддаг, очоод үнээ унагадаг, тэгээд ийм зохицуулалт асуудлууд дээр уул нь бизнес эрхлэгч нараа цуглуулаад, тодорхой асуудлуудыг нь яриад, тэр протоколууд, мал эмнэлгийн энэ асуудлууд дээр нь санаачилга гаргаад ингээд явж байсан ямар ч туршлага, ямар ч кейс огт байхгүй байгаа. Энэ чиглэлээр ерөөсөө юу ч хийхгүй байгаа.

Экспортыг дэмжих чиглэл дээр харин ч эсрэгээрээ гай болж байгаа. Махны компаниуд төдийгүй, хүнсний компаниуд дээр саяын ярьж байгаа энэ 19.1 дээр

заасан гарал үүслийн гэрчилгээ гэж. Энийг бол үндсэндээ олгох асуудал дээр маш хүнд сурталтай байсан асуудлыг нэг цонхны системд оруулаад ажиллаж байгаа. Энэ ажиллаж байна уу? Шинэ хуулиар энэ гарал үүслийн гэрчилгээ тэргүүтэй эсрэгээрээ энэ танхим нь энэ бизнес эрхлэгч нараа боомилдог, янз янзын бичиг шаарддаг энэ асуудлуудаа бууруулах ийм зохицуулалтуудын тухай ярихгүй юм уу?

Ерөнхийлөгч нь хэн байх, ТУЗ нь хэд байх гэдэг тухай ярьсан энэ агуулга бол нэг тийм нүдээ олоогүй л санагдаж байна. Самрын салбарынхан байна. Заавал ч үгүй аж үйлдвэрийн танхимтай очиж зөвшөөрөл янз бүрийн юм авч байж нөгөөдхөө экспортод гаргадаг. Экспортод гаргахад та хэд маань бүүр дэмжих биш, ерөөсөө энэ дээр нь үндсэндээ гай болсон ийм асуудлуудыг хийж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ асуудлууд руугаа гол анхаарлаа хандуулсан, тухайлсан Монгол махны шинэ брэндийг үүсгээд энэ чиглэлээр ажиллаж байгаа бүх компаниуд тодорхой хөрөнгө, санхүү, хүний нөөц бүх юмаа share-лээд ингээд Австралитай адилхан, Шинэ Зеландтай адилхан Монгол мах гэдэг энэ концепцоо хийгээд, хамгаалагдсан аж ахуйгаа байгуулаад, шинэ нэг брэндтэй явах энэ ажлуудыг үндсэндээ уул нь хийгээд явмаар байгаа юм. Тэгээд энэ асуудлуудыг хийх гэж байгаа ийм оролдлого байх шиг байна. Энийг нь харахаар дэмжиж байна. Тэгэхээр тэр гарал үүсэл, зөвшөөрөлтэй холбогдолтой асуудлууд Их Хурлын дарга яриад байгаа, Ерөнхий сайд маань яриад байгаа Чөлөөлье гэж байгаа. Тэгээд энэ чөлөөлье гэдэг санаачилгыг энэ хуулиар хэрхэн дэмжих юм бэ? Нэг цонхны систем хийсэн тэр маань ажиллаж байна уу гэдгийг тодруулъя?

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ЕБС-ийн 10А, 11А, 12А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийнхээ сурлагад нь өндөр амжилтыг хүсье. Амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Ганхүлэг гишүүний асуултад хууль санаачлагч Хассуурийн Ганхуяг гишүүн хариулна.

Х.Ганхуяг: Ажлын хэсэг гүйцээгээд хариулчхаарай. Би нөгөө энэ дүрэмтэй холбоотой асуудлаар яагаад зохицуулж болох юмыг зохицуулаагүй ингээд хуульд оруулж ирсэн бэ гэдэг асуудлыг. Яагаад ийшээ ингэж орох болсон үндсэн шалтгаан нь юу вэ гэхээр Худалдаа, аж үйлдвэрийн танхим бол яг хувийн хэвшлийн хараат бус байгууллага байх ёстой, хараат бусаар дуу хоолойгоо хүргэдэг байх ёстой. Тэрнээс биш аль нэг намын даргын, эсвэл аль нэг намын карманы ТББ болчихоод удаад байна шүү дээ. Жишээлбэл өмнө нь 20, жил нэг дарга 20 гаруй жил дарга хийсэн энэ тэнхимийн дарга. Дараад нь Иргэний Зориг ногоон намын дарга болсон. Одоо би Лхагважав гэдэг хүнийг маш их хүндэлдэг, гэхдээ манай бага хурлын гишүүн, манай намын даргын сунгаанд орсон. Тийм учраас ийм заалтыг оруулаад байгаа юм. Нэг бол намаа сонго, нэг бол тэнхимээ сонго гэдэг л шаардлага байхгүй юу. Тэгж байж энэ тэнхим чинь хараат бус болох юм. Тийм учраас энэ заалтыг оруулж өгсөн юм.

Яагаад Хяналтын хорооны гишүүдийг бүх нийтийн гишүүдээсээ нэг удаа сонго гээд байгаа юм, яагаад Удирдах зөвлөлийн гишүүдийг энэ дотор ингээд тоог нь заагаад байгаа юм. Мэдээж хэрэг энэ бол ажлын хэсэг гараад, энэ дээрээ 11 байх юм уу, 15 байх юм уу тэр бол жишээлбэл ажлын хэсгийн гишүүд шийдээд явчих боломжтой асуудлууд байгаа. Тийм учраас манай Ганхүлэг гишүүн мэтийн ХАА-н

салбарт ч ажиллаж байсан энэ залуу гишүүд энэ тэнхимийн юунд ороод ажиллаасай гэж хүсэж байгаа.

Энэ бол хувийн хэвшилтэй нэлээн олон удаа хэлэлцүүлэг хийсэн, 4 жил, 3 жил хэлэлцүүлэг хийсэн хууль шүү. Ийм учраас бид энэ эдийн засгийн асуудлууд дээр бизнесийн төлөөлөл нь хараат бусаар дуу хоолойгоо хүргэж чадахаа больсон цагт угаасаа энэ эдийн засгийн бодлогууд чинь бүгдээрээ буруу болчихоод байгаа юм. Ерөөсөө хараат бусаар дуу хоолойгоо хүргэж чаддаггүй, барьцаалагдчихдаг, аль нэг намын гишүүн болчихоор намынхаа бодлогоо дагаад явчихдаг ийм л нөхцөл байдал удчихаад байгаа юм. Тэгээд энийг засах гэж оролдож байгаа юм. Зөвшөөрлийн хууль дээр болохоор зөвшөөрлийн зөвлөл гэж байдаг. Зөвлөлийн 2/3 нь хувийн хэвшлээс байхаар орсон байдаг. Тэн дээр манай Худалдаа, аж үйлдвэрийн тэнхим зөвшөөрлийн зөвлөлд орж ажилладаг, төлөөний хүмүүс нь орж ажилладаг гэсэн үг. Тэгэхээр зөвшөөрлийг шинээр бий болгоход, эсвэл хасахад, эсвэл зөвшөөрөл дээр аудит хийхэд энэ зөвшөөрлийн зөвлөл идэвхтэй оролцоод явдаг. Нэг ёсондоо хувийн хэвшлийг төлөөлөөд ордог гэсэн үг.

Тийм учраас энэ шинэ орж ирсэн хуулийн тэр салбарын тэнхимүүд байгуулах асуудал маань өөрөө тэр тухайн салбарууд байх ёстой, байх ёсгүй зөвшөөрлүүдээ хардаг болох, энэ тэнхим нь өөрөө хараат бус болох, тэгээд тэр зөвшөөрлийн тэр зөвлөлдөө орж ажилладаг байх, бусад иргэний нийгмийн, энэ хойно дагалдаж явж байгаа хуулиуд байгаа Чөлөөт бүсийн хууль ч гэдэг юм уу тэд нар дээрээ хараат бус ажиллагаа, яг хувийн хэвшлээ төлөөлж ажилладаг болъё л гэж байгаа юм. Хувийн хэвшил төлөөлдөг байгууллага болгоё л гэж байгаа юм.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн нэмж хариулъя.

Д.Энхтүвшин: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Ер нь эдийн засаг дахь хувийн оролцооноос хамаараад энэ танхимын бүтцүүд дэлхий дээр янз бүр байдаг. Ялангуяа эдийн засаг дахь хувийн оролцоогоо нэмэгдүүлэх гэж байгаа улсуудын хувьд энэ дээр нэлээн хатуу бүтцүүд оруулж ирдэг. Тухайлбал заавал гишүүнчлэлтэй байх ёстой, бүгдээрээ энэ танхимаараа дамжуулж дуу хоолойгоо өргөдөг байх ёстой гэсэн асуудлууд ярьдаг. Эдийн засагт нь хувийн хэвшил нь угаасаа ингээд зонхилох түвшинд оччихсон улсуудын хувьд ТББ шиг байдлаар ингээд зохицуулаад явдаг. Тэгэхээр яах вэ одоогийн хувьд яг таны хэлж байгаа болгоомжлолууд байгаад байгаа, хараат бус байгаад байгаа, тэр нь зөвхөн улс төрөөс биш, том компаниудаас ч гэдэг юм уу, тухайн компаниуд нь жишээлбэл өөрсдөө Үндэсний ХАҮТ-даа очоод суучихдаг. Тэгэхээр тэнд нийтлэг эрх ашиг гэхээсээ илүү тухайн компаниудын асуудлуудыг яригдах ч гэдэг иймэрхүү байдлууд байдаг. Энэ асуудлуудын, өөрөөр хэлбэл манай эдийн засгийн хувьд хамгийн хурдан эдийн засгийг хөгжүүлэх гол хөшүүрэг хувийн.../минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг нэмж хариулъя, 4 дүгээр микрофон.

Ц.Магнайбаатар: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. МҮХАҮТ-ын гүйцэтгэх захирал Магнайбаатар байна. Гарал үүсэлтэй холбоотой асуудлын талаар хөндлөө. Цахим нэг цонхны үйлчилгээнд гарал үүсэл, махны гарал үүсэл бол бүрэн цахимаар олгогдоод явж байгаа. Энэ дээр цаг хугацаа алдаад байгаа хүндрэл учруулж байгаа зүйл байхгүй. Монгол Улсын Ерөнхий сайдын 41 дүгээр захирамжаар байгуулагдсан экспортын бараа, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, энэ

цахимжилтыг сайжруулах хүрээнд өнөөдрийн байдлаар ХАҮТ-аас олгож байгаа гарал үүслийн гэрчилгээ бүрэн цахимжсан. Тэгэхээр орон зайнаас үл хамаараад хаанаас ч бизнес эрхлэгчид маань гарал үүслийн гэрчилгээг авах ийм бололцоо бүрэн нээгдсэн байгаа. Мөн төрийн цахимжилттай холбоотой И бизнес 2.0 гээд төсөл дээр бол танхимын арбитр гарал үүсэл, эвлэрүүлэн зуучлал.../минут дуусав/

С.Бямбацогт: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя. Товчхон, тодорхой хариулна шүү минутдаа багтааж. Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

М.Ганхүлэг: Хууль санаачлагч нарын санааг ойлгож байна. Тэгэхдээ хараат бус байдал, бие даасан байдлыг ингээд харахаар уул нь өөрсдөө бие дааж асуудлаа шийдэх ийм энгийн л ойлголт санагдаад байх юм. Тэгээд яаж харахаараа Их Хурал дээр тодорхой энэ бүтцийн, бүрэлдэхүүн, дүрэмтэй холбогдолтой асуудлуудыг оруулж ирэхээр энэ хараат бус болох юм гэж хараад байгааг би бүрэн дүүрэн ойлгохгүй байна. Энэ дээр тодорхой хариултууд та хэд маань хэлэхгүй байна. Тэгэхээр ер нь бизнес эрхлэгчид өөрсдөө дотооддоо асуудлаа шийдээд, төртэй ямар нэгэн төрийн оролцоогүйгээр шууд нүүр тулаад хэлцэл хийж чадах ийм тогтолцоо руугаа л явах ёстой болохоос биш хэчнээн ТУЗ-ийн гишүүнтэй байх, Ерөнхийлөгч нь улиран сонгогдохгүй байх энэ тэр гээд нарийн ийм зохицуулалтуудыг Их Хурал дээр заавал шийдвэрлээд явах нь төдийлөн зохимжтой гэж харагдахгүй байгаад байна л даа. Тэгээд та хэд маань яаж энэ хараат бус байдлыг хараад байгаа юм бол?

Гарал үүслийн гэрчилгээний тухай би тодорхой асуулт асуугаад байгаа юм. Хэчнээн нэр төрлөөр олгож байгаа юм, эндээс хэд нь буурах юм, эсхүл ямар зохицуулалтууд хийх юм гэж.../минут дуусав/

С.Бямбацогт: Хассуурийн Ганхуяг гишүүн хууль санаачлагч хариулъя.

Х.Ганхуяг: Ганхүлэг гишүүний яриад байгаа үнэн л дээ. Энэ хараат бус болох зорилгоор л энэ хууль бичигдэж байгаа гэсэн үг. Энэ хууль бичигдсэний дараагаар тэнхимийн даргын сунгаа дахиад явагдана, гишүүдийнхээ хурлаа хийнэ. Нам бус хүмүүс тэрэндээ дэвшинэ, эсвэл одоо байгаа дарга нь сунгана гэвэл намаасаа татгалзах хэрэгтэй болно. Ингэж байж тэнхим улс төрөөс хараат бус болох юм байгаа юм. Яг тэгээд тэр намынх тэнхимийнх нь гишүүдийн нийт гишүүдийнхээ хурлыг хийнэ. Тэгэхгүй бол өмнө нь яасан бэ гэхээр зүгээр дүрмээ өөрснөө тэр хурал хийхээсээ өмнө дотооддоо өөрчлөөд л, тэгээд хуралдаад, өөрийгөө сонгуулчихдаг л байсан шүү дээ. Өнөөдрийг хүртэл дандаа л аль нэг намын хүн тэнхимийн дарга хийгээд ирсэн шалтгаан нь энэ шүү дээ. Тэгээд энэ хувийн хэвшил чинь дуу хоолой нь энэ Их Хуралд хүрдэггүй, олон нийтэд хүрдэггүй шалтгаан нь ерөөсөө энэ. Өнөөдөр гар утастай live-чин өнөөдөр очоод л уул уурхайг зогсоодог, аль нэг бизнесийг зогсоодог нь үнэн биз дээ? Тэнхим тэн дээр дуу хоолойтой оролцож чадахгүй байгаа нь үнэн. Тийм учраас энийг л засах гэж байгаа юм.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон индрийн, асуултад хариулъя. 1 минутад багтааж, тодорхой товчхон.

Ц.Магнайбаатар: ХАҮТ-аас өнөөдрийн байдлаар 6 нэр төрлийн гарал үүслийг ААН-үүдэд олгож байна. Form A, B, E, Азиномхон худалдаа, Ази Номхон Далайн худалдааны хэлэлцээрийн дагуу АРТА, тэгээд Form D, Европын Холбоо руу REX гэсэн ийм 6 төрлийн гарал үүслийг олгож байгаа. Бүгд цахимжсан байгаа. Энэ

гарал үүслийн гэрчилгээг бол ААН-үүд Гаалийн хуулийн 60.3 дугаар зүйл дээр заавал шаардана гэсэн зүйлийг нь нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөгдсөн байгаа. Ер нь энэ олон улстай байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээрүүд ч юм уу, энэ Ази Номхон далайн худалдааны хэлэлцээрийг ашиглахынхаа хүрээнд ААН-үүд энэ тарифын хөнгөлөлт эдлэхийн тулд энэ гарал үүслийн гэрчилгээг бол авч үйл ажиллагаандаа ашиглаж, тарифын хөнгөлөлт эдлэхийн тулд энэ гарал үүслийн гэрчилгээг ашиглаж байгаа.

С.Бямбацогт: Тодруулъя Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Уучлаарай, энэ дээр ААН-үүдтэй ажиллаж байсан хүний хувьд аягүй төвөгтэй байгаад байгаа юм. Ялангуяа Стандарт, хэмжил зүйн газар /СХЗГ/-ын тэр тохирлын гэрчилгээ. 1кг мах бид экспортод гаргахад 54 төрлийн бичиг баримт гаргах болгондоо үндсэндээ бүрдүүлж байгаа юм давхардалтайгаар. Энийг яах вэ цахим болгоод хагас сар байсныг үндсэндээ 2-оос 3 хоногт гаргах энэ ажлууд нэг цонхны системээр хийгдсэн. 7 байгууллага нэг цонхон дээр нэгдсэн. Ингээд орхичихмооргүй байгаа юм. Энэ үндсэндээ гарал үүсэл тэргүүтэй тодорхой бууруулж болох энэ зөвшөөрлүүдийг яаж бууруулах вэ гэдэг дээр яг тодорхой энэ бодлогын энэ саналуудыг та хэд маань хийгээд явмаар байгаа юм. Магадгүй энэ хуультай холбогдолтойгоор энэ асуудал хөндөгдөөд, тодорхой үр дүнгүүд гараасай гэж би хүсээд байгаа юм. Экспорт хийхэд бид аягүй олон бичиг баримтуудыг шаардаж байгаа энэ асуудал дээр анхаарах ёстой. Салбарын тэр экспортын бүтээгдэхүүн дээр яах вэ гэдэг дээр тодорхой хариулт авсангүй.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Тодорхой л асуулт асуугаад байх юм. МҮХАҮТ-ын байнга хийдэг, гол орлогоо олж байгаа асуудал шүү дээ. Яг үнэхээр иргэд, аж ахуй нэгжид хүнд суртал чирэгдэл учруулж байгаа. Хариульъя 4 дүгээр микрофон. Тэгээд л гарал үүслийн гэрчилгээ гээд хэрэгтэй ч юм уу, хэрэггүй ч юм уу, баахан хүнд суртал, бичиг цаасаар л гол орлогоо олдог шүү дээ та бүхэн.

Э.Бадамхорол: МҮХАҮТ-ын Гадаад худалдааны бичиг баримт баталгаажуулах газрын дарга Бадамхорол. Түрүүнд манай гүйцэтгэх захирлын хариулсанчлан гарал үүслийн гэрчилгээ бол Монгол Улс хоёр талт болон олон талт бүс нутгийн худалдааны хэлэлцээр хийсэн улс орнууд, ДХБ-ын гишүүн орнууд хооронд худалдаа хийхэд гаалийн тарифын нэн тааламжтай болон хөнгөлөлттэй тарифын хөнгөлөлтийг эдэлдэг. Энэхүү хөнгөлөлтийг эдлэхийн тулд тухайн бараа, бүтээгдэхүүн нь тухайн улсын тодорхой гарал үүслийг бол шалгуурыг хангасан байх ёстой. Тийм учраас энэ гарал үүслийн гэрчилгээг шаардаж, МҮХАҮТ-аас авдаг. Манай байгууллагын хувьд гарал үүслийн гэрчилгээг одоогийн байдлаар цаасан хэлбэрээр олгож байхад ажлын 4 цагт багтаан олгож байсан. Одоо цахимд шилжсэнтэй холбогдуулан ажлын нэг цагт багтаан олгож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя.

Ө.Шижир: Өдрийн мэнд. ХАҮТ бол яг бизнес эрхлэгчдийнхээ дуу хоолой болж чадаж байгаа юу гэдэг асуудал 1 дүгээрт байгаа. Энэ бол хангалттай болж чадахгүй байгаа гэж миний хувьд үзэж байгаа. Яагаад гэхээр зөвхөн том бизнес эрхлэгчтэйгээ харьцчихдаг, том ААН-үүдтэйгээ харьцчихдаг. Жижиг, дунд бизнес эрхэлж байгаа, аж ахуй, үйлчилгээ эрхэлж байгаа, бага бизнес эрхэлж байгаа хүмүүстэйгээ төдийлөн нэг их харьцдаггүй. Хамгийн хүнд дарамт тэр жижиг, дунд бизнесийнхэн дээр очдог. Энэ ХАҮТ-ын энэ үндсэн зорилго дээр бизнесийн

амжилтын талбар байж, дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд манлайлахад хөтөч нь болно. Эрхэм зорилго дээр бизнесийн хөгжилд чиглүүлж, холбогч, дэмжигч байна гээд ингээд биччихсэн. Манайх ингээд эрхэм зорилго, үнэт зүйл гэхээр ингээд гоё, гоё юм аваачаад биччихдэг. Тэгээд бодит байдал дээр хэрэгждэггүй. Яг энэ ХАҮТ-ын зүгээс жижиг, дунд бизнес эрхлэгч нартай ямар бодлогын чиглэлээр, яаж холбож, яаж зөвлөж, яаж хөтөч болсон юм бэ гэдэг нэг асуулт байна? Нэг тодорхой жишээтэй ярьчаарай.

2 дугаарт улс төрөөс хараат байх ёстой. Тэгээд бүүр хараатын хараат байх ёстой. Харамсалтай нь ХАҮТ дээр дандаа улс төрчид очдог. Нэг бол улс төрч болоод яваад өгдөг. Манай Энхтүвшин гишүүн нэг жил ч болоогүй байх ХАҮТ дээр очоод, тэгээд эрх барьж байгаа намын урилгыг хүлээж аваад, гуяа алгадаад Их Хуралд ороод ирдэг. Ард нь ингээд танхим нь хаягдчихдаг. Одоо хүртэл түр орлон гүйцэтгэгчтэй. Тэгээд энэ бизнесийн боломжуудаа, энэ бизнесийн орчноо та нар яаж хамгаалах гээд байгаа юм бэ?

2 дугаарт энэ 6.1.1 дээр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулалтад оролцоно гээд. Та нар төрөөс хараат байх ёстой байхгүй юу. Төрийн боловсруулах бичиг баримтад оролцоно гээд. 6.2 дээр хуульд зааснаар холбогдох төрийн байгууллагатай зөвшилцөнө. 6.1.5, 6.1.6 гээд энэ асуултууд чинь өөрөө эд нар чинь өөрөө ТББ-ын 9 дүгээр зүйлд заасан төрөөс ТББ-тай харилцах хэсгийн 2 дахь хэсгийг зөрчөөд байгаа байхгүй юу. Дээр нь энэ ТББ-ын тухай хуулийн 6 дахь хэсэгт ТББ нь төрийн байгууллагаас гаргасан шийдвэрийн талаар байр сууриа илэрхийлж мэдэгдэл хийж болно гэдгийг бас зөрчөөд энэ юу чинь өөрөө ингээд хараат байдал руу орж ирээд байгаа юм. Тэр 6.3-ыг бол ярьчихлаа. Зарим нь асуусан.

Тэгээд энэ жишээ нь төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж, тэр тухайдаа улсын төсвөөс санхүүжиж байгаа байгууллагын ЗГ-ын шийдвэрийг биелүүлж, уг ажлаа Монгол Улсын зохих сайдын өмнө хариуцна гээд заасан чинь танхим өөрөө улс төр, төрийн чиг байдлаас хараат бус байдлыг чинь өөрсдөө ингээд хараат болгоод байна шүү дээ энэ хуулийн төсөл дээр чинь. Тэгээд энэ заалтуудаа та нар яаж харж байгаа юм бэ? Би энийг гайхаад байгаа юм.

Одоо яах вэ бид хараат бус болох гээд байна л гээд байдаг. Тэгээд яг бодитоор энэ төрийн байгууллагуудын зарим чиг үүргийг хамтарч хийх, эсвэл зарим үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гээд байдаг. ХАҮТ бол төрөөс, улс төрөөс бүүр хамааралгүйгээр бизнесийн орчныг эрүүл болгоход түлхэц үзүүлэх ёстой шүү дээ. Яагаад өөрсдөө ингээд төртэй хамтрах энэ дээр ингээд орж оролцоно гээд хууль дээр оруулж ирээд байгаа юм бэ? Та нар төртэй хамтарч яах гээд байгаа юм бэ? Зүгээр бизнес эрхлэгчдийнхээ дуу хоолой болж болдоггүй юм уу? Үнэт зүйл, эрхэм зорилгоо унш л даа нээрээ. Та нар энэ дээр ингээд биччихсэн байгаа байхгүй юу. Тэгээд манайхан үнэт зүйл, эрхэм зорилго гээд сайхан үг зохиогоод биччих юм. Ард нь гүйцэтгэл нь байхгүй, үр дүн нь байхгүй.

Тэгээд жижиг, дунд үйлдвэрлэл /ЖДҮ/-лэгчдийг ер нь нэг төр нь ч анхаардаггүй, ХАҮТ ч тоодоггүй, 5-аас 10 хүнтэй ААН нь өөрөө өөрөөрөө яваад, нэг бол дампуураад, нэг бол аятайхан болоод явдаг. Одоо жижиг аж ахуй нэгж бүгд хаалгаа барьж байна шүү дээ. Тэгээд энэ дээр төр, ЗГ ийм бодлогын дэмжлэг үзүүлээч гээд танхимаас ЗГ-т, Их Хуралд хандсан юм байна уу? Энэ 2 жилийн

хугацаанд би лав олж хараагүй. Манай бизнес эрхлэгчдийн эрх ашиг ингэж хохироод байна, жижиг, дунд бизнесүүд ингэж хохироод байна, тийм учраас энэ бизнес эрхлэгчдээ хамгаалъя, ажлын байрыг нь хамгаалж авч үлдье гэдэг тодорхой шийдэл гаргасан юм байна уу? Тэгээд тодруулчихъя.

С.Бямбацогт: Чухал асуудал хөндөж байна. Хууль санаачлагч Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултад хариулъя.

Д.Энхтүвшин: Шижир гишүүний хэлж байгаа үнэн. Ер нь одоогийн танхимын үйл ажиллагаа маань яг бизнес эрхлэгчдийн, ялангуяа жижиг, дунд бизнес эрхлэгчдийнхээ эрх ашгийг хамгаалж чадахгүй байгаа. Энэ хуулийн төслийг өргөн барьсан 3 жил ингээд явж байгаагийн гол шалтгаанууд нь үндэслэлүүд нь нэг энэ байгаа. Өнгөрсөн хугацаанд ч гэсэн энэ хууль маань одоогийн байгаа орчин, жишээлбэл чөлөөтэй өөр өөрсдөө холбоонууд нь, тэгээд компани нь, яг энэ үндэсний танхим маань бусад бизнесийн холбоотой яг л адилхан компаниуд нь ороод суудаг ийм болчихсон учраас томууд нь очоод суучихдаг, жижгүүд ач холбогдол багатай учраас үйл ажиллагаанд нь оролцохоо больчихсон иймэрхүү л асуудал байгаа юм. Ер нь том зургаар аваад үзвэл манай эдийн засаг маань бид хувийн хэвшилд суурьтай энэ чиглэл рүү шилжинэ гэсэн боловч яг хараахан шилжиж чадаагүй байгаа. Топ 100 ААН-үүдийн маань бараг 90 орчим нь зөвшөөрөл, лиценз дээр үндэслэсэн бизнес үйл ажиллагаа явуулдаг. ТӨК-удын хэмжээ нэмэгдчихсэн.

Тэгэхээр энэ орчныг сайжруулахын тулд энэ төрийн, Танхимын хуулиар дамжуулж яг энэ бүгдээрээ бид нэгдэж, төлөөллөө яаж сайжруулах вэ гэдгийг энэ хуулиар сайжруулж, хувийн хэвшлийн орон зайг тэлье гэсэн иймэрхүү бодол байгаа юм. Тэгээд ер нь төр дээр асар их чиг үүргүүд байгаа. Энийг бид тодорхой хэмжээнд шилжүүлж авахгүй бол жишээлбэл зөвшөөрөлтэй холбоотой, зөвшөөрөл шинээр өгөх, авах харилцаанууд байна гэдэг зүйлүүдийг төрд өөрт нь зөнд нь орхиод байвал эрх мэдлээ тэлээд л байгаа юм. Тэгэхээр энийг нөгөө талд нь цул болж, төлөөллөө сайжруулж, тодорхой хэмжээнд эн тэнцүү институц бий болгохгүй бол өнөөдрийн хувьд энэ байдлаараа төр давамгайлаад, улам төр данхайгаад ийм л зам руу орно. АН-ын хувьд баруун төвийн үзэл баримтлалтай намын хувьд хувийн хэвшлийн орон зайг тэлэх энэ чиглэлээр Танхимын хуулийг хэлэлцүүлгийн явцад сайжруулаад, энэ чиглэлээр илүү хамтарч ажиллаасай, ажлын хэсэгт идэвхтэй оролцож, саналуудаа илэрхийлээсэй гэж хүсэж байгаа юм.

Жижиг, дунд бизнесүүдийн хувьд өмнө энэ компаниуд маань салбар болон аймаг, нийслэлийн танхимууд руугаа шилжчихээр тэндээ тухайн асуудлуудаа ярих юм. Жишээлбэл худалдааны танхим байлаа гэж бодоход тэнд илүү худалдаатай холбоотой жижиг, дунд ААН-үүд, тэгээд тооны хувьд ААН-үүд чинь жижиг, дундууд нь олон учраас энэ асуудлуудаа байр сууриа нэгтгэж ярихад, тэгээд тухайн салбарын бодлого гэхэд жижиг, дунд ААН-үүдийн дуу хоолой нэмэгдэх ийм бололцоо боломжууд нээгдэнэ. Ажлын хэсгээс нэмж.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон.

Ц.Магнайбаатар: Улсын Их Хурлын гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн байдлаар ХАҮТ дээр 6768 гишүүн бүртгэлтэй байна. Улаанбаатар хотын хувьд 3147, орон нутагт 3621. Эндээс жижиг, дунд ААН-үүдийг бүртгэлийг нь аваад үзвэл ХАҮТ 5 төрлийн гишүүнчлэлтэй байдаг. Энэний гоулд стандарт ангиллуудад

дандаа нөгөө бичил, жижиг, дунд ААН-үүд маань хамрагдаж байдаг. Гоулд ангилалд 674, стандарт ангилалд 426 гээд нэг мянга орчим ААН бол энэ анхан шатны ангиллууд дээр байна. Хөдөө орон нутагт бол үйл ажиллагаа эрхэлж байгаа ААН-үүд ихэнх нь жижиг, дунд ААН-үүд байдаг. Өнөөдрийн байдлаар жижиг, дунд ААН-үүдийг дэмжих чиглэлээр ХАҮТ-аас 60 гаруй, 64 төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж байгаа. Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, гадаадад бараа, бүтээгдэхүүнүүдийг нь энд гаргах.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулъя.

Ц.Магнайбаатар: Сургалт, зөвлөгөө өгөх, олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдэд хамруулах, хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх. Бизнес академиараа дамжуулаад хосмог сургалтын тогтолцоог ААНБ сургалтын байгууллагуудыг холбох зэрэг ийм олон үйлчилгээг жижиг, дунд ААН-үүддээ хүргэж байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Тодруулъя, Өлзийхүүгийн Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Нөгөө нэг топ зуун ААН гэхээр дандаа төрөөс хамааралтай, ямар нэгэн тусгай зөвшөөрөл авдаг ийм ААН-үүд байгаад байгаа юм. Тэгээд энэ чинь өөрөө чөлөөт эдийн засгаа боомилсон нэг хэлбэр байхгүй юу энэ талаасаа харахаар. Нөгөө талаасаа харахаар топ 100-даа ашгүй нэг ТӨК-удыг оруулахаа больсон юм байна лээ 2024 оноос хойш. Тэгэхгүй бол энэ чинь өөрөө төр хувийн хэвшилтэй өрсөлдөөд байгаа юмыг чинь бататгаад байгаа юм. Одоо төр чинь өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ий 74 хувийг үйлдвэрлээд байна шүү дээ. Энэ чинь уг нь хувийн хэвшлийн орон зайг байхгүй болгоод байгаа юм.

Нөгөө талаасаа харахаар 2014 онд Топ 100 ААН нь нийт татварын орлогын 20, 30 хувийг бүрдүүлдэг байсан юм. Одоо 2024 оны байдлаар 20 хувийг бүрдүүлдэг болчхож байгаа юм. Энэ тоо нь ингэж 20 хувь гэж харагдаж байгаа юм шиг мөртөө та нар аргачлалаа өөрчилчихсөн байхгүй юу. Тэр аргачлал нь юу вэ гэхээр топ зуугаасаа ТӨК-удаа бүгдийг нь гаргаад хаячихсан гэсэн үг. Тэгэхээр яг бодит тоон дээр бүх юугаараа харвал Топ 100 чинь бараг нийт ДНБ-ий татварын чинь бараг 50, 60 хувийг төлөөд байгаа юм. Тэгэхээр энэ өөрөө чөлөөт буюу жижиг бизнесийн орон зайгаа яаж.../минут дуусав/

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Хассуурийн Ганхуяг гишүүн хууль санаачлагч хариулъя.

Х.Ганхуяг: Шижир гишүүн маш зөв асуудлыг хөндөөд байгаа шүү. Ер нь өнөөдрийн тэнхимийн гол проблем нь юу вэ гэхээр нэг бол улс төрийн намын харьяалалтай, нэг бол том компаниудын төлөөлөл болчхоод байгаа юм. Тэгэхээр энэ шагнал олгодог юман дээрээ бид яг өнөөдрийн трендтэйгээ уялдуулаад хамгийн инновацлаг ч гэдэг юм уу, хамгийн сайн экспортлог ч гэдэг юм уу, уул уурхайн бус экспортлог ч гэдэг юм уу тийм байдлаар ингээд шагналуудаа тодорхойлдог болохгүй бол одоо ингээд төрийн шагнал хүртэж байгаа 100 хүнээс нэг нь л хувийн хэвшлийн хүн шагнагддаг шүү дээ. Тэр статистикаа бас үзээрэй. Тэгэхээр энэ дээр яг ингээд тэнхим өөрөө маш идэвхтэй байх ёстой. Яг тэр шагнал тодорхойлдог эд нар байхгүй бол хувийн хэвшил нь шагнал авдаггүй, тэгээд л нэг төрийн албан хаагчид л шагнал аваад байдаг ийм нөхцөл байдал бүрдчихсэн шүү дээ.

Тэгэхээр энэ топ 100 гэдэг юман дээрээ эргэж харахгүй бол яг л өнөөдрийн энэ тэнхимийн хуулийг оруулж ирээд байгаа шалтгаан нь энэ юм. Ерөөсөө нэг улс төрийн намын харьяалалтай, нэг бол том компаниудын л төлөөлөлтэй ийм болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 7 мянган ААН өнөөдрийн бүх хувийн хэвшил.../минут дуусав/

С.Бямбацогт: Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Энэ зүгээр нэг топ 100 гээд байгаадаа ч биш байхгүй юу даа. Энэ чинь бодвол, больё эхний мянган компанийг аваад хаячихъя тэр 100 ажилтантай компани хүртэл байя гэж бодъё. Түүнээс хойших дөнгөж бойжиж байгаа, зах зээл дээр бойжиж байгаа шинэ ААН-үүдээ танхимын зүгээс яаж дэмжиж, холбож өгч байгаа юм бэ гэдэг асуултад хариулахгүй байна. Танай үнэт зүйл, үнэт зорилго дээр чинь байна, үнэт зүйл дээр чинь байна. Анхлан бизнес эрхэлж байгаа ААН-үүдэд өнгөрсөн хугацаанд яаж анхаарсан юм бэ, яаж дэмжлэг үзүүлсэн юм бэ, ямар бодлогын дэмжлэг үзүүлсэн юм бэ?

Дараа нь өнгөрсөн 2 жилийн хугацаанд эдийн засгийн мөчлөг сөрсөн эдийн засгийн үеүдэд эдийн засгийн хүндрэлтэй үеүдэд ХАҮТ-аас ЗГ-т эсвэл УИХ-д эдгээр зүйлүүд дээр анхаараад ажиллавал манай жижиг, дунд бизнес эрхлэгчид хөл дээрээ тогтож үлдэх гээд байна, ажлын байраа хадгалж үлдэх гээд байна гэдэг бодлогын баримт бичиг боловсруулсан юм уу? Яагаад гэвэл та нар энэ хуульд оруулсан дээр чинь ЗГ-ын бодлогын баримт бичигт оролцоно гээд биччихсэн байна шүү дээ. Өөрсдөө хараат байдлаа ингээд өгөөд байна шүү дээ оролцоно гээд. Хууль дээрээ ингээд заагаад өгчихсэн байна. Тэгэхээр энэ юмнуудаа та нар өнгөрсөн хугацаанд яаж хангасан юм бэ? Надад жишээ.../минут дуусав/

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? 4 дүгээр микрофон.

Ц.Магнайбаатар: Топ 100 ААН-тэй холбоотой асуудал бол ерөнхийдөө Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байгаа ийм компаниудыг үнэлж байгаа. Эсрэгээрээ жижиг, дунд ААН-үүдийг эрэмбэлдэг, нийгэмд таниулдаг ХАҮТ дээр entrepreneur гээд арга хэмжээ 12 сард зохион байгуулагддаг. 30 гаруй номинациар ААН-үүдийг өөрсдийнх нь тайлан, процесс дээр нь үнэлээд олгодог. Энэ дээр жижиг, дунд, start-up компаниуд гэсэн ийм номинациудаар шалгаруулалтаа хийгээд явдаг.

ХАҮТ бол хувийн хэвшлийн төлөөллийн нэгдмэл байгууллага больё, дуу хоолойгоо төрд хүргэдэг больё гээд энэ дээр санал санаачилгуудаа үеийн үед гаргаад явж байсан. Хамгийн сүүлд миний мэдэж байгаагаар бол УИХ, намын бүлгүүдэд Эзэн 900 гээд хөтөлбөрүүдийг танхимаас, танхимын удирдах зөвлөлийн гишүүд, гишүүн байгууллагуудаараа хэлэлцүүлээд, санал санаачилгуудыг хүргэж ирсэн.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн нэмж хариулъя.

Д.Энхтүвшин: Жижиг, дунд ААН-үүд ажлын байр хамгийн их бий болгодог, тэгээд татвар хураамж дээр ч гэсэн эдийн засгийн тогтвортой өсөлтөд чухал хэсэг байгаа. Тэгэхээр энийг бол танхимын үйл ажиллагаанууд дээр одоо энэ салбарын танхимууд руугаа шилжчихээр энд тэр оролцоонууд илүү ойрхон болж, жишээлбэл яг танхим дээр чинь бол нэг боллоо гэхэд өөр, өөр төрлийн компаниуд байгаа

байхгүй юу. Худалдааны компани ч байж байдаг, том телеком, банкны салбарууд нь ч байж байдаг. Тэр олон газрууд, компаниуд хэлбэр хэмжээнүүд нь өөр, өөр газрууд нэг дор орчихоор ер нь үйл ажиллагааны хувьд яг ийм төвлөрч, анхаарах боломжууд нь хязгаарлагдмал байдаг. Тэгэхээр Танхимын үйл ажиллагаа дээр сургалтууд явж байгаа, ААН-үүд хоорондын харилцаа сайжруулах жишээлбэл зарим нэг хууль тогтоомжууд дээр орж ирдэг. Жишээлбэл том ААН-тэй хийсэн гэрээг жижиг, дунд ААН-үүдийн том компанитай хийсэн гэрээгээ барьцаалж зээл авах бололцоо боломж жишээлбэл энийг хууль, эрх зүйн орчныг нээх.../минут дуусав/

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалангийн урилгаар Нийслэлийн БЗД-ийн Социал Демократ МЗХ-ны гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Улс орныхоо ирээдүйг авч явах залуучууд та нартаа Улсын Их Хурлын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, ажилд нь амжилтыг хүсье. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуултаа асууя, алга байна. Жамбалын Ганбаатар гишүүн асуултаа асууя, алга байна. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу? Сургалт, зөвлөгөө, ХАҮТ-ын үйл ажиллагааг харахаар сургалт, зөвлөгөө болон гишүүддээ зориулсан үйл ажиллагаа явуулдаг гэж байгаа юм. Энэ дээр нь би нөгөө хөгжлийн бэрхшээлтэй мөртөө бизнес хийдэг хүмүүсийг дурдаж, тоо баримт асуумаар байгаа юм. Хэчнээн байгууллага тэр сургалт, зөвлөгөөнд нь оролцож ирсэн юм бэ? Ядаж сүүлийн 5 жилийн тоог ярих уу гэсэн нэг ийм мэдээлэл байна.

2-т гэвэл танайхаас ер нь миний мэдэхээр л лав 3, 4 жижиг аж ахуй нэгж байгууллага хаалгаа барьчихлаа л даа. Тэгээд дандаа аль болохоор иргэдэд эрүүл хоол өгдөг, зөв сайныг үйлчлэх гэж оролддог хэд хэдэн хоолны газар хаалгаа барьсан. Тэгэхээр ер нь энэ дампуурч байгаа бизнесийг аврахад аврах ямар төлөвлөгөө байдаг юм бэ? Тийм юм байдаг уу, эрсдэлийн ч юм уу, дампуурч байгаа гэж хэлж болох уу, авардаг төлөвлөгөө нь юу байдаг юм бэ? Танай дээр хандах юм уу, тэр хүмүүс ингээд аргаа барахаар хаана очих вэ гэдэг асуулт байна?

3 дугаарт нь Топ 100-нхаа шалгуур үзүүлэлтийг нэг задалж өгөөч. Юу, юу багтаж ордгийг нь, Топ 100-г шалгаруулдаг юм бэ?

4-д нь орон нутагт бизнесээ эхэлж байгаа хүмүүст яаж тусалдаг вэ? Тэд нарын хувьд ер нь ямар хамгаалалт, үйлчилгээ байдаг юм бэ гэсэн асуудлаар мэдээлэл авъя?

С.Бямбацогт: ХАҮТ-аас хариулъя, хэн хариулах вэ? Индрийн 4 дүгээр микрофон.

М.Сарандаваа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. ХАҮТ-ын зөвлөх Сарандаваа. Нэлээн олон удаа Топ 100 гээд дурдчихлаа. Тэгэхлээр Монгол Улсын бизнесийг л гадаад улсын зах зээл рүү холбох гэж байгаа, тэд нарыг дэмжин урамшуулж байгаа танхимын үндсэн 2 функцийн нэг байдаг. Тэр функцийг л үйл ажиллагаандаа нэвтрүүлж байгаа. Шалгуур үзүүлэлтийн тухайд татвар, нийгмийн даатгал, ажиллагсдын тоо, ашиг, эзний өмч гэсэн энэ 5 үзүүлэлтүүдийг хувийн жингээр нь жинлээд 30, 30, 20, 20, 20 буюу татвар төлж байгаа, ажлын байр бий болгож байгаа гэсэн 2 үндсэн үзүүлэлтийг нь 30, 30 хувийг өгөөд ингээд жинлээд

явж байгаа. Энэ бол олон улсын фортун буюу олон улсад томоохон компаниуддаа ингэж олгодог энэ шалгуур үзүүлэлтийн дагуу л адилхан ийм дэвжээн дээр гаргаж байна гэж ойлгох хэрэгтэй дэмжих чиглэлээр.

Нөгөө талаар орон нутагт 21 салбар танхимуудаараа дамжуулаад түрүүн хэлсэн танхимын 60 гаруй үйлчилгээгээр ЖДҮ-лэлийг бойжуулах, хамгаалах, дэмжих, В2В арга хэмжээнүүдийг олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг.

С.Бямбацогт: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Тийм топ 100 шалгаруулалтыг нь ойлголоо. Тэгэхдээ ер нь олон улсын нөгөө тогтвортой хөгжлийг дэмжсэн ч гэдэг юм уу, энэ олон улсын гэрээ, конвенцод заасан бизнес, том, жижиг бизнест тусгаж байгаа шалгуур үзүүлэлтүүд чинь энэнд ордоггүй юм уу гэдгийг тодруулмаар байгаа юм?

2-т гэвэл бойжуулдаг, дэмждэг гэж байна. Тэгээд хэчнээн ААНБ-ыг дэмжиж, бойжуулсан юм бэ? Хэчнээн байгууллагыг дампуурахаас аварсан юм бэ?

3-д би орон нутагт бизнес хийж эхэлж байгаа хүмүүст ямар үйлчилгээ байдаг юм бэ гэж тодруулах гээд байна л даа? Тэрийг хариулт өгөөч.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

М.Сарандаваа: Их чухал асуулт гэж бодож байна. Тогтвортой хөгжлийн чиглэлээр танхимаас 17 зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр хувийн хэвшлийн оролцоо хувь нэмрийг дэмжиж ирж байгаа. Үүний нэг жишээ нь байгаль орчин, нийгэм, засаглалын энэ стандартыг ААНБ, ЖДҮ-лэл эрхлэгч, олон нийтэд хувьцаагаа нээлттэй арилждаг энэ компаниудад суурь үнэлгээг нь боловсруулж өгөх, ногоон кредит тооцуулах, ногоон бонд гаргах энэ үйл ажиллагаа тогтвортой хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг нэлээн манлайлж ажиллаж байгаа. Холбогдох олон улсын байгууллагуудтай хамтраад.

Яг таны асууж байгаа сүүлийн 5 жилийн тоо яг хэдэн хөгжлийн бэрхшээлтэй гэдэг юм уу, манай ААН-үүдэд маань Хөдөлмөрийн тухай хуулиар оногдсон хуулийнхаа хүрээнд шаардлагаа биелүүлээд явж байгаа. Тэрний дээр бид та бүхэнтэй хамтраад өнгөрсөн жил хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэмжих чиглэлээр, бизнесийг нь менежментийн удирдлагын дээд түвшинд оруулах чиглэлээр хамтраад арга хэмжээ зохион байгуулсныг та санаж байгаа байх. Энэ нарийн тоог би танд дараа.../минут дуусав/

С.Бямбацогт: Отгоны Саранчулуун гишүүнд тодруулж асууя.

О.Саранчулуун: Тогтвортой хөгжлийн талаар мэдээлэл авлаа. Байгаль орчин гэдэг юм байна. Би нэг жишээ хэлэх гэсэн юм. Нэгэнт хууль, эрх зүйн орчныг сайжруулж байгаа бол нэгмөсөн л юм хиймээр байгаа. Юуг хөндөх гээд байгаа гэхлээр бид байгальд ээлтэй утаа гаргадаггүйг дэмжих хэрэгтэй байгаад байгаа. Тэгэхлээр утаа нүүрс түлэхгүй гээд аялал жуулчлалын юм уу нэг ресорт ажилладаг байгууллага байлаа, тог цахилгаанаар ажиллаад явахад тэнд ер нь ямар хөнгөлөлт, тэдгээрийг энэ байгаль орчинд ээлтэй байсных нь төлөө ямар бодлого барих юм бэ, ямар хөнгөлөлт юм уу эсвэл ямар зохицуулалт байх юм бэ? Энэ дээр танайх ямар бодлогын баримт бичиг гэдэг юм уу, юу гаргасан бэ?

Тэгээд дампуурч байгаа бизнес, ер нь дампуурах гэж байгаа бизнес танай дээр очоод аврагддаг ч юм уу нэг ийм, инкубатор байдаг юм байж. Тэгвэл бүүр балраад байгаа газрууд яг хаанаас тусламж хандах вэ гэдгийг дахиад хариулаад өгөөч. Маш олон байгууллагууд одоо дампуурч байгаа болохоор.

С.Бямбацогт: Хассуурийн Ганхуяг гишүүн хууль санаачлагч хариулъя.

Х.Ганхуяг: Энэ хууль тэнхимийн хууль. Тэгээд Саранчулуун гишүүн маш зөв асуултууд асууж байна. Гэхдээ бидний сая Саранчулуун гишүүн болон зарим гишүүдийн асууж байгаа асуултад бид өөрснөө хариулах ёстой. Яаж энэ ногоон хөгжлийг дэмжих гээд байгаа юм, яаж тэр утаагүй бизнесийг дэмжих гээд байгаа юм. Энэ Дампуурлын хууль жишээлбэл УИХ дээр ирээд 20 жил болж байна, одоо батлагдаагүй л байна. Дампуурах гэж байгаа аж ахуйн нэгж тэр хууль батлагдаж байж тэр процесс нь хялбар болгох, одоо дампуурах гэж байгаа бол яадаг ийдэг нөгөө процессыг нь хийх асуудал өнөөдөр Их Хурал дээрээ л гагцхисан байж байгаа шүү дээ. Тэгээд бид өөрсдөө энэ ажлуудаа хийхгүй бол тэнхим гээд ганц байгууллага жишээлбэл хувийн хэвшилтэй холбоотой бүх бодлогыг бариад явна гэж байхгүй. Гэхдээ энэ дээр бүх бодлогын юм дээр оролцоод явах ёстой. Гэхдээ тэр бидний өөрсдийн хийх ёстой гэрийн даалгавар байхгүй юу. Тэр төсвөө батлахдаа яаж баталж байгаа юм, хөгжлийн төлөвлөгөө батлахдаа яаж.../минут дуусав/

С.Бямбацогт: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуултаа асууя.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу, энэ өдрийн мэндийг хүргэе. Танхимын тухай хууль орж ирж байна. Манай Монгол Улсад 200 гаруй мянган ААН-үүд байгаад байгаа юм. Татвар төлж байгаа 60 гаруй мянган ААН-үүд, яг танхимын өөрийнх нь гишүүнчлэлтэй 6800 орчим гишүүд байна гээд байгаа юм. Тэгээд энэ ААН-үүдийг хамгаалдаг, өмгөөлдөг байгууллага бол танай ХАҮТ. Тэгээд төр бол ААН-үүдийг өнөөдөр татвар төлөгч л гэж харж байгаа. Тэгээд татвараа бол маш хүчтэй шахалт үзүүлж байгаад татварыг нь аваад байгаа шүү дээ ААН-үүдээс. Энэ цаг үед танхим ААН-үүдээ хэрхэн хамгаалж байна гэдэг асуудал.

Ковидын цаг үед 20 мянган ААН-үүд ер нь үйл ажиллагаа нь саарсан, үүд хаалгаа хаасан байгаа. Энэ ковидын дараах энэ ААН-үүдээ сэргээн босгох, үйл ажиллагааг нь жигдрүүлэх, хэвийн байдалд нь оруулахад нь танхим яаж ажилласан юм бэ? Өнөөдөр энэ татварын ачаалал ихсээд, ААН-үүд чинь татвараа төлж чадахаа больчихлоо. Бүгд л үүд хаалгыг нь хаасан, бүгд л татварынхаа дансыг хаалгасан ийм байна. Өнөөдөр Ерөнхий сайд энэ ААН-үүдийн дансыг нээ гэсэн, НДШ төлж чадаагүй компаниудын дансыг нээгээгүй л байгаа. Танхим яаж ажиллаж байна вэ энэ тал дээр?

ЖДҮ-лэл мөн л ижилхэн. Хөөрхий ингээд бөгтийгөөд л, бөмбийгөөд л, гүйгээд л байдаг. ЖДҮ-лэлийнхээ энэ түвшин дээр компаниуд 2, 3 жил л байх ёстой юм байхгүй юу. Үзэсгэлэнд ороод л, гар хийцийн үйлдвэрлэл хийчхээд л, тэгээд л хөгжихгүй байна шүү дээ. Танхим хэдэн ААН, жижиг, дундыг хөгжүүлж, дунд, том түвшинд авчрав?

Топ 100 ААН мөн ижилхэн. Одоогоос 15 жилийн өмнө дандаа л хувийн компаниуд оролцдог байсан шүү дээ. Топ 5 банк гээд л, бусад нь хувийн компаниуд

байдаг байсан. Одоо болохлоор бүгдээрээ тэр чигээрээ төрийн өмчийн бараг ихэнх компаниуд байна шүү дээ Топ 100 дотор чинь. Тэгээд энэ тогтолцооны төрийн өмчийн хэлбэр нь өөрчлөгдөөд байхад танхим ямар байр суурьтай байгаа юм бэ?

Бодлогын хүү мөн ижилхэн, маш өндөр бодлогын хүүтэй. ААН-үүдэд бага хүүтэй зээл олдохоо больчихсон. Одоо компаниуд чинь томрох нь битгий хэл бүгдээрээ Дампуурлын тухай хууль яриад байгаа байхгүй юу. Тэгээд энэ үед танхим хаанаа байгаад байгаа юм бэ? Танхимд өнөөдөр эрх мэдэл, цаг хугацаа багадаагүй. Тэгж харж байгаа. Институцийн хувьд үнэхээр санал хэлэхээс цаашгүй байгаа юм бол бид үр дүнд суурилсан хамтын ажиллагаа, хувийн хэвшил, түншлэлийн энэ модуль бодлогоо л энэ хууль дээрээ сайн суулгаж өгөх хэрэгтэй байна.

Түүнээс биш бид өнөөдөр яг бүтцийнхээ хувьд өөрчлөлт хийж байж энэ танхим сайжирна гэсэн ямар ч баталгаа байхгүй байгаа шүү дээ. Тэгтэл бид өнөөдөр бүтцээ л томруулах гээд байдаг. Энэ бүтэц чинь өөрөө улс төрийн шинжтэй ийм бүтэц болоод хувирчихвал яах юм, бодлогоо барьж авч чадахгүй бол яах юм бэ? Энэ ААН-үүдэд өмөөрдөг, хамгаалдаг хамгийн том дуу хоолойтой байгууллага танхим. Танхим энэ тал дээрээ л илүү анхаараасай гэж бодож байгаа. Хүсэлт, санал, баярлалаа.

С.Бямбацогт: Асуулт асуусангүй, санал хэллээ. Хууль санаачлагч хариулчихъя, асуулт гарлаа гэж байна.

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Ер нь бол эрх зүйн орчин чухал байгаа. Миний хувьд өмнө нь ХАҮТ-ын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсны хувьд яг УИХ-д орж ирээд хувийн хэвшлийн энэ хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр байр сууриа ямар нэгэн улс төр, нам, бүлгийн эрх ашгаас үл хамаарч яг энэ байр сууриа илэрхийлж байгаа. Жишээлбэл, төсвийн зарлагыг бууруулах, энэ зохистой түвшинд нь байлгах, хувийн хэвшлийн оролцоог сайжруулах гэх мэтчилнээр асуудлууд явж байгаа.

Саяын тэр татварын данстай холбоотой асуудал дээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл одоо бэлэн болчихсон. Өргөн барихаар тов дараалал хүлээж байгаа. Энэ дээр өнгөрсөн ААН-үүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг энэ харилцаа маань процессгүй, хувь хүн дээр бол баривчлахад тодорхой хугацаа байдаг бол ААН-ийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, дансыг нь хаах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах нь ямар ч процессгүй байгаа учраас энэ хуулийг жишээлбэл өөрчлөхөөр ажиллаж байна. Энэ танхимын хуулийг тодорхой хэмжээнд энэ бол зөвхөн өнөөдөр бид Ганхуяг гишүүн бид 2-ын асуудал биш, энэ өмнө нь Амартүвшин Ерөнхийлөгч өргөн барьж байсан, дараа нь Ганхуяг гишүүн ажиллаад Хууль зүйн яам өргөн барьж байсан. Тэгэхээр энэ эрх зүйн орчныг сайжруулахгүй бол одоогийн байдал хангалтгүй байгаа учраас энэ хуулийн жишээлбэл төслийг оруулж ирж хэлэлцүүлэхээр бэлдэж байна. Гэх мэтчилнээр энэ хууль, эрх зүйн орчнуудыг нь сайжруулахгүй бол хэн нэгэн дарга гарч ирээд ч юм уу, сайд дарга гарч ирээд өөрчлөхөөр бол ийм хүнээс хамаарсан ийм түр зуурын шийдлүүд болоод байгаа.

Тэгэхээр энэ углуургаар нь хууль, эрх зүйн орчнуудыг нь сайжруулах зайлшгүй шаардлага байгаа. Тэгээд энэ чиглэлээр УИХ-д ч гэсэн өмнөх Улсын Их Хурлуудыг бодвол шинээр болон бизнест ойрхон гишүүд нэлээн олон сонгогдсон

байгаа учраас энэ талаар бол тодорхой хэмжээний ахиц дэвшлүүд гарах байх гэсэн ийм хүлээлттэйгээр хуулийн төслүүд санаачлаад, эхнээсээ ингээд өргөн баригдаад, хэлэлцэгдэж эхэлж байна. Та бүхнийг энэ хувийн хэвшлийн орон зайг тэлэх энэ бололцоо боломжуудыг эрх зүйн талаас нь хамгаалж, дэмжиж өгөөд, сайжруулах зүйлүүд байвал ажлын хэсэг дээр сайжруулаад явах бололцоотой гэж харж байна.

Тэгэхээр түрүүн өмөөрөх гэсэн асуудал ярилаа. Яг үнэндээ бол юун өмөөрөх, яг л ААН-үүдийн жишээлбэл тодорхой хэмжээгээр танхимын удирдлага байр суурь илэрхийлбэл тухайн бизнестэй нь хариуцлага тооцдог, тухайн бизнесийг нь дарамталдаг иймэрхүү харилцаа байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг хүнээс хамааралтай биш, энэ үндэсний танхимын компаниуд бүрдүүлдэг биш, салбар танхимууд, энэ мэргэжлийн холбоод нь төлөөлөл нь ордог ийм байдлаар зохицуулж байгаа. Тэгэхгүй бол ер нь энэ улс төрийн салхинд бол, улс төрийн намаас өөр институт байхгүй болчихсон энэ үед эдийн засгийн энэ хувийн хэвшлийн орон зайг тэлэх энэ бололцоо бол үнэхээр хязгаарлагдмал байгаа. Тэгэхээр бид өмнөх шигээ ингээд тархай бутархай ч юм уу, баахан холбоод яваад, хүн болгон нэг, нэг жишээлбэл ТББ-тай энэ олон холбоодыг улс төрийн хүч нь өөртөө хэрэгтэй байдлаар ашигладаг энэ байдлаас гарах зайлшгүй шаардлагатай байгаа. Тэгэхээр энэнээс гарахын тулд.../минут дуусав/

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатарын урилгаар Монгол 92-Эвсэг барс холбооны төгсөгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Наранбаатар гишүүн маань гадаад томилолттой байгаа. 92 онд 10 дугаар анги төгссөн төгсөгчдийн төлөөлөл манай Батболд гишүүн, энд Ренчиндоржийн Батболд гишүүн сууж байна, олон гишүүд байгаа 8, 9 төлөөлөлтэй. Нийт төлөөлөл болон Улсын Их Хурлын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс та бүхний ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Би Монгол 92-ын төлөөлөл байгаа шүү, төгсөгчдийн төлөөлөл. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя. Тодруулах уу? Пунсалмаа, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн тодруулж асууя.

Б.Пунсалмаа: Тэгээд бүтцийн талаар дахиад асуугаадахъя л даа. Орон нутагт салбарууд байгаад байгаа юм. Тэгэхлээр тэр нэг орон нутагт байгаа нэг салбар чинь 50 гишүүнчлэлтэй салбар нь орон нутагт нэг байгуулагдчихлаа гэхэд тэрэн шиг дахиад 2 дахь салбар байгуулагдвал яах юм бэ? Энийгээ хэрхэн зохицуулах юм бэ?

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн хууль санаачлагч хариулъя.

Д.Энхтүвшин: Энэ нөгөө анх эхэлж танхим байгуулагдах санаачилга гаргах этгээд нь 50 байгаа юм. Тэгэхээр энэ хэрэгжүүлэлт, хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тодорхой зохицуулалтуудыг энэ хэрэгжилтийн тухай хууль гэж тусад нь дагалдуулж байгаа. Энэ дээр тодорхой зааж оруулах бололцоотой. Энэ 50 нь нийлээд санаачилга гаргаад, тэрийгээ тодорхой хугацаанд, энэ жишээлбэл би юунд Дархан-Уул аймагт ч юм уу ийм танхим байгууллаа, ийм саналтай байна, ийм ААН-үүд нийлээд энийг хуралдах санал гаргаж байна гээд, энэ саналаа тодорхой хэмжээнд олон нийтэд, дээр нь танхим өөрөө энийг сурталчилж, таниулж, бусад ААН-үүдэд тэр зарыг нь хүргэх, хамрах байдлыг нь нэмэгдүүлэх тал дээр ажиллах ёстой.

Тэгэхээр энэнтэй холбоотой зохицуулалтуудыг нь дагаж хуулийн хэрэгжилттэй холбоотой энэ журам дээрээ зохицуулаад явах бололцоотой. Тэгэхээр өөрөөр хэлбэл аль болохоор санаачилга нь 50-аар, 50 дээр нэмэх гэж гараад, энэ хамрагдах байдлуудыг нь нэмэгдүүлэхийн тулд дараа нь маргаан гаргахгүйн тулд танхимын яг энэ хуулийн.../минут дуусав/

С.Бямбацогт: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Энэхүү хуулийн төсөл нь улс төрөөс ангид, нэг компанийн асуудал биш, тодорхой салбарын эрх ашгийг хамгаалах зэрэг гээд олон ийм томоохон бодлогын болоод, бүтцийн өөрчлөлт оруулж байгаа учраас энэ ХАҮТ-ын шинэчилсэн найруулгын төслийг дэмжиж байгаа. Тэгээд аливаа өөрчлөлт бол мэдээж тодорхой хэмжээний эсэргүүцэлтэй тулгарна. Ялангуяа гишүүдийн тодруулж асуугаад байгаа энэ төртэй холбоотой асуудлууд гээд. Тэгэхээр хууль санаачлагчаас асуух гээд байгаа нь өмнөх ХАҮТ дээр байсан ямар үйл ажиллагаанууд энэ шинэ хуульд байсан нь хасагдсан бэ, эсвэл шинээр нэмэгдсэн бэ, ямар үйл ажиллагааг шинээр хийхээр болж байгаа юм бэ?

Төртэй холбоотой хийдэг төрийн зарим үйлчилгээг эрхлэх тухай хуульд үйл ажиллагааны хэлбэрүүд өмнө нь байсан санагдаад байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр нэг тодорхой хариулт өгөөч? Тэгвэл нөгөө гишүүд маань илүү ойлгомжтой болох юм болов уу л гэж бодоод байна.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

М.Сарандаваа: Нэлээн олон гишүүд хөндөж байна. Төртэй ажиллах, хамтарч ажиллах танхимын оролцоо хамааралтай байдалтай холбоотой ингээд хэтэрхий хамаарал үүсчих юм болов уу гээд. Тэн дээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаарх баримтлах бодлого байдаг. Төрийн үйлчилгээг ямар учраас, ямар этгээдэд шилжүүлж болох вэ, ямар хэлбэрээр байж болох вэ гэдэг зохицуулалтыг, бодлого нь байдаг. Мөн 2017 онд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн 17 оны 01 сарын 01-нээс.

Дээрээс нь дэлхийн бүх танхимуудын хийдэг үйл ажиллагаа бол энэ бодлогын өмгөөллийн үйл ажиллагаа байдаг. Нэг ёсондоо бизнесийн орчин таатай ээлтэй л болгох энэ бодлого, журмуудад танхимын дуу хоолой, бизнес эрхлэгчдийн дуу хоолойг л холбож өгөх. Энэ утгаараа өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 257 хууль бизнесийг ямар нэгэн хэмжээгээр бизнесийн үйл ажиллагаанд оролцож байна. 110 хууль нь бизнесийн эрх чөлөө, бизнесийн үйл ажиллагааг чөдөрлөж байна гэж судалгааны дүн гарсан байгаа. Тэгэхлээр энэ чиглэлээр танхим дүр эсгэсэн хамтын ажиллагаа биш, илүү үр дүнд суурилсан хамтын ажиллагааг гаргаж ирэхийн тулд институцийн хамтын ажиллагаа энэ дээр их чухал юм байна.

Тийм учраас өнөөдөр энэ хуулийн төсөл болон танхимаас өгсөн санал дээр энэ талын зохицуулалтуудыг нэлээн тодруулж, танхим хувийн хэвшлийн төлөөллийн төв байгууллагын хувьд байр суурийг зөвхөн саналаа өгөөд орхих биш, тэр санал нь тусгагддаг байх тэр оролцоотой, үр дүнтэй механизмыг л бий болгох чиглэлээр ярьж байгаа. Энэ чиглэлээрээ Төр, хувийн хэвшлийн түншлэл, Төр, хувийн хэвшлийн хэлцлийн тухай хууль дээр хүртэл танхим саналаа өгөөд явж байгаа. Энэ Дэлхийн банкнаас гаргасан аргачлалын дагуу явж байгаа ийм үйл ажиллагаа байдаг. Баярлалаа.

С.Бямбацогт: Соронзонболд гишүүн тодруулж асууя.

Л.Соронзонболд: Би яах вэ нэг тодорхой асуугаад байна шүү дээ. Өмнөх хууль дээр байсан эрхэлдэг үйл ажиллагаанаас чинь энэ шинэ хуулийн төсөл дээр ямар нь хасагдсан юм бэ, шинээр ямар үйл ажиллагаа эрхлэхээр болж байгаа юм бэ л гэж асуусан?

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

М.Сарандаваа: Хасагдсан үйлчилгээ байхгүй байгаа. Эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа байгаа танхимын дэргэд байдаг үйл ажиллагааг нэмж оруулсан байгаа. Хосмог тогтолцоотой холбоотой тодруулж, дэлгэрүүлж оруулсан зарим нэг зохицуулалтууд байгаа мэргэжлийн боловсролтой холбоотой гэсэн үг.

С.Бямбацогт: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Бид хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжих эсэхийг шийдвэрлэх гэж байгаа. Тийм учраас илүү доторх заалтууд гэхээс илүү үзэл баримтлалын шинжтэй асуулт асууя. 1 дүгээрт, яг энэ нэг танхим, Нэг улс, нэг танхим гэдэг энэ зарчмаар хууль орж ирж байна. Энэ манай улсад ер нь хэр оновчтой вэ? Ялангуяа Үндсэн хуульд заасан эвлэлдэн нэгдэх эрхийг тодорхой хэмжээгээр хязгаарлах хязгаарлалт болохгүй юу гэдэг дээр байр сууриа илэрхийлээч. Яг тодорхой судалгаа байвал яг судалгаа эшлээд хэлээч гэсэн үг. Үүнийг яагаад асуугаад байна вэ гэвэл бусад мэргэжлийн холбоод, бусад энэ ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг, компаниудыг, ААН-үүдийг төлөөлж төртэй харилцаж байгаа эдгээр холбоодыг дефакто 2 дугаар зэрэгт шууд оруулж байна л гэсэн үг л дээ. Тэгэхээр энэ маань өөрөө шууд хязгаарлалт гэхээс илүү шууд бус хязгаарлалтыг бодитой үүсгэх ийм сөрөг нөлөөтэй байна. Тэгэхээр энэ сөрөг нөлөөг яаж бууруулна гэж харж байгаа вэ гэсэн нэг асуулт?

2 дугаарт, энэ ХАҮТ одоогийн байгаа институц нь, одоогийн байгаа байгууллага нь танхим нь дотоод ардчиллын индекс ямар вэ? Та хэд ер нь нэг дотоод ардчиллын индексээ үнэлж, дүгнэж үзэж байсан ийм судалгаанууд хийгдэж байсан уу? Танай байгууллагын дотоод ардчилал дээр анхаарах ёстой ямар асуудлууд байдаг гэж та нар өөрсдөө хардаг вэ гэсэн ийм 2 дахь асуулт?

3 дугаарт, Монгол Улс ардчилсан нийгэм. Ардчилсан нийгмийн хамгийн гол чухал бүрэлдэхүүн хэсэг бол иргэний оролцоог хангах байгаа. Тийм учраас би эдгээр асуултыг асуугаад байгаа юм. Тэгэхээр иргэний оролцоог хангах, тэр дундаа олон ургалч байдлыг тэлэх тал дээр танхим ямар бодлого барьдаг вэ? Жишээ, маш тодорхой жишээ хэлээч гэсэн ийм 3 асуулт байна.

Тэгээд түрүүн тэнд Пунсалмаа гишүүн асуугаад байсан. Энэ яг ХАҮТ бодлогын нөлөөлөл гээд. Энэ дээр би нэг одоо энэ жил болгоны эцэст дандаа татвар төлөхгүй байна гээд энэ ААН-үүдийн дансыг хаадаг явдлыг аль нэг Ерөнхий сайд, тухайн үеийн Сангийн сайд гарч ирээд л данс хаахааргүй болголоо гээд дандаа ийм улс төрийн шинжтэй үйл ажиллагаа болоод яг ийм улс төрөөс хамааралтай данс нь нээгддэг, хаагддаг байдал жил болгон үргэлжлээд байна. Энийг болиулах тал дээр танхим ажиллах уу? Үүнийг болих тал дээр та нар идэвхтэй, бодитой үйлдэл хийж байсан уу? Би судлаад үзэхээр 2014 оноос хойш

жил болгон л дансыг нь хаана, буцаагаад Сангийн сайд нь, эсвэл Ерөнхий сайд нь данс хаахаа болилоо, тэдэн мянган ААН-ийн дансыг чөлөөллөө гээд л ингэж байдаг. Тэгэхээр энэ чинь ерөөсөө данс нь хүртэл улс төрөөс хамааралтай байхаар яаж ААН-үүд чинь бие даах юм бэ? Тэгэхээр энэ дээр яг жишээ нь, энэ бол хамгийн элементарны наад захын жишээ байгаа шүү дээ. Энэ дээр жишээ нь танай ХАҮТ 14 оноос хойш юу хийсэн бэ? Ийм асуулт.

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн хууль санаачлагч хариулъя. Дараад нь ажлын хэсэг бэлдэж байгаарай, танхим 4 дүгээр микрофон.

Д.Энхтүвшин: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Танхимын нэлээн олон загварууд байдаг. Заавал гишүүнчлэлтэй ААН-үүд нь бүгдээрээ энэ танхимдаа нэгддэг, тэндээ татвар хураамжаа төлдөг ийм загвараас авхуулаад зүгээр нэг ТББ шиг эвлэлдэн нэгддэг, тусдаа чөлөөтэй эвлэлдэн нэгдэх тэр хэмжээндээ үйл ажиллагаа явуулдаг ийм зохицуулалт гэсэн 2 хязгаар дунд янз бүрийн загвар, хувилбаруудыг сонгож авдаг. Тэгээд 2002 он, 22 онд энэ хуулийн анхны төслийн үзэл баримтлал нь болохоор яг энэ нэг яг таны саяын хэлээд байгаа нэг танхим байх энэ зарчим руугаа өөрөөр хэлбэл ААН-үүд нь бүгдээрээ энэ танхимдаа бүртгэлтэй байдаг Герман, Австри, Франц гэх мэтчилний энэ загвар луу шахсан ийм хуулийн төсөл орж байсан.

Тэгээд тухайн үед үзэл баримтлалын хүрээнд дэмжигдээгүй учраас. Тэр үед бусад ААН, төрийн бус байгууллагуудтай уулзалт хийсэн. Гадаад байгууллагууд, гаднын улсуудын худалдааны танхимууд, AmCham, AustCham, тэгээд бусад танхимуудтай уулзалт хийсний хүрээнд энэ зохицуулалт Монгол Улсын хувьд одоогоор зохимжтой биш юм байна гээд. Нөгөө талдаа ингээд одоогийнх шиг ингээд чөлөөтэй орхичихвол зүгээр нэг төрийн бус байдлаар ингээд зохицуулаад явъя гэвэл бидний хувьд энэ эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоо, дуу хоолой бол үнэхээр хүчгүй сул байна. Саяын тэр данс тооцоотой холбоотой асуудлуудыг байнга ярьдаг, ААН-тэй холбоотой энэ хуулийн төслүүд дээр байнга санал илэрхийлдэг. Тэгээд энэ нь ерөөсөө бодлого боловсруулж байгаа, шийдвэр гаргаж байгаа хүмүүсийн энэ тусдаггүй. Ер нь сонссон болоод л өнгөрдөг. Хуулийн бүрдүүлбэр хангах үүднээс хэлэлцүүлэг хийгээд л өнгөрдөг. Тэрнээс ерөөсөө идэвхтэй сонсдоггүй.

Өөрөөр хэлбэл энэ тэгш бус харилцаан дээр тарчихсан олон холбоод тэгэхээр хүссэн холбоогоо дуудаж авч өөрийнхөө хэлсэн үгээ хэлээд л, зарим үед танхимыг ашиглана, танхимыг ашиглахгүй гэсэн иймэрхүү байдлаар явдаг учраас энэ дундын хувилбар буюу илүү энэ танхим тодорхой хэмжээнд нэгдлийг нь сайн дурын үндсэн дээр энэ бий болгох, тэрнээс гадна бусад энэ олон улсын худалдааны танхимууд болон бусад энэ бизнесийн чиглэлийн мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарлахгүй, энэ нь өөрсдөө чөлөөтэй дуу хоолойгоо илэрхийлээд явах бололцоотой ийм завсрын хувилбарыг сонгож авч, хуулийн төсөлд оруулж танилцуулсан байгаа юм.

Тэр данстай холбоотой асуудал дээр яах вэ түрүүн би хэлсэн. Татварын хууль дээр бол танхим тодорхой байр сууриа энэ Татварын хуулийг л өөрчлөхгүй болохгүй байгаа. Дээр нь түрүүн хэлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай дээр ААН, бизнесийн байгууллагад хариуцлага тооцохдоо процессгүйгээсээ болоод хэрэг хянан шийдвэрлэх явцдаа, мөрдөн шалгах явцдаа бараг хүнээр бол цаазаар

авах ялыг ААН-д өгчихдөг, компани цаашаа данс үйл ажиллагааг нь хязгаарласнаар хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг нь.../минут дуусав/

С.Бямбацогт: Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Ажлын хэсэг нэмж хариулъя, 4 дүгээр микрофон.

Ц.Магнайбаатар: Яг өнөөдрийн байдлаар яг дотоод ардчиллын индексээр бол хийсэн судалгааны ажил байхгүй. Гэхдээ танхим олон улсын нөгөө нэг танхимуудын, танхимтайгаа хамтраад үйл ажиллагаа дээрээ бенчмаркинг, засаглалын бенчмаркинг хийсэн. Тэгээд ил тод байх, танхим тунгалаг байх энэ чиглэлүүдээрээ бол бенчмаркинг хийгээд явсан. Энэ талаарх саналаа бол бид бүхэн танхимаас боловсруулсан санал дээрээ тусгаад, хууль санаачлагчид өгсөн байгаа. Ер нь ХАҮТ-ын одоо мөрдөгдөж байгаа үйл ажиллагаагаараа Их хурлыг бол зохион байгуулахдаа Ардчиллын зарчмаар зохион байгуулж ингээд явагдаж байгаа. 75 Удирдах зөвлөлийн гишүүн байна, 25 тэргүүлэгч гишүүд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн төлөөллийн, бүгд хувь гэх юм уу, ардчилсан.../минут дуусав/

С.Бямбацогт: Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Иргэний Зориг ногоон намын 2024 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрт байгаа л даа. Ер нь ашгийн төлөөх ЗГ-ын ААН байж болохгүй юм гэж. Бизнесийнхэнтэйгээ ашиг булаацалддаг төрийн өмчит, орон нутгийн өмчит ЗГ-ын компани байж болохгүй юм гэдэг ийм мөрийн хөтөлбөртэй. Тэгээд энэ яах вэ гэхдээ өнөөдөр ТӨК-уд амьдрал дээр бүгдээрээ байдгаараа байж байна. Татвар, хураамж, ДНБ-ий үйлдвэрлэлийн бас томоохон хувийг эзэлж байна. Энэ гишүүнчлэл дээрээ ТӨК-уд гишүүн болохгүй гээд 16.6 дээр байсан билүү дээ байж байсан. Танхим дотор ТӨК-уд байвал тэд нар маань хувийн хэвшлийн ААН-үүдтэйгээ хамтарч ажиллах, тэгэхдээ удирдах бүрэлдэхүүнд нь сонгогддоггүй байх иймэрхүү зүйлүүд дээрээ хэрэгтэй зүйл байж болохгүй юу гэдэг, энийгээ юу гэж бодсон юм бол гэдэг талаар нэг асуумаар байгаа юм?

Ажлын хэсэгт дандаа ХАҮТ-ын төлөөлөл орсон байна. Хувийн компани, ААН-үүд энэ ажлын хэсэгт орж болоогүй юм уу? Зөвхөн нөгөө танхим гэдэг байгууллагынхаа эрх ашиг, ашиг сонирхол тэрийгээ илүү хамгаалаад, хувийн ААН-үүд танхимд хамааралгүй ААН-үүд юу болж байна вэ гэдэг тухайд бодоогүй юм шиг энэ бүрэлдэхүүнийг нь харахад тэгж харагдаад байна. Танхимынхаа хараат бус байдал дээрээ 5.1.2, 27.1 дээр заасан байсан нөгөө төрийн бодлого боловсруулахад оролцох Зөвлөлд оролцох эрх бас 6.1 дээрээ ингээд байж байгаа. Тэгэхээр төрийн бодлогынхоо шийдвэрт оролцох хэр нь улс төрөөсөө хараат бус байдлаа бодитоороо хэрхэн хангах юм бэ? Хуульдаа болохоор бодлого боловсруулахад орно, төрийн байгууллагад санал өгнө, арбитрад зуучилж, үнэлгээ хийдэг олон чиг үүргүүдээ нэг дор ингээд төвлөрүүлчихсэн байж байгаа.

Тэгэхээр танхим маань нэгэн зэрэг бодлогод нөлөө үзүүлээд, үйлчилгээ үзүүлээд, дээрээс нь маргаан шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх нь ашиг сонирхлын зөрчлүүдийг нь яаж тооцож уялдааг нь, харилцааг нь хангаж байгаа юм бэ гэдэг асуултууд байж байна.

Том компаниуд танхимыг эзэмших эрсдэлийг нь хэрхэн хязгаарлах юм бэ? Нэг бол 1 хүн их уддаг, үгүй бол нэг том компанийн нөгөө энэ танхимын гол

бодлогын шийдвэр болон үйл ажиллагааны чиглэлүүдийг нь гаргаад явчихдаг. Тэндээсээ дарга болон тэргүүлэгчид нь сонгогдоод эхэлдэг. Энэ асуудлуудынхаа хязгаарлалтыг нь яаж оруулж байна вэ? Санхүүжилт дээрээ гишүүнчлэлийн хураамж, хандив, үйлчилгээний орлого эд нар гэдэг дээрээ их асууж, энэ орлогоос үүсэх нөлөөллийг хэрхэн ил тод, хяналттай болгох вэ? Яаж болгож байгаа юм бэ гэдгийг асууж байна.

Танхимд төрийн чиг үүрэг шилжүүлэхдээ төрийн зарим чиг үүргийг энэ танхимдаа шилжүүлсэн нь бид чинь байсхийж байгаад ҮХЦ-ээр хуулийн зүйл, заалт тохирохгүй байна гээд байсан. Энийгээ их сайн бодож чадсан уу? Үүн дээрээ нэг анхаарахгүй бол асуудал үүсэж магадгүй юм байна гэсэн ийм зүйл харагдаж байна. Тэгээд энэ хууль маань үнэхээр энэ бизнесүүдээ хамгаалах юм уу, эсвэл цөөхөн томоохон компаниудад эрх мэдэл төвлөрүүлэх хууль болчих вий. Танхимд ЖДҮ-лэл эрхлэгчдийнхээ дуу хоолой, эсвэл дуу хоолой болж чадах уу, эсвэл ингээд томоохон бизнес эрхлэгчдийн дуу хоолой болсон, шийдвэр болсон ийм зүйл явж байна уу гэдэг? 200 гаруй мянган ААН байгаа гэж байдаг, зуун хэдэн мянга.../минут дуусав/

С.Бямбацогт: 13 цаг болж байна. Энэ танхимд цөөхөн гишүүд асуулт асуухаар нэрс үлдсэн байна. Тэгээд асуултаа асууж дуустал хуралдаанаа үргэлжлүүлчихье цагаа сунгаад. Тэгээд үг хэлэхээ бол үдээс хойш 14 цагаас нөгөө Эд, эрхтэн шилжүүлэх тухай хуулийн төслийн 72 санал хураалт байгаа. Түүний дараа үгээ хэлж, үгээ хэлнэ. Тийм болохоор энд танхимд сууж байгаа гишүүд асуултаа асуугаад, чуулганаа завсарлаад, 14 цагаас харин маш чухал хуулийн санал хураалттай гишүүдийг танхимдаа цагтаа цуглахыг урьж байна. Хариулт Энхтүвшин дарга, хэн хариулах вэ? Ганхуяг гишүүн, Хассуурийн Ганхуяг гишүүн хууль санаачлагч хариулья.

Х.Ганхуяг: Тэгээд ер нь юу Батбаатар гишүүний асуугаад байгаа асуултууд яалт ч үгүй чухал асуултууд байна. Энэ хэлэлцэх эсэх, тэгээд л шинэчилсэн найруулга байгаа. Тэгэхээр таны санаа зовниж байгаа асуудал би энэ хуулийн төслийг Их Хурлын даргаа болж өгвөл ажлын хэсэг байгуулахдаа сөрөг хүчний төлөөллөөр ажлын хэсгийг нь ахлуулаасай гэж хүсэж байгаа юм. Яг ингээд хувийн хэвшилтэйгээ ажиллаад. Одоо энд байгаа ажлын хэсэг маань зүгээр энэ хуулийг боловсруулах л ажлын хэсэг болохоос биш энэ хуулийг нөгөө хэлэлцүүлэх ажлын хэсэг биш. Тийм учраас танхим сууж байгаа гэсэн үг. Гэхдээ энийг хувийн хэвшилд асар олон удаа хэлэлцүүлэг хийсэн юм. Нэг ёсондоо хувийн хэвшилтэй хэлэлцүүлэг хийгээд, тэгээд энэ чинь үг, үсэг болгон хувийн хэвшилтэй зөвшилцсөний үндсэн дээр орж ирсэн байгаа.

Гэхдээ ажлын хэсэг байгуулаад, энэ дээр шинэчилсэн найруулгад энэ дотор байгаа зүйл, заалтыг өөрчлөх боломжтой. Тийм учраас энэ болж өгвөл энэ танхимын энэ хуулийг болж өгвөл энэ сөрөг хүчнээр ахлуулаад явчихвал их сайн байгаа юм. Энэ сөрөг хүчний нүдээр харах ёстой, улс төрөөс хамааралгүй болох ёстой. Тэр ТӨК-удыг яагаад хязгаарлаад байна гэхээр танхимын бодлого өөрөө улс төр болон ЗГ-аас хамааралгүйгээр явдаг байх ёстой. Яагаад гэхээр эдийн засгийн ихэнх хууль дээр танхимд төлөөлж суудаг юм нөгөө хувийн хэвшлийг төлөөлж орж ирж суудаг гэсэн үг. Тийм учраас энэ дээр хязгаарлаад байгаа.

Тэр дарга, цэрэг болоход нь ТӨК-удыг хязгаарлаж байгаа. Ерөөсөө гол санаа аль болох том компаниудаас хол байлгая, улс төрөөс хол байлгая, тэгээд дуу хоолойгоо чөлөөтэй, хараат бусаар илэрхийлдэг байя л гэдэг гол санаа юм. Салбар

энэ тэнхимүүдийг бий болгосноор таны ярьж байгаа, одоо бидний яриад байгаа тэр ЖДҮ буюу одоо бид үндсэндээ ЖДҮ, тэгээд том компаниуд л гэсэн 2 байдлаар л хуваачхаад байгаа байхгүй юу ААН-үүдээ. Тэн дотор нь уул уурхайн, уул уурхайн бус гээд байгаа. Гэхдээ ЖДҮ гэдэг маань өөрөө хэмжээг л заагаад байгаа болохоос биш тэр салбарыг нь заахгүй байгаад байгаа. Жишээлбэл тэр start up байж болно, мэдээлэл технологийн компани байж болно, эсвэл тэр 8 нэрийн барааны дэлгүүр байж болно, эсвэл оёдлынх нь байж болно, тэр салбар нь өөрөө хүсвэл сайн дурын үндсэн дээр тэнхимээ байгуулаад явбал энэ өнөөдрийн байдлаар 7000 ААН хамаарч байгаа бол төлөөлөх төлөөлөл нь орж ирэх энэ компаниудын тоо эд нар нэмэгдэх боломжтой гэж харж байгаа юм. Баярлалаа.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 13 цаг 02 минутаас хуралдааныг даргалав.

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвжавын Сайнзориг гишүүн алга байна. Болдын Уянга гишүүн асуултаа асууя.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Танхимын, ХАҮТ-ын тухай хуулийн яг одоогийн хүчин төгөлдөр байгаа хууль дээр жаахан сууж одоогийн та хэдийн оруулж ирсэн хуулийн дүгнэлтийг нь үзэл баримтлал дээрх мэдээлэлтэй нь танилцсан. Одоогийн хуулийнхаа 1 дүгээр зүйл дээрээ энэ хуулийн зорилт нь болохоороо танхим болон төрийн ба ТББ, иргэн, ААН-ийн хоорондын харилцааг зохицуулахад оршиж байгаа ийм хууль байгаа юм байна. 3.1-д нь болохоороо ААН байгууллагуудаас худалдаа, үйлдвэрлэл эрхлэхтэй холбогдсон нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах болон худалдаа үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор байгуулсан ашгийн төлөө бус хуулийн этгээд. Яг ийм байдлаар манай ХАҮТ үйл ажиллагаагаа явуулж байгаа юм байна.

Яагаад ч юм танай байгууллагыг дандаа ашгийн төлөө байгууллага гэж боддог байлаа. Яагаад тэгж байгаа юм бол? 2020 оноос хойш яг танай энэ одоогийн хүчин төгөлдөр хуулийн 3.1-д заасан өөрсдийнхөө гишүүн байгууллагуудын эрх ашгийг хамгаална гэж байгаа энэ дээрээ яг юу хийснээ аягүй тодорхой яг танхимаас ирсэн хүн нь хариулаад өгөөч? Яагаад ингэж асууж байгаа юм бэ гэхээрээ сая энэ долоо хоногт Хүмүүнлэгийн их сургуулийн оюутнуудтай уулзсан юм. Тэгээд уулзсан юу гэж байна гэсэн нэг залуухан эрэгтэй хүүхэд асууж байгаа юм л даа. Төр ингээд юм болгонд оролцох юм, янз бүрийн хууль эд нар гаргахаа больчихооч. Шаардлагатай биш бол ер нь хуульчилж яах гээд байгаа юм бэ? Тэгэхээр танай энэ одоогийн хуулийн зорилтыг уншихаар энэ хууль байсан, байгаагүй ААН-үүд нэгдээд, өөрсдөө дундаасаа аль нэг хүнээ томилоод, төрийн байгууллагад мэдээллээ хүргээд, эрх ашгаа хамгаалчих юм биш үү? Тэгэхээр энэ хууль байх үндсэн шалтгаан нь яг юу юм бэ гэдгийг хэлээд өгөөч? Танхимынхан өөрсдөө хариулбал их зүгээр гэж бодож байна.

Одоогийн хууль дээр нь 50-аас доошгүй ААН-үүд нэгдээд танхим байгуулж болох зохицуулалт чинь угаасаа байдаг юм байна. Эдийн засгийн байнгын хороон дээр орж ирэхэд гишүүд яагаад 50 гэсэн тоог авсан юм бэ гээд асуугаад байсан. Тэгээд ухаад үзэнгүүт энэ чинь одоогийн хуулийн зохицуулалт чинь юм байна. Энэ хууль 1995 онд батлагдсан хууль боловч яг энэ 50 ААН гэдэг чинь 2002 оны 7 сарын 4-ний өдөр орсон өөрчлөлтөөр орж ирсэн юм байна. Тэгтэл өнөөдөр 2026 онд орж ирж байхдаа дахиад 50 ААН гэдэг энэ тоо чинь өөрчлөгдөхгүй байна. Яагаад тэгж байгаа юм бэ? 2002 онд Монгол Улс 2,5 сая хүнтэй байсан юм байна, ААН-ийн тоо

нь 29 мянга байж. Одоогийн статистикаа харвал 2025 оны байдлаар л 3,5 сая гараад явчихсан хүн амтай, яг идэвхтэй бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН нь 115 мянга буюу 4 дахин өсчихсөн байна шүү дээ. Тэгэхээр энэ 50 гэсэн тоон дээрээ ядаж ажиллаад, тэгвэл 4 өссөн юм бол өнөөдөр 2026 он 200 ААН нэгдэж байж танхим байгуулах ёстой юм байна гэж ядаж суурь тооцооллоо харах ёстой байсан юм биш үү? Нэг тийм дутуу юм шиг санагдаад байгаа учраас энэ хууль байх зайлшгүй шаардлагыг ойлгомоор байгаа учраас хариулт авахыг хүсэж байна.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулах уу? Танхимынхан хариултыг эхлээд, 4 номерын микрофон.

Ц.Магнайбаатар: ХАҮТ бол бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаална гээд одоогийн байгаа хууль дээр заагдсан байгаа. Гэхдээ энэ дээр нэг ААН-ийн эрх ашгийг хамгаална гэхээсээ илүүтэйгээр бизнесийн орчны нийтлэг эрх ашгийг хамгаалах үүднээсээ өнөөдөр бид бүхэн бизнесийн орчны судалгаа, хүнд суртлын индекс гээд олон төрлийн судалгаанууд явагдаж байгаа. Судалгааны үр дүнгээс хамаараад асуудлуудыг нь холбогдох төрийн байгууллагуудад нь зөвлөмж маягаар үйл ажиллагааг сайжруул гэсэн энэ чиглэлээрээ ингэж оролцож байгаа. Мөн бизнесийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр энэ явагдаж байгаа хууль санаачлагдсан хуулиудын хэлэлцүүлэг дээр оролцоог нь хангаж нэгдсэн дуу хоолой маягаар, өмгөөллийн, бодлогын өмгөөллийн чиглэлийн үйл ажиллагаагаар л ингэж хамгаалж явж байгаа. Одоогийн байгаа энэ хууль, эрх зүйнхээ хүрээнд бол.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүн нэмж хариулъя.

Д.Энхтүвшин: Уянга гишүүний асуултад хариулъя. 50 дээр нэмэх гэдэг санаачилга болохоор ер нь энэ яг тавиуд тавиулаа нийлээд л шууд хаалттай байж байгаад нэг газар хуралдаад л байгуулчихна гэсэн үг биш. Энэ салбарын танхим байгуулж, санаачилга гаргахын тулд эхлээд ядаж 50 ААН-үүд нийлээд бид нэг ийм санаачилга байна. Энэ салбар дээр танхимын Удирдах зөвлөлөөс баталсан яг энэ ангилалд ийм салбарын танхим дээр бид энэ танхим байгуулах ийм саналтай байна, тэгээд энийг хэрэгжүүлээч энэ дээр ААН-үүдийг оролцох бололцоог боломжийг хангаач гэдэг байдлаар асуудалд хандах юм. Тэгэхээр энэ нь өөрөө танхимын зүгээс яг энэ санал санаачилгыг нь хэрэгжүүлэх үүднээс анхны тэр танхимын хурлыг хуралдуулахын тулд илүү тэр төлөөлөх чадварыг нь хангахын тулд бусад жишээлбэл ААН-үүд тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдэд мэдээлэл хүргэх энэ чиглэлээр ажиллах юм. Зарим салбарын хувьд, нэмээд.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: 1 минут сунгая.

Д.Энхтүвшин: Зарим салбарын хувьд яг салбарын ААН-үүд нь 50 хүрэхгүй ААН-үүд байгаа. Тухайлбал банкны салбар ч гэдэг юм уу, харилцаа холбооны зарим салбарууд ч гэдэг юм уу гэх гэх мэтчилэн энэ салбаруудын хувьд яг хэрвээ 50-д хүрэхгүй салбарууд байдаг учраас энэ салбарууд хүрэхгүй бол олонхын төлөөлөл нь хуралдаад энэ асуудлаа бид энэ салбар дундаа ийм холбоо байгуулъя эсвэл байгуулчихсан тэр холбоонууд нь энэ хуулийн дагуу салбар танхимын чиг үүргийг бид авчихъя. Та нар битгий танхимын зүгээс давхар энэ юу салбарын танхим байгуулахгүй гэдэг асуудлаар ярилцаад, тэгээд үйл ажиллагаануудаа явах бололцоотой байна. Тэгэхээр яах вэ 50 гэдэг тоо нь хэдийгээр тухайн үед байсан ч

гэсэн ер нь бол санаачилга гаргах ААН-үүдийн тоо гэсэн байдлаар ойлгож болно. Одоо үйл ажиллагааны хувьд хуулиараа энэ хувийн хэвшлийн нийтлэг эрх ашгийг илэрхийлж болох юм шүү гэдэг асуулт асуулаа. Тэгэхлээр яг үнэндээ бодит байдал өнөөдрийн тоо харахад бид үнэхээр чадахгүй байгаа.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: 50 ААН дээр нэг их ажиллаагүй л сонсогдоод байна, хариулт нь яг тэгж л уншигдлаа. Тэгээд энэ дээр цаашдаа хэрвээ хэлэлцэх эсэх нь дэмжигдээд явбал яг бодитой ийм суурь тоонууд хэрвээ 50 гэж бичиж байгаа бол яагаад 50 гэдгээ бүрэн гүйцэд хариулах хэрэгтэй. Яаж ч бодсон 2002 оны тоо, тухайн үеийн хүн амын тоо, ААН-ийн тоо нь шал өөр байхад чинь 50-аар нь үргэлжлүүлэн орж ирэхийг ойлгохгүй байна.

Яг хийсэн ажлуудаа ярь гэхээр ерөөсөө ярихгүй байна. Яг хийсэн ажлуудаа тодорхой ярь гээд байхад ерөнхий хуулийг нь эхний 2 өгүүлбэрээс нь ойлгогдож байгаа юмыг яриад байхаа болих хэрэгтэй байна. Хуучнаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайдаар ажиллаж байсан дотор нь газрын дарга гээд дотор нь ч гэсэндээ төрийн албан хаагчийн хувиар ажиллаж байсан хүний хувьд танхимаас хэзээ уул уурхайн салбарынхны төлөөлөл болоод янз бүрийн албан бичиг, хүсэлтүүд саналууд ирж байсан юм бэ? 2021 оноос хойш Ашигт малтмалын тухай хуулийг сайжруулъя гээд ажиллуулж байхад хэдэн удаа танайхаас санал нь ирсэн юм бэ, орж ирж байгаагүй. Яг тэрийгээ нэг тодорхой хариулах гээд үз, үгүй бол бичгээр авъя.

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Уянга гишүүний хэлсэн санаатай санал нэг байна. Танхимын хувьд сайжруулах зүйл их байгаа. Өнөөдөр төгс төгөлдөр болчихсон байсан бол бид хувийн хэвшлийн орон зай ийм байхгүй байсан. Тэгээд энэ хууль дээр яг энэ тухайн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн салбарын олонхыг хамруулж чаддаг энэ холбоодыг жишээлбэл энэ танхим гэдэг энэ үндэсний танхим бий болох энэ бүтэцтэй зэрэгцүүлж танхим байгуулахгүйгээр шууд хамтарч ажиллахаар ингээд заалтууд орчихсон байгаа. Тэгэхээр энэ танхим дээр бүх ААН-үүд нь танхим дээрээ орчихдог учраас төлөөлөх чадвар салбар салбарын бодлого гаргах бололцоо байхгүй. Тэгэхээр танхимын дэргэд энэ салбарын бодлогын зөвлөлүүд гээд ажилладаг энэ бүтцүүдээрээ яахыг хичээдэг, зарим нь хангалтгүй. Тэгэхээр жишээлбэл бид уул уурхайн ассоциаци гэдэг юм уу, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Хүнсчдийн холбоо, Барилга ассоциаци гэх мэтчилнээр гээд энэ олонхын төлөөлөл авчихсан энэ холбоодтой бас яг энэ хууль гарсны дараа хамтарч ажиллах талаар ярилцсан байгаа. Тэгэхээр энэ хууль дээр энэнтэй холбоотой зүйл, заалт оруулчихсан байгаа учраас.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя.

М.Мандхай: Танхимын хуулийг юу гэж харж байгаа вэ гэхлээр ААН-үүдийн энэ нийтлэг эрх ашиг, сонирхлыг төлөөлөх, тэгээд бизнесийн энэ орон зайн орчныг чадавхжуулах ийм дэмжиж ажилладаг аймаг болон нийслэл энэ үндэсний хэмжээний ийм байгууллагын энэ эрх зүйн орчныг сайжруулах гэж байгаа хууль байна гэж би хувьдаа дүгнэж байгаа. Үеийн үед танхимын Ерөнхийлөгч болон удирдах зөвлөл үргэлж л улс төрийн төлөөлөл, улс төрийн нөлөө орж ирсэн. Тэгээд

шинэчилсэн найруулга дээр үр дагаврын нөлөөн дээрээ ч гэсэн ер нь энэ улс төрийн нөлөөг бууруулах тал дээр ер нь улс төрийн нөлөө байдаг, энэ нь өөрөө сул тал гэдгийгээ өөрсдөө тодорхойлоод гаргаад өгчихсөн байгаа. Тэгэхээр энэ танхимын хараат бус байдлыг улс төрийн намуудаас ангид байх, улс төрийн нөлөөтэй гишүүнийг Ерөнхийлөгчөөр эсвэл Удирдах зөвлөлөөр томилдоггүй байх яг ямар энэ хуульд шинэчлэл хийгдсэн юм бэ гэдгийг асуумаар байна.

Яагаад гэхлээр ялангуяа улс төрийн энэ нөлөө бүхий, дээрээс нь топ 100 шалгаруулж байгаа компаниуд нь өөрсдөө дандаа хараат нэг групп компанийн охин компаниуд, эсвэл уул уурхай, банк санхүү, шатахуун бензиний ийм л 3 салбарын компани шалгардаг топ 20-д тийм л компаниуд байгаа. Тэгэхээр эдгээр компаниудын нөлөөлөл үүсэхгүй байх, үүсэхгүй, нөлөөлөхгүй нөлөөлөлд автахгүй байх яг ямар энэ хуульд шинэчлэл хийгдсэн юм бэ? Хэрэв үйл ажиллагаандаа улс төрийн нөлөөлөлд автах ийм нөхцөл байдал үүсвэл эсвэл энэ тохиолдолд энэ хууль дээр яг ямар хариуцлагын механизмыг тусгаж байгаа юм бэ гэдэг асуултыг асуучаад тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Хассуурийн Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Мандхай гишүүн яг л энэ гол юуг нь олоод харчихсан байна. Мандхай гишүүнд талархал илэрхийлье. Мөн Лхагважав ерөнхийлөгчид талархал илэрхийлмээр байгаа юм. Энэ хууль батлагдвал шинээр тэр дарга цэргээ сонгох асуудал үүснэ. Тэгээд тэн дээр шалгуурын заалт орсон байгаа, тэр нь нам бус байх ёстой гэдэг. Өнөөдөр яах вэ бодит байдал манай Лхагважав Ерөнхийлөгч МАН-ын бага хурлын гишүүн, дээрээс нь МАН-ын даргад өрсөлдөж байсан ийм хүн байгаа. Хэрэв зээ дахиад сунгаанд оръё гэвэл намаасаа татгалзах асуудал үүснэ гэсэн үг. Ерөөсөө л бидний энэ гол энэ хуулийг эр зориг гаргаад манай энэ танхимын дарга болон юунууд дэмжээд явж байгаа асуудал бид энэ бизнесээ цэвэрлэе, энэ хийрхсэн улс төрчөөсөө салъя.

Урьд өмнө яагаад энэ тэнхимийн хууль явдаггүй байсан бэ гэхээр дандаа л ҮБХ-ны гишүүн эсвэл Бага хурлын гишүүн, Иргэний Зориг ногоон намын дарга гээд дандаа улс төрийн л харьяалалтай хамааралтай л хүмүүс байсан. Тийм учраас тэр хуулиа өөрчлөх сонирхолгүй байдаг байсан. Зөвхөн дүрмээрээ дарга цэргээ сонгодог, өөрийгөө нэг сонгочихвол дараа нь нөгөө хугацаагаа сунгах хүсэлтээ явуулдаг. Ерөөсөө л улс төрчдийг бэлтгэх ийм дамжаа шат дамжаа болж л ирсэн. Аль эсвэл ялсан намын халаасны ТББ болж явж байсан. Энийг л өнөөдөр засъя гэж байгаа юм. Тэгээд би Мандхай гишүүнийг болж өгвөл яг энэ ажлын хэсэгт нь ороод ажиллаасай гэж хүсэж байна гэдэг л үг хэлмээр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Тэгэхээр танхим өөрөө аль нэгэн улс төрийн нөлөөнд автахгүй, хараат бус үйл ажиллагаагаа явуулдаг, яг ААН-үүдийнхээ бизнес эрхлэгчдийн энэ орон зайг нэмэгдүүлэх, сайжруулахын төлөө ажиллах байгууллага байгаасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байгаа. Энэ хуулийн шинэчлэл дээр нэг ийм зүйл орж ирсэн байгаа. Салбарын танхим байгуулах 50-аас доошгүй энэ босгыг тавьж өгсөн байгаа юм. Энэ өөрөө салбарыг төлөөлж чадах уу гэдэг нэг асуулт байгаа юм. Тэгээд 50 гэдэг тоог яг ямар үндэслэлээр гаргаж ирсэн бэ? Энэ өнөөдрийг хүртэл энэ төлөөлөл хангагдаж чадаж байна уу? Тэгээд би түрүүн хэлсэн топ 100 шалгаруулалт нь компаниуд өрсөлдөөд, тодорхой түвшинд энд нь орчих юм сан гэдэг ийм

эрмэлзлийн төлөө шалгаруулаад шагнагдчих юм сан, өөрийгөө компаниа таниулчих юм сан гэдэг зарчмаар ингэж өрсөлдөж, танхимд ч гишүүн болоод явж байгаа. Тэгэхлээр энэ түрүүн хэлсэн шатахуун бензин, уул уурхай.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах юм бэ? Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Энэ 50 гэдэг болохоор бид зарим нэг бизнесийн салбар тийм олон оролцогчтой цөөхөн оролцогчтой салбарууд байгаад байдаг. Тийм учраас 50 гэдэг тоо тавьсан юм. Тэрнээс биш 50-аас дээш хэд ч байж болно. Жишээлбэл шинэ юу гэдэг юм хоршооны тэнхим хүртэл байгуулж болохоор байгаа байхгүй юу. Хоршооны тэнхим гээд л 50-аас дээш хоршоо нэгдчихвэл тэнхимээ, салбар тэнхимээ байгуулаад л, тэгээд тэр бидний нөгөө хөгжүүлэх гээд оролдоод байсан тэр хоршооны бодлогоо аваад явчих боломжтой болно гэсэн үг. Тийм учраас энийг чөлөөтэй тавьсан юм, тэдэн салбарын тэнхим байна гэдэг хатуу тоо заагаагүй. Тэгэхгүй бол одоо бид чинь цэвэр ерөөсөө л уул уурхай, тэр нефть, банк гэсэн 3 салбар дотор л эргэлдээд байгаа байхгүй юу. Тийм учраас энэ ЖДҮ гэхээр бүгдийг нь аваачаад тэр ЖДҮ рүү хийчхээд байгаа юм. Гэтэл ЖДҮ гэдэг маань дотроо аягүй олон салбар бизнесийн үйл ажиллагаа байгаа байхгүй юу. Тэгэхээрээ нөгөө яг тэр бизнес үйл ажиллагааг нь дэмжих бодлого нь гарч чаддаггүй, цэвэр яг ЖДҮ гэхээрээ татварын, аль эсвэл татаасны гэдэг л 2.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгээс тодруулъя, 4 номер.

Л.Загдаа: Мандхай гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн гишүүн Загдаа. Хуулийн төслийн 9 дүгээр зүйл дээр тэр нөгөө Ерөнхийлөгч улс төрөөс хараат бус байх асуудлыг зохицуулж өгсөн байгаа. Энэ дээр улс төрийн намын харьяалалтай биш, тэгээд аж ахуйн үйл ажиллагаа 10-аас доошгүй жил эрхэлсэн, Удирдах зөвлөлийн гишүүн байна гэж байгаа. Өөрөөр хэлбэл тухайн Ерөнхийлөгчид нэр дэвших хүн бол аймаг, нийслэлийн салбарын танхимын удирдах зөвлөлөөр дамжаад тэр танхимынхаа дарга болоод, тэгээд үндэсний танхимд орж ирж байж дараа нь Ерөнхийлөгч дэвших тийм боломжтой болж байгаа.

Дараагийн асуулт нь болохоор энэ 50 гэдэг тоо 1995 онд батлагдсан хуулийн тоогоо ер нь ингээд аваад яваад байгаа юм. Шаардлагатай гэвэл нөгөө ажлын хэсэг байгуулагдаад явбал энэ тоог дээшээ, доошоо бууруулах тийм боломжтой гэж харж байгаа. Гол нь орон нутагт яг 50 ААН нийлээд аймгийн танхим байгуулсан тохиолдол өнөөдөр байхгүй болохоор яг энийг хэт өсгөж болохгүй. Харин эсрэгээрээ салбарын танхим.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Чинбатын Ундрам гишүүн алга байна. Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалан: Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Монголын бизнесүүд энэ эрх баригч МАН-ын хулгай, ковид хавсарсан давхар цохилтод өртөөд одоо ер нь сэхээнд байгаа гэж хэлж болно. Бизнесийн орчин өдөр ирэх тусам доройтож байгаа. Хувийн хэвшлийн орон зай өдөр ирэх тусам хумигдаж байгаа. Тэгээд бид ийм эгзэгтэй цаг хугацаан дээр бизнес эрхлэгчдийг төлөөлөх гол байгууллага болох МҮХАҮТ-ын тухай хуулийг хэлэлцэж байна. Тэгэхээр эхний ээлжид танхимын төлөөллөөс хэд хэдэн асуулт байна.

2025 онд улсын хэмжээнд 263 мянган ААН бүртгэлтэй байгаагаас 117 мянган ААН идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа гэсэн тоо баримт Үндэсний статистикийн хороо /УСХ/ өгч байна. Тэгвэл танхимд гишүүнчлэлтэй 6768 ААН байгаа талаар сая Байнгын хороон дээр тодруулсан. Тэгэхээр энэ 6768 гишүүн чинь нийт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн ердөө 5, 6 хувь байгаад байгаа гэсэн үг. Тэгэхээр танхим ер нь энэ гишүүнчлэлийнхээ бодлого дээр ямар бодлого барьдаг юм бэ, гишүүнчлэлээ нэмэгдүүлэх чиглэлээр ямар хөтөлбөр хэрэгжүүлдэг юм бэ? Ер нь энэ гишүүнчлэлийнхээ тоонд хангалуун байдаг уу? Би бас ийм олон улсын зарим харьцуулалтуудыг харахыг зорилго л доо. Тэгэхээр ийм сайн дураараа эвлэлдэн нэгдэх танхимтай дийлэнх улс орнуудад нэг ядаж нэг минимум 10 хувийн, компаниудын 10 хувийг гишүүнчлэлдээ хамруулсан байдаг юм байна. Тэгэхээр та нарт яг энэ тал дээр тодорхой тоо баримт судалгаанууд байна уу? Ер нь энэ гишүүнчлэлээ нэмэгдүүлэх чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулж байна вэ? МҮХАҮТ бизнес эрхлэгчдээ зүй ёсоор төлөөлж чадаж байна гэж үзэж байна уу гэдэг асуудал.

Улсын Их Хурлын талаас харвал танхимыг бизнес эрхлэгчдийн дуу хоолой гэж хардаг учраас хуулийн төслүүдийг бол танхим дээр хийгээд байгаа шүү дээ. Тэгээд бид ч УИХ дахь АН-ын бүлэг ч гэсэндээ нэлээн олон хэлэлцүүлгүүдийг хийсэн. Аль болох ажил хэрэгч саналуудыг төсөлдөө тусгахыг зорьдог. Тэгэхээр энэ бодлогын нөлөөллийн чиглэлээр танайх ер нь энэ сэтгэл хангалуун бас байна уу? Ер нь танхим дээр явагдаж байгаа хэлэлцүүлэг, танхимын өгч байгаа энэ хуулийн төслүүд дээрх саналууд хэр биеллээ олдог вэ гэдэг нэг асуулт.

Эдийн засгийн байнгын хороон дээр уг хуулийн төслийг дэмжээгүй. Дэмжихгүй байх хэд хэдэн шалтгаан байсан. 1 дүгээрт 1995 онд батлагдсан хуультай харьцуулахад яг ямар давуу тал байгаа вэ гэдэг нь ерөөсөө ойлгомжгүй байгаад байгаа юм. Ер нь энэ 95 оны хуулийг шинэчлэх бодит шаардлага байгаа юм уу гэдэг асуудал. Аль болох төрөөс хараат бус байж, гишүүдийнхээ, гишүүн байгууллагуудынхаа эрх ашгийг хамгаална энэ тэр гэсэн тийм үзэл баримтлал яриад байгаа боловч яг энэ нэг бодитой ялгаа бол харагдахгүй байна гэсэн үг. Ер нь бид эрх зүйн тогтвортой байдлыг их чухалчлах ёстой шүү дээ. Тэгэхээр өнгөрсөн 20 жилийн хугацаанд бий болсон энэ танхим дээр байгаа бүтэц, бүрэлдэхүүн, энэ бүх байгууллагын соёл институцийн төлөвшлийг одоо энэ хуулиар ахиад эвдээд хаячих вий дээ гэсэн болгоомжлол зүй ёсоор байгаа.

Энэ болгоомжлолын нэг хэсэг нь саяын гишүүдийн яриад байгаа салбар танхимын асуудал. Энэ салбар танхим гэдэг нь энэ шинээр өргөн баригдаж байгаа хуулийн төслийн нэг гол ялгаа гэж харагдаж байгаа. Тэгэхээр салбар болгонд одоо үйл ажиллагаа явуулж байгаа маш бэхэжчихсэн ийм сайн холбоод бий. Эдгээр холбоодын асуудал яах юм бэ, эсвэл ингээд энэ танхимынхаа бүтцийг бүүр эвдчих, 50 компанийг нийлээд л янз бүрийн салбар танхимууд бий болгоод л бүүр нэг ийм үүрээ эвдсэн шоргоолж шиг болчих вий ч гэсэн болгоомжлол байгаад байгаа. Тэгэхээр яг энэ шинэчилсэн найруулга оруулж ирж байгаагийн яг бодит зорилго нь юу вэ? Яг ямар ийм тодорхой ялгаа байна вэ гэдгийг хууль санаачлагчаас асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: 95 оны хуулиар танхимууд байгуулагдах ёстой байгаа. Орон нутгийн зарчмаар танхим байгуулагдахаар заасан байгаа. Тэгэхдээ бодит байдал дээр бол яг Улаанбаатар хотын танхимаас 2015 онд Улаанбаатар хотын танхим

байгуулагдсан, тэрнээс өөрөөр орон нутгийн танхимууд байгуулагдаагүй. Энэ нь өөрөө байгуулагдахгүй байсан шалтгаан нь болохоор бие даасан жишээлбэл санхүүтэй үйл ажиллагаа явуулах бололцоо байхгүй, эдийн засгийн хувьд ч гэсэн тийм татвар хураамжууд нь хангалттай үйл ажиллагаа явуулах боломж байхгүй учраас танхимын нэг хэсэг ажилтан танхимын бүтцэд орж, орон нутгийн танхимын үйл ажиллагаанууд явдаг байсан. Тэгээд энэ нь өөрөө танхимын нөгөө төлөөлөх чадварыг алдагдуулж байгаа. Өөрөөр хэлбэл аймаг, нийслэлүүд дээрээ тэндээ очиж ААН-үүд нь гишүүнчлэлээ илүү тэндээ үүсгээд, тэгээд Үндэсний танхим дээрээ илүү бодлогын асуудлууд ярих ийм бололцоо орон зайнууд гарна гэж хуулийн хувьд тэгж харагдсан ч гэсэн ААН-үүд нь нөгөө орон нутгийн салбарууд байхгүй болохоор бүгдээрээ Үндэсний танхим дээр очоод орчихсон.

Тэгэхээр тэнд цөөн гол үйл ажиллагаа явуулдаг том компаниудын төлөөлөл илүү ороод, жижиг, дунд ч юм уу ААН-үүдийн хувьд яг энэ бололцоо боломж нь хязгаарлагдмал учраас энд төлөөлөх чадвар энэ хэмжээгээр унасан байгаа. Тэгэхээр энэ хуулийн өөрчлөх болсон зайлшгүй шаардлагуудын нэг нь эдийн засгийн салбаруудаар, яагаад вэ гэхээр салбаруудаар энэ танхимыг өргөжүүлэх ёстой юм байна гээд. Нөгөө талаас энэ салбар даар сая тэр таны тэр болгоомжлол үнэхээр яг байх ёстой болгоомжлол байгаа. Одоо яг олонхын төлөөллөө авчихсан яг энэ холбоодыг бужигнуулж болохгүй. Сая Мэргэжлийн нэгдсэн холбоодын тухай хууль дээр ч гэсэн энэ нь өөрөө тодорхой хэмжээгээр ийм үл ойлголцол бий болох, зарим нэг хэмжээгээр амбиц жишээлбэл бий болгох, тэр олон жил болчихсон зарим нь 100 жил болчихсон энэ холбоод байна, гишүүд нь зүгээр үйл ажиллагаа явуулдаг энийг ингээд хэвийн байдлыг нь алдагдуулах тийм эрсдэлүүд харагдсан.

Тэгэхээр танхимын хувьд ч гэсэн бас яг энэ асуудалд оруулахгүйн тулд хуулийн төсөл дээр заалт оруулж байсан байгаа. Тухайн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн ийм түүхэн энэ байгууллагуудыг салбар холбоодыг тэр салбарт нь зэрэгцүүлж танхим байгуулахгүйгээр, өөрөөр хэлбэл дахиж тэр байгаль юу гэдэг юм түүхэн жамаараа бий болчихсон энэ бүтцийг эвдэхгүй байхаар ийм хуулийн төсөлд заалт оруулсан байгаа. Тэгээд энэтэй холбогдуулж өмнө нь энэ хуулийн төсөл хэлэлцүүлэх явцад 20 орчим яг энэ олонхын төлөөлөл авчихсан ТББ, энэ мэргэжлийн холбоодтой уулзалтууд хийсэн. Тэгээд энэ байгууллагуудаас энэ танхимын хуулийн үзэл баримтлалыг танилцуулж, уулзалт ярилцлагад хийхэд энэ байгууллагуудын хувьд нааштайгаар хүлээж авч байгаа. Тэгэхээр энэ холбоод нь өөрөө танхимыг бүрдүүлэх хэсэг нь болохоор ААН-үүдийн.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Салбар тэнхимийг заавал байгуул гэсэн юм бол биш, байгуулж болно гэж орсон байгаа. Салбар тэнхим байгуулж байгаа асуудлууд юу байна гэхээр бид 367 зөвшөөрөл байгаа. 367 зөвшөөрлийг тодорхой хэмжээг нь ТББ болон хувийн хэвшил рүү шилжүүлэх асуудлыг хуулиар нээгээд өгчихсөн байгаа. Тэгэхээр салбар тэнхим байж эсвэл салбар тэнхим нь байх юм уу, эсвэл тэр чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагууд зөвшөөрөл олгох боломж боломжууд бий болно гэсэн үг. Нэг ёсондоо тодорхой хэмжээний төрийн үйл ажиллагааг төрийн өмнөөс гүйцэтгэх боломжтой болно гэсэн үг. 95 оноос хойш өнөөдрийг хүртэл нэг ч дарга улс төрийн намаас хамааралгүй нэг ч хүн байгаагүй шүү. Энэ дотроо намын дарга ч байна, ҮБХ-ны дарга ч байна. Яагаад энэ хувийн хэвшлүүд маань идэвхтэй энэ гишүүнчлэлтэй байгаагүй гэдэг шалтгааны нэг нь мөн шүү дээ. Тухайн үеийн дарга нь АН-ын дарга байвал нөгөө зарим нэг хүмүүс нь

болгоомжлоод ордоггүй. Ардын намын дарга байвал бас болгоомжлоод ордоггүй.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Өнөөдрийн байдлаар манай ЗГ-ын бодлогыг манай намын гишүүн тэнхимийг толгойлоод явж байвал бодлого сөрсөн юм ярихгүй. Тэрийг л засах гэж байгаа юм. Улс төрөөс хараат бус байг. Энэ ажлын хэсэг нь болж өгвөл цөөнхийн гишүүн ахлаад яваг. Ингэж байж өнөөдөр бид бизнесийн эрх чөлөөгөөр 81-д явж байна шүү дээ эдийн засгийн бизнес эрх чөлөөгөөр. Тэгээд яагаад жишээлбэл яг ижилхэн гараатай байсан Казакстан, Эстони, Латви, Литва эхний 30 руу яваад орчихсон байна. Тэгэхээр чинь бид энэ хувийн хэвшилдээ тэр дуу хоолойг нь өгдөггүй, тэр бодлогод оролцох боломжийг нь олгодоггүй тийм үү. Тэр учраас бид улс төрөөс, төрөөс, ЗГ-аас энэ хамаарлыг байхгүй болгож байж л бид хараат бус дуу хоолойтой болж байж энэ тэнхимээс гарах хуулиуд зөв чиг рүүгээ явахад чиглэх байхгүй юу. Энэ тэнхимээс, энэ ордноос гарч байгаа бодлогууд зөв тал руугаа явж эхэлнэ гэсэн үг. Бодитой шүүмжлэл бий болж байж ЗГ-ын бодлого зөв болж эхэлнэ шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын микрофон.

М.Сарандаваа: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Бизнесийн орчны судалгаа сүүлийн 10 жилд тогтмол буурсан, муу үзүүлэлттэй байгаа, 1 дүгээрт тогтмол буурч байгаа. Энэ нь тодорхой 4, 5 хууль, эрх зүйн орчин буюу зохицуулалтуудтай холбоотой гэж бизнес эрхлэгчид өөрсдөө дүгнэсэн байдаг. Тэр хууль, эрх зүйн орчнуудыг сайжруулах чиглэлээр танхим өнгөрсөн хугацаанд 40 гаруй хууль, ажлын хэсэг, хууль, ажлын хэсгүүдэд орж, төлөөллөөрөө дуу хоолойгоо хүргэж ажиллаж байгаа. Гэвч тэр саналууд тусдаггүй, үр дүн байхгүй. Тэгэхлээр энэ хуулийн зохицуулалтаар дамжуулаад, танхим нэгэнт төлөөллийн, хувийн хэвшлийн төлөөллийн төв байгууллага юм бол энэ хувийн хэвшлийг төлөөлөх мандатаа нэг баталгаажуулъя гэсэн ийм санал санаачилга 1 дүгээрт явж байгаа.

2 дугаарт гишүүнчлэлээрээ аваад үзвэл нийтийн эрх зүйтэй 119 улсад албан журмын гишүүнчлэл байна. Хувийн эрх зүйн 77 улсад сайн дурын гишүүнчлэлтэй байгаа. Ази болон төв Азийг аваад үзвэл хосолсон байдлаар явж байгаа. Танхимын санал бол хосолсон байдлаар явах цаг нь болчихсон гэж институцийн хувьд үзэж байгаа. Энэ нь ч өөрөө.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Хэрэв жишээлбэл аймгуудад танхим байгуулагдахгүй байгаа бол тэр 95 оны хуульд чинь аймаг болон хотод хот дундын танхим байж болно гэчихсэн байгаа шүү дээ. Тэгэхээр тэр санал санаачилгыг ингээд бас нэг дэмжээд, зохион байгуулалтуудыг нь хийгээд явах бүрэн боломжтой гэж харж байна.

Танхимын Ерөнхийлөгч нь намын гишүүн бус байна гэдэг шаардлагыг тэр тухайн сонгуулийнхаа дүрэм журамд ч гэсэндээ тусгаад явах боломжтой. Заавал энийг хуульчлаад байх ер нь шаардлагагүй гэж би хараад байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь бид аливаа зүйлийг бүүр хэтэрхий их хуульчилж, хэтэрхий их юу гэдэг юм шахах тутам энэ нөгөө ардчиллын чинь зарчим алдагдана л гэж хараад байгаа юм.

Төгсгөлд нь бизнес эрхлэгчдэдээ уриалах байна. Энэ танхимынхаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцооч, тэгж байж дуу хоолойгоо хүргээч. Эс бөгөөс энэ бүх зүйлийг ингээд нөгөө хуульчлаад, бүх зүйлийг өмнөөс чинь шийдээд байна шүү дээ л гэж хэлэх байна.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Банзрагчийн Түвшин гишүүн алга байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

13.32 цаг

Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг 14 цаг хүртэл завсарлуулж байна.

*2026 оны 4 дүгээр сарын 23, Пүрэв гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 06 минут.*

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: ХАҮТ-ын тухай хуулийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлье. Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. 2 гишүүн байна уу? 5 гишүүн, 5 гишүүн нэрээ өгсөн байна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн, Эрдэнэболд гишүүн алга байна. Гомбын Ганбаатар гишүүн, Ганбаатар гишүүн алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, алга байна. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн, үг аваагүй байна. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн, алга байна. Үг хэлэх гишүүд байхгүй тул хаалаа.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Өглөөний хуралдаан дээр үдээс хойш 14 цагаас санал хураалт гэж зарласан байгаа. Гишүүдийг танхимд урьж байна. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийн санал хураалтыг явуулна. Гишүүдийг танхимд урьж байна.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 14 цаг 10 минутаас хуралдааныг даргалав.

С.Бямбацогт: Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр, нам, эвслийн бүлэгт харьяалагддаг гишүүн тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. 3 гишүүн үг хэлэхээр нэрээ ирүүлсэн байна. Үүний дараа санал хураалт явагдана. Гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Энэ чухал хууль хэлэлцэж байгаа учраас гишүүд санал хураалтдаа бүрэн оролцоно уу. 72 зарчмын зөрүүтэй санал байгаа. Лутаагийн

Энхнасан гишүүн үгээ хэлье. Алга, байна. Юу юм байна шүү яг тухайн санал дээрээ та, яг энэ санал дээр зарчмын зөрүүтэй энэ санал дээр би дэмжиж байна, эсхүл дэмжихгүй байна гэж үгээ хэлэх юм байна. Тийм 4 дүгээр санал юм байна тийм ээ. Тийм болохоор шууд санал хураалт явах нь.

Гишүүд танхимдаа яаралтай орж ирнэ үү. Одоогийн байдлаар өнөөдөр чуулганы хуралдаанаар ирцэд 126 гишүүн оролцохоос 91 гишүүн бүртгэлтэй байгаа, одоо танхимд 38 гишүүн байна. Гишүүдийг санал хураалтад танхимдаа орж ирэхийг урьж байна. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Тувааны урилгаар Төв аймгийн Аргалант сумын ЕБС-ийн 8А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийнхээ сурлагад нь өндөр амжилт, ажил, амьдралд нь бас эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе.

Гишүүд санал хураалтдаа бэлдье. Ирцийн санал хураалт явуулна. 35 гишүүн санал хураалтад бэлэн болсон байна, 56 гишүүн бэлэн болоогүй байна. Гишүүд хурууны хээгээ уншуулж, санал хураалтдаа бэлдье. Удахгүй ирцийн санал хураалт явуулна. Санал хураалтдаа бэлдье. 45 гишүүн санал хураалтад бэлэн болсон байна, танхимд 51 гишүүн байна, бэлдээгүй гишүүд бэлдэнэ үү. Ирцийн санал хураалт. Санал хураалт явуулъя. Санал хураалтад 91 гишүүн оролцохоос 47 гишүүн ирцдээ орсон байна. Ирцдээ ороогүй 44 гишүүнийг чуулганы танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Одоохондоо нэр уншаад яах вэ. Энд дэлгэц дээр ирцдээ ороогүй гишүүдийн нэрс гарч байна. Ирцдээ ороогүй гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урья. Их Хурлын гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдээ санал хураалтад оролцохоор дамжуулж хэлээрэй. Санал хураалтууд эхэлье.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Нэг.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээг үзүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар, Энхнасан, Баясгалан, Болормаа, Рэгдэл, Отгонбаяр, Сарнай, Эрдэнэбат, цаашдаа ажлын хэсэг гэх. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос 51 гишүүн буюу 55,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос 54 гишүүн буюу 58,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “эрхтэн, эд, эс” гэсний өмнөх “хүний” гэснийг хасаж, 4.1.2 дахь заалтын “бөгөөд гэрлэгчид, төрлийн хүн, садангийн хүн, хүргэн, бэр гэсэн дарааллаар сонгогдсон хүнийг” гэснийг “, хүргэн, бэрийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос 56 гишүүн буюу 60,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Зочин танилцуулъя. Нийслэлийн ЕБС-ийн 111

дүгээр сургуулийн 9В ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүүхэд багачууд сурагч та бүхнийхээ сурлагад нь өндөр амжилтыг, эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе. Бүгдээрээ онц сурцгаагаарай.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.3.“амьгүй донор” гэж тархины үйл ажиллагаа бүрэн, эргэшгүй алдагдсан, тархины үхэл тодорхойлох мэргэшсэн багаар тархины үхэл нь тогтоогдсоны дараа үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгахаар авч болох донорыг;” Санал гаргасан ажлын хэсэг. Энхнасан гишүүн үг хэлэх үү та? Лутаагийн Энхнасан гишүүн саналаа хэлье. Индрээс хэлэх юм байна, 2 дугаар индэр.

Л.Энхнасан: Эрхэм гишүүдийн өдрийн мэндийг эрье. Олон нийтийн дунд хэл ам, үл ойлголцол дагуулж ирсэн энэ Донорын тухай хуулийг шинэчлэх асуудлыг бол би бол анхнаасаа дэмжиж ирсэн. Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга хийж байх, даргыг хийж байх ч хувьд энэ донорын байгууллагуудын уялдаа холбоо, хариуцлагыг тодорхой болгох, амьгүй донорын тухай ойлголтыг зөв түгээх, олон нийтэд донорын тухай ойлгуулах асуудалд илүү онцгой анхаарч ажилласан. Өнөөдрийг хүртэл бодит байдал дээр бол донорын тухай буруу ойлголтоос болоод олон хүн амь насаа алдаж, олдсон ч үйл явц нь удаан, уялдаа сул байсан.

Харин энэ хуулийг хууль шинэчлэгдсэнээр донорын бүртгэлийг ИМонголиагаар дамжуулан ил тод, хялбар болж, донорын зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлж, эд, эсийн эмчилгээ, био банкны эрх зүйн орчныг бүрдүүлж, байгууллагуудын уялдаа, хариуцлагын тогтолцоо бий болж байна гэж ойлгож байгаа. Өөрөөр хэлбэл донорын тухай ойлголтыг зөв болгоод зогсохгүй өмнө нь бид донорын тухай ярьдаг байсан бол одоо амь аврах энэ тогтолцоо байгуулж байна гэж ойлгож байна. Иймд энэ хуулийн төслийг дэмжиж байгаагаа үүгээр илэрхийлж байна. Гишүүдийг бас дэмжинэ гэдэгт итгэж байна, баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. 4 дэх саналын томъёоллыг сая уншиж танилцуулсан. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 62 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “болон” гэснийг “эсхүл” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтын “эсийг шилжүүлэн суулгах” гэсний өмнө “үүдэл” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 53 гишүүн буюу 57 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.7.“реципиент эмнэлэг” гэж бүтцэд нь төрөлжсөн тасаг, мэргэжлийн багтай Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагыг;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал

хураалт. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 61,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.8.“донор эмнэлэг” гэж амьгүй донорыг илрүүлэх, оношлох, эрхтэн хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагыг;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 61,3 саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.11.“био банк” гэж оношилгоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэх, хяналт хийх зорилгоор авсан эд, эсийг хадгалах тусгай зориулалтын санг;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 54 гишүүн буюу 58,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 4.1.17 дахь заалтыг хасах:

“4.1.12.“эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ” гэж эмнэлгийн нөхцөлд донорыг илрүүлэх, эрхтэн, эд, эсийг авах, шинжлэх, хадгалах, тээвэрлэх, хуваарилах, шилжүүлэн суулгах болон мэс заслын дараах эмчилгээ, хяналт хийх эмнэлгийн тусламж, үйлчилгээг.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 56 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.17 дахь заалт нэмэх:

“4.1.17.“сорьц” гэж оношилгоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэх, хяналт хийх зорилгоор хүнээс авсан цус, эс, эд, эрхтний хэсгийг;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 56 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.18 дахь заалт нэмэх:

“4.1.18.“хүйн эд” гэж нярайн хүй таслагдсаны дараа ихэстэй залгаа хэсгээс тайран авсан хүйн судсан багцыг;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 55 гишүүн буюу 59,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.19 дэх заалт нэмэх:

“4.1.19.“үндэсний хүлээх жагсаалт” гэж эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгуулах шаардлагатай иргэдийг эрхтэн, эд, эс, цусны бүлгээр ангилан, эмнэл

зүйн үнэлгээ, шалгуур үзүүлэлтээр эрэмбэлэн бүртгэсэн жагсаалтыг.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 58 гишүүн буюу 62,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

13.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “сайн дурын,” гэсний дараа “аливаа дарамт шахалт, бусдын нөлөөнд автахгүй” гэж нэмж, мөн зүйлийн 5.1.6 заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 56 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

14.Төслийн хоёрдугаар бүлгийн гарчгийн “ДОНОРЫГ СОНГОХ” гэснийг “ДОНОРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 57 гишүүн буюу 61,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “эрхтэн, эд, эс” гэсний өмнө “энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллагаас” гэж нэмж, мөн заалтын “холбогдох эрх бүхий эрүүл мэндийн байгууллагаас” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцож, 56 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

16.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “холбогдох журам, зааврын дагуу” гэснийг хасаж, мөн зүйлийн 6.1.3 дахь заалтын “, хүүхэд” гэснийг “гаргах бөгөөд, хүүхэд, эрх зүйн бүрэн чадамжгүй иргэн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёолол санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 58 гишүүн буюу 62,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

17.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Эрхтэн, эд” гэсний дараа “, эс” гэж нэмж, 6.2.1 дэх заалтын “тус улсад” гэснийг хасаж, мөн заалтын “гэрлэгчид дундаасаа” гэсний дараа “төрсөн” гэж, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын “гадаад улсын иргэн,” гэсний дараа “харьяалалгүй хүн” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсгийн ахлагч Баярбаатар гишүүн үг хэлье.

Б.Баярбаатар: Ажлын хэсгээс энэ заалтыг гүйцээн боловсруулах чиглэл хүсье. Энэ гадаад улсын иргэнд бэлгийн хэсгийг шилжүүлэн суулгахтай холбоотой асуудлаар ажлын хэсэг дээр дахиж нэг нягтлах зайлшгүй шаардлага үүссэн учраас чиглэл өгнө үү.

С.Бямбацогт: Энэ санал хураалтыг хураахгүй хойшлууллаа. Гүйцээн боловсруулж, эцсийн хэлэлцүүлэгт оруулж ирэхийг Ажлын хэсэг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд даалгалаа.

18.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “яс үндэс, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, боловсрол харгалзахгүйгээр иргэн амьдралын чанараа сайжруулах, эрүүл мэндээ хамгаалуулах” гэснийг “үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол харгалзахгүйгээр хүн амьдралын чанараа сайжруулах, эрүүл мэндээ хамгаалах” гэж, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтын “хангах” гэснийг “сайжруулах” гэж өөрчилж, мөн заалтын “тусламж, үйлчилгээ” гэсний өмнө “эрүүл мэндийн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 62,4 саналаар энэ санал дэмжигдлээ.

19.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “гэрлэгчид дундаасаа” гэсний дараа “төрсөн” гэж нэмж, мөн зүйлийн 8.1.4 дэх заалтын “сайн дурын үндсэн дээр” гэснийг “сайн дураар” гэж өөрчилж, мөн заалтын “сэтгэцийн эмгэггүй” гэсний өмнө “хөгжлийн бэрхшээлгүй хүн болон” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн орсноос 56 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

20.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “хүний эрүүл мэндийг хамгаалах, амьдралын чанарыг дээшлүүлэхэд зориулан эрхтэн, эд, эсээ өгөхдөө” гэнийг, мөн зүйлийн 8.1.6 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцож, 58 гишүүн буюу 62,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

21.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.2.Эсийн донор нь дараах шаардлагыг хангасан байна:

8.2.1.эсийн донорт насны дээд, доод хязгаар заахгүй, хэрэв бэлгийн эсийн донор бол 18 насанд хүрсэн байна;

8.2.2.хүүхдээс ясны хэм, захын цус авахдаа 14 хүртэлх настай бол хүүхдийн хүсэл зоригийг хүндэтгэн эцэг, эх болон асран хамгаалагчийн, 14-өөс дээш настай бол өөрийнх нь болон эцэг, эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн зөвшөөрлийг бичгээр авна;

8.2.3.эсийн донор нь гэр бүлийн гишүүн эсхүл сайн дурын донор байж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 93 гишүүн санал хураалтад орсноос 61 гишүүн буюу 65,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

22.Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.3 дахь хэсэг нэмэх:

“8.3.Хүүхдээс ясны хэм, хүйн цус, хүйн эд, захын цуснаас бусад эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах зориулалтаар авахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 62,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

23.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын “яс үндэс, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ,” гэснийг “үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол,” гэж, мөн зүйлийн 9.1.2 дахь заалтын “үйлчилгээ, түүнтэй холбоотой бусад мэдээ” гэснийг “үйлчилгээний талаар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 93 гишүүний санал хураалтад оролцсоноос 61 гишүүн буюу 65,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

24.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “амьдралын чанарыг хангах тасралтгүй тусламж үйлчилгээг” гэснийг “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг

чанар,” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.1.4 дэх заалтын “мөрдөх” гэсний өмнө “дагаж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 59 гишүүн буюу 63,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

25.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын “хонжоо,” гэснийг “олох зорилгоор” гэж өөрчилж, “авах,” гэсний дараа “өгөхийг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 61 гишүүн буюу 65,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

26.Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.1.6, 9.1.7 дахь заалт тус тус нэмэх:

“9.1.6.эрхтэн, эд, эсээ бусдад шилжүүлэн суулгах явцад өөрийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байх эрхээр хангагдах;

9.1.7. эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний явцад технологийн заавар зөрчигдсөний улмаас донорын эрүүл мэндэд хохирол учруулсан нь тогтоогдсон бол эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгасан буруутай этгээд, байгууллагаар хохирлоо нөхөн төлүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор. санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 57 гишүүн буюу 61,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

27.Төслийн 10 дугаар зүйлийн гарчгийн “донорт тавигдах шаардлага” гэснийг “донорыг ирүүлэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 10.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.Тархины үхэл тодорхойлох мэргэшсэн багаар тархины үхэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд амьгүй донороос эрхтэн, эд, эс авна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 93 гэсэн санал хураалтад оролцсоноос 58 гишүүн буюу 62,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

28.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “, дүү” гэсний дараа “төрлийн хүн, садангийн хүн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 62,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

29.Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийн “Гадны нөлөөтэй” гэснийг “Гэмт хэргийн улмаас тархины үхэлтэй болох нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон” гэж, мөн хэсгийн “эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан” гэсний дараах “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн хэсгийн “хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын” гэсний дараах “гишүүд” гэснийг “гишүүн, Улсын Ерөнхий прокурор” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 57 гишүүн, 93 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 61,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

30.Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.6 дахь хэсэг нэмэх:

“10.6.Амьгүй донорт насны хязгаар заахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 56 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

31.Төслийн 11 дүгээр зүйлийн гарчгийн “болохоо” гэснийг “болох хүсэлтээ” гэж өөрчилж, мөн зүйлийн 11.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.21 насанд хүрсэн Монгол Улсын иргэн энэ хуулийн 4.1.3-т заасан донор болох хүсэлтээ төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан гаргаж донорын цахим үнэмлэх, эсхүл Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад өөрийн биеэр хүсэлт гарган баталгаажуулж донорын үнэмлэх авч болно.” Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 63,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяагийн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 133 дугаар сургуулийн 9Д ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт хүүхэд багачууд та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс сурлагад нь өндөр амжилт, амьдралд нь эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

32.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн дугаарыг “11.3” болгон өөрчилж, мөн хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.3.Татгалзах хүсэлтээ төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан, эсхүл Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад өөрийн биеэр хүсэлт гарган баталгаажуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 56 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

33.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн дугаарыг “11.2” болгон, мөн хэсгийн “гэрчилгээ” гэснийг “үнэмлэх” гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн “татгалзах эрхтэй.” гэсний өмнө “хугацаа хамаарахгүй” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 59,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

34.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “8.1-д заасан шаардлага хангасан амьд донороос эрхтэн, эд, эсийг авна” гэснийг “8.1, 8.2-т заасан шаардлага хангасан байна” гэж, мөн зүйлийн 12.2 дахь хэсгийн “энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан донороос авах бөгөөд зөвшөөрснөөс бусад эрхтэн, эд, эсийг авахыг хориглоно” гэснийг “энэ хуулийн 10.2-т заасан зөвшөөрлийг авна. Зөвшөөрснөөс бусад эрхтэн, эд, эс авахыг хориглоно.” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 56 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

35.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “тусламж, үйлчилгээг үзүүлнэ” гэснийг “үйл ажиллагааг зохион байгуулна” гэж өөрчилж, мөн зүйлийн 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрлийн дагуу энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн

байгууллагын эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах мэргэжлийн баг эрхтэн, эд, эс авах эмнэлгийн тусламж, үйлчилгээг гүйцэтгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 53 гишүүн буюу 57 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

36.Төслийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн “донороос” гэснийг “донорыг бүртгэх,” гэж, мөн хэсгийн “эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан” гэсний дараах “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн “хадгалах,” гэсний дараа “хамгаалах,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 61,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

37.Төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн дугаарыг “12.3” болгож, мөн хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.3.Энэ хуулийн 11.1-д заасан амьгүй донороос эрхтэн, эд, эс авахдаа гэр бүлийн 3 хүртэл гишүүнд урьдчилан танилцуулах бөгөөд энэ хуулийн 10.2-т заасан зөвшөөрлийг авахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 61,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

38.Төслийн 13 дугаар зүйлийн гарчгийн “Эрхтэн, эд, эс шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах” гэснийг “Био банк байгуулах, ашиглах үйл ажиллагаа” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь үндэсний хэмжээнд оношилгоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэх, хяналт хийх зориулалттай нэгдсэн био банктай байна.”-Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 62,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

39.Төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 13.1-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэх” гэснийг “Био банк байгуулах, ашиглах” гэж, мөн хэсгийн “байгууллагын саналыг үндэслэн” гэсний өмнөх “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 52 гишүүн буюу 55,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

40.Төслийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.3, 13.4 дэх хэсэг нэмэх:

“13.3.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож байгаа эрүүл мэндийн байгууллага нь эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэх био банктай байж болно.

“13.4.Био банкиг эд, эсийг цуглуулах, шинжлэх, өсгөвөрлөх, боловсруулах, хадгалах, бүртгэх, тээвэрлэх, устгах, шаардлагатай үед эмчилгээ, судалгааны зорилгоор тохирох эд, эсээр реципиент эмнэлэг болон судалгаа, шинжилгээний байгууллагыг хангах зориулалтаар ашиглана.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье

гэсэн томьёоллоор санал хураалт санал. Хураалтад 93 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 61,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

41.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “шаардлага хангасан” гэснийг хасаж, мөн хэсгийн “импортолж болно” гэсний өмнө “энэ хуулийн 14.3-т заасан журамд заасны дагуу” гэж нэмж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “хариуцсан” гэснийг “эрхэлсэн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 59,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

42.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 15.2 дахь хэсгийг хасах:

“15.1.энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллага нь донор, реципиентийн эрхтэн, эд, эсийн тохироог үзэх, донороос авсан эрхтэн, эд, эсийг шинжлэх, боловсруулах, шилжүүлэн суулгах мэс засал, эмчилгээг гүйцэтгэх мэргэжлийн багтай байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 56 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

43.Төслийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.5, 15.6 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 52 гишүүн буюу 55,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

44.Төслийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн “13.3-д” гэснийг “12.5-д” гэж, мөн зүйлийн 15.8 дахь хэсгийн “Донор бэлгийн эсийг” гэснийг “Бэлгийн эсийг” гэж, мөн хэсгийн “болох бөгөөд холбогдох журмыг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.” гэснийг “болно.” гэж, мөн зүйлийн 15.9 дэх хэсгийн “энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллага эрхэлнэ.” гэснийг “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.4-т заасан эрүүл мэндийн байгууллага гүйцэтгэж болно.” тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 54 гишүүн буюу 58,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

45.Төслийн 15 дугаар зүйлийн 15.10, 15.11 дэх хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“15.10.холбогдох эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр өөрөө жирэмслэх, ураг тээх, хүүхэд төрүүлэх чадваргүй нь тогтоогдсон эмэгтэйд тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болохыг зөвшөөрөх бөгөөд бусад тохиолдолд тээгч эх ашиглахыг хориглоно.

15.11.Бэлгийн эс ашиглах, үр хөврөлийг шилжүүлэн суулгах, тээгч эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ энэ хуулийн 12.5-д заасан журмыг баримтлах бөгөөд талуудын хооронд байгуулах гэрээний загварыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 93 гишүүний санал хураалтад оролцсоноос 53 гишүүн буюу 57 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

46.Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.13, 15.14 дэх хэсэг нэмэх:

“15.13.Нэг донорын бэлгийн эсийг зөвхөн нэг удаагийн амьд төрөлтөд ашиглахыг зөвшөөрнө.

15.14.Үр хөврөлийг эцэг, эхээс нь бусад хүмүүст ашиглахыг хориглоно.”
Ажлын хэсэг Баярбаатар гишүүний микрофон өгье.

Б.Баярбаатар: Энэ дахиад л нэг бэлгийн эстэй асуудал ярих гээд байна. Энэ өмнө мөрдөгдөж байсан хууль дээр бол нэг бэлгийн эсээс нэг амьд төрөлтөд ашигладаг байсан. Одоо шинжлэх ухаан хөгжөөд нэг бэлгийн эсээс бол 2, 3, 4 ашиглах боломж бүрдсэн учраас энэ хязгаарлалтыг нэмэгдүүлэх үүднээс энийг дахиж гүйцээн боловсруулах чиглэл авъя.

С.Бямбацогт: 46 дахь саналыг гүйцээн боловсруулахаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, ажлын хэсэгт чиглэл өгье.

47.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “байх бөгөөд мэдээллийн аюулгүй байдал технологийн нууцлал, найдвартай байдлыг хангасан” гэснийг хасаж, мөн хэсгийн “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн зүйлийн 16.2 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн” гэснийг “эрүүл мэндийн байгууллага” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 53 гишүүн буюу 57 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

48.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 49, 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 51 гишүүн буюу 54,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүд жоохон анхааралтай санал хураалтдаа оролцоно уу. Танхимд хангалттай олон гишүүн байна. Зарим гишүүдийн санал бас эсрэг гарч байна шүү.

49.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “шилжүүлэн суулгах” гэсний дараа “тусламж, үйлчилгээний” гэж, мөн заалтын “баримтлах бодлого,” гэсний дараа “төлөвлөлт, арга хэмжээ,” гэж тус тус нэмж, мөн заалтын “төрөөс” гэснийг хасах. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. 93 гишүүн санал хураалтад оролцсоноос 50 гишүүн буюу 53,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

50.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалтын “ажиллагааг зохион байгуулах,” гэснийг “ажиллагаа,” гэж өөрчилж, мөн зүйлийн 18.1.3, 18.1.6 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 47 гишүүн буюу 50,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүд суудалдаа сууя. Энэ саналууд бас яах гээд байна.

50.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалтын “ажиллагааг зохион байгуулах,” гэснийг “ажиллагаа,” гэж өөрчилж, мөн зүйлийн 18.1.3, 18.1.6 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал. Хураалт санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 58,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

51.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг 19 дүгээр зүйлийн 19.3.4 дэх заалт болгон шилжүүлж, мөн заалтын “4.1.8-д заасан” гэсний өмнө “4.1.7,” гэж нэмж, мөн заалтын “механизм” гэснийг “систем” гэж өөрчилж, мөн заалтын “эмнэлгийн мэргэжилтнийг” гэсний өмнөх “эмч,” гэснийг хасах. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. 94 гишүүн санал хураалтад оролцсоноос 54 буюу 57,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

52.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.9 дэх заалтыг 19 дүгээр зүйлийн 19.3.5 дахь заалт болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.3.5.энэ хуулийн 4.1.7, 4.1.8-д заасан эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээг батлах, хэрэгжилтийг хянах, цуцлах.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 51 гишүүн буюу 54,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

53.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.10 дахь заалтыг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмэх:

“18.2.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын бүтэц, дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 94 гишүүн санал хураалтад оролцсоноос 55 гишүүн буюу 58,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 53.

54.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.1 дэх хэсэг нэмэх:

“19.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан тусгай мэргэжлийн төв байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 94 гишүүн санал хураалтад оролцсоноос 62 гишүүн буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

55.Төслийн 19 дүгээр зүйлийн нэрийн “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн зүйлийн 19.1.2 дахь заалтын “12.5-д заасан журмын дагаж мөрдөнө.” гэснийг “12.5. 13.2-т заасан журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавих.” гэж, мөн зүйлийн 19.1.3 дахь заалтын, мөн зүйлийн 19.4.4 дэх заалтын “эмчилгээ,” гэснийг “тусламж,” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 19.1.4, 19.2.3, 19.3.4, 19.3.5 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 94 гишүүн санал хураалтад оролцсоноос 56 гишүүн буюу 59,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

56.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2.2 дахь заалтын “эмч эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, багийн чадавхийг дээшлүүлэх,” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 19.2.3 дахь хэсэг нэмэх:

“19.2.3.эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, багийн чадавхыг дээшлүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 94 гишүүн санал хураалтад орсон 57 гишүүн буюу 60,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

57.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.3.1 дэх заалтын “Эрүүл мэндийн тухай хуулийн” гэсний дараах “15.1.4, 15.1.5,” гэснийг, мөн заалтын “15.1.13-т заасан” гэсний өмнөх “15.1.12,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 94 гишүүн санал хураалтад оролцсоноос 51 гишүүн буюу 54,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

58.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.4.1 дэх заалтын “донор эмнэлгийн,” гэснийг хасаж, мөн заалтын “ёс зүйн хороодтой” гэсний өмнө “мэргэжил,” гэж нэмж, мөн зүйлийн 19.4.2 дахь заалтын “Эрүүл мэндийн тухай хуулийн 26.5-д заасан ёс зүйн хороонд хүргүүлэх” гэснийг “шийдвэрлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 94 гишүүн санал хураалтад оролцсоноос 59 гишүүн буюу 62,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

59.Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн,” гэснийг, мөн хэсгийн “байгууллагын бүтцэд” гэсний өмнөх “байгууллага байх ба тус” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 94 гишүүн санал хураалтад оролцсоноос 59 гишүүн буюу 62,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

60.Төслийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “4.1.6” гэснийг “4.1.7” гэж, мөн хэсгийн “төрийн захиргааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж, мөн хэсгийн “мэдээлнэ.” гэснийг “мэдээлж, улирал тутам тайлагнана.” гэж тус тус өөрчилж, “донорын талаарх мэдээллийг” гэсний өмнөх “амьд, амьгүй” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 62,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

61.Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дахь заалтын “хүндрэл, сөрөг нөлөөллөөс” гэснийг “эрсдэл, хүндрэлээс” гэж, мөн зүйлийн 20.2.2 дахь заалтын “энэ хуулийн 20-д” гэснийг “энэ хуулийн 19-д” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 20.3.6 дахь заалтын “эрчимт эмчилгээг” гэсний өмнө “амин чухал эрхтний үйл ажиллагааг дэмжин,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 20.3.8 дахь заалт тус тус нэмэх:

“20.3.8.хуульд заасан бусад.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 60,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

62.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэнд дараах үйл ажиллагааг хориглоно:

21.1.1.донор болон реципиент, тэдний гэр бүлийн гишүүн, тэдгээрийн хамаарал бүхий этгээдээс аливаа хэлбэрээр урамшуулал, шан харамж авах;

21.1.2.албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж, бусдад давуу байдал олгох;

21.1.3.Шинжлэх ухааны бус зорилгоор судалгаа, шинжилгээ, туршилт хийх;

21.1.4.хуульд заасан бусад.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 60,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

63.Төслийн 22, 23 дугаар зүйлийг нэгтгэн 22 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22 дугаар зүйл. Амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмж болон амьд донорт үзүүлэх дэмжлэг

22.1.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг холбогдох сангаас олгоно.

22.2.Амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, рашаан сувилалд сувилуулах журмыг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

22.3.Хуульд заасан бусад.”. Ажлын хэсгийн ахлагч Баярбаатар гишүүний микрофон өгье.

Б.Баярбаатар: Энэ дээр бас гүйцээн боловсруулах чиглэл хүсье. Ариунзаяа гишүүний түрүүн гаргасан саналыг хуульд нийцүүлэх, энэ тэтгэмж оршуулгын тэтгэмжийг холбогдох сангаас олгоно гэснийг яг тэр сангийн хуульд нийцүүлсэн тодорхой нэршилтэй нь оруулах нь зөв гэж үзэж байгаа учраас ажлын хэсэг эндээс гүйцээн боловсруулах чиглэл хүсье.

С.Бямбацогт: Гүйцээн боловсруулах чиглэлийг ажлын хэсэг, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд өгч байна. Энэ саналаа сайжруулъя.

64.Төслийн 24 дүгээр зүйлийг 23 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23 дугаар зүйл. Санхүүжилтийн тогтолцоо

23.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээтэй холбоотой санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, реципиентийн төлөх төлбөр, хандив, тусламж, дэмжлэг, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

23.2.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлж болно.

23.3.Энэ хуулийн 23.2-т заасан тусламж, үйлчилгээний жагсаалт, төлбөрийн жишиг хэмжээг Эрүүл мэндийн тухай хуулийн 24.3-т заасны дагуу тогтооно.

23.4.Дархлаа дарангуйлах эмийн эмчилгээний санхүүжилтийг улсын төсвөөс хариуцах бөгөөд худалдан авалт, тасралтгүй бэлэн байдал, хуваарилалт, хяналтын асуудлыг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар зохицуулна.

23.5.Хүүхдэд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний төлбөрийг Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.11-т заасны дагуу шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 94 гишүүн санал хураалтад оролцоноос 55 гишүүн буюу 58,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

65.Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 94 гишүүн санал хураалтад оролцоноос 56 гишүүн буюу 59,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын Монгени сургуулийн 11Е ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилтыг амьдралд нь эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсье. Бүгдээрээ онц сураарай.

66.Зарчмын зөрүүтэй 63 дугаар санал буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг холбогдох сангаас олгох санал дэмжигдсэнтэй холбогдуулан хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулах. Ажлын хэсгийн ахлагч Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: 63 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл авсантай холбогдуулаад энэ 66 дугаар саналыг бас гүйцээн боловсруулах чиглэл авъя.

С.Бямбацогт: 63 дахь санал гүйцээн боловсруулах хойшлогдсонтой холбогдуулж Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Найруулгын санал. 1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.16 заалтын “аав, ээжийг” гэснийг “эцэг, эхийг” гэж, төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын “суулгах” гэснийг “суулгуулах” гэж, төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “доор дурдсан” гэснийг “дараах” гэж, төслийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “шаардлагад нийцсэн” гэснийг “шаардлага хангасан” гэж тус тус өөрчлөх;

2.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь заалтын “эрүүл мэндийн байгууллага” гэсний өмнөх “заасан” гэснийг, төслийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалтын “талаарх” гэснийг, мөн зүйлийн 19.4.4 дэх заалтын “ухуулан” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 94 гишүүн

санал хураалтад оролцсоноос 60 хувийн, 60 гишүүн буюу 63,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр.Хүний хөгжил,, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал.

1.Хуулийн төслийн нэрийн “ЭРХТЭН, ЭД, ЭС” гэсний өмнө “ХҮНИЙ” гэж нэмэх. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 63,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Байж байгаарай. Энэ санал хураалт дуусчихлаа тийм үү?

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дагасан хуулиуд. Нэг.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Нэг.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дугаарыг “2” болгож, мөн заалтын 6.19 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 94 гишүүн санал хураалтад оролцсоноос 60 гишүүн буюу 63,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын дугаарыг “1” болгож, мөн заалтын 6.1.4 дэх заалтын “, холбогдох баримт бичиг” гэснийг “болон хоорондын байгуулсан гэрээ” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 62 гишүүн буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 94 гишүүн санал хураалтад оролцсоноос 63 гишүүн буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Нэг.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал.

Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж, төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл тус тус нэмж, төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгох:

“2 дугаар зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.18 дахь заалтын “Донорын тухай хуулийн 3.1.2, 3.1.4-т” гэснийг “Хүний эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн 4.1.2, 4.1.3, 4.1.5-д” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 63 гишүүн 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хураалт явуулж дууслаа.

Манай Их Хурлын гишүүн Чинбүрэн, Ариунзаяа, Алдаржавхлан, Батсүмбэрэл нарын гишүүд санаачилж, Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар нарын гишүүд ажлын хэсэгт ажиллаж, өнөөдөр ард иргэдийн амьдралд маш чухал үр өгөөжөө өгөх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Хууль санаачилсан гишүүд болон ажлын хэсэгт ажилласан гишүүддээ нийт гишүүдийнхээ өмнөөс талархлаа

илэрхийлье. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

15.15 цаг

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжлэв.

Дараагийн асуудалдаа оръё. ХАҮТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хууль санаачлагчаас болон Байнгын хорооны санал, дүгнэлтээс асуулт асууж, хариулт авч дууссан. Үг хэлж дууссан. Одоо санал хураалт явуулна. Гишүүд үг хэлж дууссан. Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн үг авна, үг микрофон өгье.

Х.Тэмүүжин: Д.Энхтүвшин нарын гишүүдийн санаачилсан 2025 оны 12 сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн тус хуультай холбоотойгоор хэд хэдэн асуудлууд хөндөгдөж байгаа юм. 1 дүгээрт, АН-ын үзэл баримтлал, АН-ын мөрийн хөтөлбөрт тусгагдсан энэ өөрийн удирдлага, өөрийн зохицуулалт болон төрийн хязгаарлагдмал оролцоотой холбоотой асуудлуудыг хөндсөн. Энэ асуудлаар тодорхой хэмжээний судалгаа, тооцоо болон мэдээлэл авах хэрэгцээ шаардлага бий болсон. Ийм хуулийн төсөл өргөн баригдсан. Бид бол үзэл баримтлалынхаа хувьд бол энэ хуультай бол олон зүйл дээр санал нэгдэж байгаа боловч цааш тодорхой мэдээлэл авах хэрэгцээ шаардлагууд байна. Тийм учраас 2026 оны 4 сарын 27-ны өдөр хуралдах намынхаа бүлгийн хурлаар бид ХАҮТ-ыг сонсох, энэ хуулийн үзэл баримтлал болон одоо ХАҮТ дээр байгаа санаа бодолд нийцэж байгаа эсэх, зарим дурдагдсан мэдээлэл хэр бодитой эсэх гэх мэтчилэн нэлээн олон асуудлууд тодруулах хэрэгцээ шаардлага байгаа учраас бүлэг хуралдаж, саналаа нэгтгэх болон мэдээлэл, нэмэлт мэдээлэл авах энэ хэрэгцээ шаардлагын үүднээс 5 өдрийн завсарлага авч байгаа юм.

С.Бямбацогт: Чухал хууль учраас бүлэг дээр мэдээлэл авах нь зөв байх. Тийм болохоор АН-ын бүлэгт ирэх Пүрэв гараг хүртэлх 5 хоногийн завсарлага өглөө. Пүрэв гараг 10 цагаас санал хураалтаар эхэлнэ шүү, тэр хүртэл өглөө шүү. Пүрэв гаргийн 10 цагт санал хураалтаар эхэлнэ, тэр хүртэл завсарлага өгч байна.

15.17 цаг

***Гурав. “Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

3 дахь асуудалдаа оръё. Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал. Одоо санал хураалт явна шүү гишүүдээ. Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Очирбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээрээ дамжуулан Эдийн засгийн байнгын хорооны харьяан дахь Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдөж, Инновац, цахим бодлого, хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах тухай саналаа ирүүлснийг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүний өөрийнх нь хүсэлт болон УИХ дахь АН-ын бүлгийн саналыг хэлэлцэх үед хуралдаанд оролцсон гишүүдийн зүгээс асуулт асууж, санал хэлээгүй бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүнийг Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнд оруулахыг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь уг саналыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүнийг Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнд оруулах тухай Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

С.Бямбацогт: Очирбат гишүүнд баярлалаа. Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Түрүүн 63 гишүүн байсан, одоо санал хураалтад 49 гишүүн бэлэн болсон байна. Хурууны хээгээ уншуулж, санал хураалтдаа бэлдэнэ үү гишүүдээ. Санал хураалт явуулъя.

Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 52 гишүүн, Баасанжаргал гишүүн нэмэгдэж байна, Цогтбаатар гишүүн Дамдины Цогтбаатар гишүүн, Батсуурь гишүүн нэмэгдэж байна, Жамбын Батсуурь гишүүн, Аюушийн Ариунзаяа гишүүн, ингээд 56 гишүүн дэмжиж, олонх дэмжсэн тул энэ тогтоолын төслийг баталлаа. Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.5 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүнийг Тогтвортой хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг 2026 оны 4 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

15.22 цаг

Дөрөв.Зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай

Дараагийн асуудал Зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ. ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг ТББХ 2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд, дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

ТББХ-ны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг Байнгын хорооны даргыг сонгохдоо УИХ-д сонгогдсон, ажилласан хугацаа, туршлагыг харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээс сонгох гэж заасныг харгалзан ТББХ-ны даргад Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхланг нэр дэвшүүлж, хэлэлцүүллээ.

Болдын Жавхлан 1975 онд Дархан хотод төрсөн, ам бүл 3, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1990 онд Дархан хотын 17 дугаар дунд сургууль, 92 онд Сүхбаатар аймгийн 1 дүгээр дунд сургууль, 97 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг банкны эдийн засагч мэргэжлээр, 2008 онд АНУ-ын Калифорнийн их сургуулийн Риверсайдын хэлний сургууль, 2009 онд АНУ-ын Индианагийн их сургуулийг тус тус төгссөн.

1997-гоос 99 онд Монголбанкны Хяналт шалгалтын газрын хянан шалгагч, 1990-ээс 2000 онд Монголбанкнаас Хаан банканд бүрэн эрхт төлөөлөгч, эрх хүлээн авагч, 2000-аас 2004 онд Монголбанкны Хяналт шалгалтын газрын ахлах хянан шалгагч, 2004-өөс 2006 онд Худалдаа, хөгжлийн банкны /ХХБ/ үйл ажиллагаа эрхэлсэн захирал, 2006-аас 2007 онд ХХБ-ны дэд ерөнхийлөгч, 2010-аас 2016 онд Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч, 2016 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр 3 удаа сонгогдон ажиллаж байна. 2016-аас 20 онд Монгол Улсын Их Хурлын Нутгийн удирдлагын дэд хорооны дарга, 2020-оос 21 онд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 2021-ээс 2026 онд Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Сангийн сайдаар тус тус ажилласан.

ТББХ-ны даргад Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхланг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

С.Бямбацогт: Баярбаатар гишүүнд баярлалаа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвсүрэнгийн Наранбаяр танилцуулна. Таныг индэрт урьж байна.

П.Наранбаяр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг гаргасныг та бүхэнд танилцуулж байна.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийг баримтлан Байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзоригийг нэр дэвшүүлж, хэлэлцүүллээ.

Пүрэвжавын Ганзориг нь 1984 онд төрсөн, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1991-ээс 2001 онд Хөвсгөл аймгийн 10 жилийн дунд сургууль, 2001-ээс 2005 онд МУИС-ийн Математик, компьютерын сургуулийг тус тус төгссөн. Математикч мэргэжилтэй. 2005-аас 2008 онд Номин даатгал компанид эрсдэлийн шинжээч, актуарч, 2008-аас 2011 онд тус компанийн гүйцэтгэх захирал, 2010-аас 2013 онд Монголын даатгалын холбооны ерөнхийлөгч, 2018 оноос Үндэсний стратегийн хүрээлэнгийн удирдах зөвлөлийн гишүүн, 2016-аас 2020 онд Их эрин холдинг компанид ТУЗ-ийн дарга, 2020-оос 2024 онд НИТХ-ын төлөөлөгч, мөн онд Хан-Уул дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, бүлгийн дарга, 2015 оноос ХҮН намын удирдах зөвлөлийн гишүүн, 2016-аас 2020 онд ХҮН намын хариуцлагын ерөнхий хорооны дарга, 2021-ээс 2026 онд ХҮН намын ЕНБД, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2025 оноос УИХ дахь ХҮН намын зөвлөлийн даргаар тус тус ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа илэрхийлээд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын улсын төсөв, цалингийн асуудлаар хамгийн түрүүнд юу хийх талаар болон ХҮН намын гишүүний хувьд ямар бодлого баримталж ажиллах чиглэл тус намаас өгсөн талаар асуулт асууж, хариулт авав.

Улсын Их Хурлын гишүүн Зулпхар зохих түвшний улс төрийн ажлын болоод орон нутагт ажиллаж байсан туршлагатай, бодлогын тодорхой санал шийдэл гаргадаг гишүүн тул Байнгын хорооны даргаар ажиллахыг дэмжиж байгаагаа илэрхийлээд Байнгын хорооноос Боловсролыг дэмжих жилийн хүрээнд ЗГ-т чиглэл өгсөн тогтоолыг баталсан бөгөөд хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг 2027 оны улсын төсвийн санал боловсруулахаас өмнө буюу 5 дугаар сард багтаан сонсох, түүнчлэн Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны гишүүд чуулганы завсарлагааны хугацаанд шинжлэх ухааны байгууллагуудаар очиж ажиллан санал, зөвлөмж гаргасныг Байнгын хороогоор хэлэлцэн шийдвэрлэхэд анхаарах талаар үг

хэлэв. Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалаа Байнгын хорооны эрхлэх асуудал болох боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, соёлын салбар бол хүний төлөө ажилладаг салбарт бол хүний хөгжил гэж нэрлэсэн нь маш оновчтой зөв зарчим байсан. Энэхүү салбар хоорондын уялдааг ханган ажиллахад Байнгын хорооны үүрэг чухал бөгөөд зөвхөн салбарын төлөө биш, хүний хөгжлийг тодорхойлдог эдгээр салбарыг цогцоор нь харж ажиллах талаар, Байнгын хорооны даргаар ажиллаж байх хугацаандаа ЭМД-ын шинэчлэлийн асуудалд анхаарал хандуулж ажиллахын зэрэгцээ хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн асуудалд санаачилга гарган Ажлын хэсэг байгуулж, үр дүнтэй ажилласан. Байнгын хороо бол парламентын мэргэшсэн гол бүтэц, хүчтэй цэг бөгөөд Байнгын хорооны үйл ажиллагаа сайн байвал төрийн бодлого сайн байх учраас гишүүд өөрсдийн итгэл үнэмшил, мэргэшсэн чиглэлээрээ санаачилгатай ажиллаж, зохих газарт нь нэгдэн, аль болох сэдэв давхцалгүй олон асуудлыг шийдвэрлэхийн төлөө ажиллах талаар үг хэлсэн болно.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзоригийг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 94,1 хувийн саналаар дэмжсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Наранбаяр гишүүнд баярлалаа. Нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Алга байна. Байнгын хороодын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлдсэн байх. Гишүүд санал хураалтад. Санал хураалт явуулъя.

1.Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхланг сонгохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 61,7 хувийн саналаар, Пүрэвдорж гишүүн дэмжсэн. Ингээд 59 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзоригийг сонгохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 94 гишүүн санал хураалтад оролцсоноос 61 гишүүн буюу 64,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Байнгын хорооны даргаар сонгох саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын тогтоол. Зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзоригийг Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар, Улсын Их

Хурлын гишүүн Болдын Жавхланг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар тус тус сонгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалааг Монгол Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргын, Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

15.33 цаг

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Чуулганы хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Маргааш чуулган 10 цагаас эхэлнэ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА